

СОЁЛ ЭРДЭМ ДЭЭД СУРГУУЛЬ

Оюутны гарын авлага

2025-2026 оны хичээлийн жил

Улаанбаатар хот
2025 он

Гарын авлага боловсруулсан: Д.Эрдэнэчимэг, Д.Энхчимэг
Хэвлэлийн эхийг бэлтгэсэн: Д.Шинэбаатар

Хаяг:
Embassy One
4,5 давхар
Сүхбаатар дүүрэг 1-р хороо
Улаанбаатар
Утас: (+976)-70118584, 326947
Веб хаяг: <http://www.soyolerdem.edu.mn>

ГАРЧИГ

СЭДС-ИЙН	
СЭДС-ИЙН АЛСЫН ХАРАА	4
СЭДС-ИЙН ЭРХЭМ ЗОРИЛГО.....	4
СЭДС-ИЙН ҮНЭТ ЗҮЙЛ	4
СЭДС-ИЙН УРИА.....	4
СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛДАГ ЖУРМУУД.....	8
➤ ОЮУТНЫ МЭДЛЭГИЙН ҮНЭЛГЭЭ	8
➤ 6. Сургалтын төлөвлөгөө, хичээлийн стандарт	11
➤ СЭДС-ИЙН ОЮУТНЫ ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ ЖУРАМ	12
СОЁЛ ЭРДЭМ ДЭЭД СУРГУУЛИЙН ОЮУТАН ТӨГСГӨХ ЖУРАМ.....	18
➤ Хоёр. Дипломын төсөл, ажилд өгөх үэлгээ.....	19
СУРГУУЛИЙН БҮТЭЦ.....	40
МЭРГЭЖЛИЙН ТЭНХИМҮҮД,	43
СУРГАЛТ ЯВУУЛЖ БУЙ ХӨТӨЛБӨРҮҮД	43
➤ ЯПОН СУДЛАЛЫН ТЭНХИМ	43
• ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	43
• СУРГАЛТ ЯВУУЛЖ БАЙГАА ХӨТӨЛБӨРҮҮД.....	44
• ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	60

СОЁЛ ЭРДЭМ ДЭЭЛ СУРГУУЛЬ

СЭДС-ИЙН АЛСЫН ХАРАА

ЯПОН ХЭЛ, СОЁЛ, ПРОГРАММ ХАНГАМЖИЙН ХОСОЛСОН СУРГАЛТ, ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААГААР МОНГОЛ УЛСДАА ТЭРГҮҮЛЭГЧ СУРГУУЛЬ БОЛНО.

СЭДС-ИЙН ЭРХЭМ ЗОРИЛГО

МОНГОЛ БОЛОН ЯПОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛД ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨГДӨХҮЙЦ МЭРГЭЖИЛТЭН БЭЛТГЭНЭ.

СЭДС-ИЙН ҮНЭТ ЗҮЙЛ

- С - СОЁЛ УЛАМЖЛАЛАА ДЭЭДЭЛЖ,
- Э - ЭРДЭМ МЭДЛЭГИЙГ ЭРХЭМЛЭН,
- Д - ДАЯАРШСАН ХӨГЖЛИЙГ ХҮНДЭТГЭЖ,
- С - СУДАЛГААНЫ ТӨГӨЛДӨРШИЛД ТЭМҮҮЛНЭ

СЭДС-ИЙН УРИА

ЧАНАРТАЙ СУРГАЛТ - ЯПОН СОЁЛ

СУРГУУЛИЙН ТОВЧ ТҮҮХ

1993 онд Япон хэлний “Соёл” дамжааг байгуулсан нь одоогийн СОЁЛ ЭРДЭМ дээд сургуулийн үндэс суурь нь болсон байдаг. 1996 онд Япон улсын 100 хувийн хөрөнгө оруулалттай Соёл Эрдэм Дээд Сургууль болон өргөжин тэлж, “Япон хэлний багш, орчуулагч” мэргэжлээр элссэн 60 оюутантайгаар сургалтын үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн юм.

БМИҮЗ-өөс 2003, 2010, 2020 онуудад тус тус амжилттай магадлан итгэмжлэгдсэн байгууллага юм. Одоо 2025 онд 4 дэх удаагаа магадлан итгэмжлүүлэх ажиллагаа явагдаж байна.

Өдгөө Гадаад хэлний орчуулагч, Олон улс, орон судлал, Эдийн засаг, Аялал жуулчлал, Программ хангамж гэсэн 5 мэргэжлээр бакалаврын хөтөлбөрөөр, хэл шинжлэлийн магистрын хөтөлбөрөөр тус тус сургалт явуулж байна.

Бакалавр, магистрын түвшний сургалтыг шинжлэх ухааны болон боловсролын доктор, магистрын зэрэгтэй, профессор, дэд профессор цолтой эрдэмтэн багш нар удирдан явуулдаг.

Бид одоогийн байдлаар 1500 гаруй оюутныг төгсгөж, нийт төгсөгчдийн маань 40 орчим хувь нь Япон улсад суралцаж, ажиллаж, амьдарч байна.

СЭДС нь Япон улсад 50 болон 100 хувийн тэтгэлэгтэй суралцах, сард 2 сая 500 мянга орчим төгрөгийн цалинтай япон хэл, соёлын практик дадлага хийх, зуны амралтаараа багш, оюутнууд 100 хувийн тэтгэлэгтэй хэлний бэлтгэлд суралцах, төгсөөд Япон улсад мэргэжлээрээ болон гэрээгээр ажиллах зэрэг олон боломжийг оюутан суралцагчиддаа олгодог.

2025-2026 оны хичээлийн жилд Программ хангамж хөтөлбөрөөр 2+2 бакалаврын хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэхээр Япон улсын Велнесс спортын их сургуультай хамтын ажиллагааны гэрээг байгуулсан. Мөн энэ хичээлийн жилд хичээлийн шинэ байрандаа үйл ажиллагаагаа явуулж эхлээд байна..

СЭДС нь Монгол Япон хоёр улсын соёл, боловсролын чиглэлээр хамтын ажиллагааны гүүр болон ажилладаг байгууллага юм.

Тус сургууль нь 2023 оны 8 сарын 3-нд түүхт 30 жилийн ойн баяраа тэмдэглэн өнгөрүүлсэн бөгөөд 30 жилийн ойгоороо Соёл Эрдэм Ахлах Сургуулийг дэргэдээ үүсгэн байгуулсан.

2025-2026 оны хичээлийн жилд сургуулийнхаа шинэ байрандаа үйл ажиллагаагаа явуулж байна.

Соёл Эрдэм Дээд Сургуулийн онцлог давуу талууд:

- Япон улсын 100%-ийн хөрөнгө оруулалттай
- Япон хэлний мэдлэгтэй Программ хангамжийн инженерийн боловсролтой болох
- Япон хэлний мэдлэгтэй мэдээллийн технологийн мэргэжилтэнг Япон улсын компаниуд руу ажилд зуучлах
- Япон хэлний N1 түвшингийн мэдлэгтэй болсон тохиолдолд Япон улсын их,
- дээд сургуулийн магистрт шууд элсэн суралцах
- Суралцаж байх хугацаандаа Япон улсад 1 жил хүртэлх хугацаагаар интерншип хөтөлбөрт хамрагдан цалинтай дадлага хийх
- Япон хэлийг Япон улсаас ирсэн мэргэжилтэн багшаар заалгах
- Япон улсын их, дээд сургуулиудад 50-100%-ийн тэтгэлэгтэй нөхцлөөр суралцах
- АНУ-ын сүлжээний мэргэжлийн CISCO академийн салбар үйл ажиллагаа явуулдаг
- Цахим сургалтын MOODLE платформыг хэрэглэж байна.

СУРГАЛТ

2023 онд УИХ-аар боловсролын шинэчлэлийн хүрээнд батлагдсан багц хуулиуд болох Боловсролын ерөнхий хууль, Дээд боловсролын тухай хуулиуд тэдгээрийн хэрэгжилтийг хангах хүрээнд Боловсролын яамны сайдын тушаалаар батлан гаргасан дүрэм, журмуудыг үйл ажиллагаандаа мөрдлөгө болгон ажиллаж байна.

Өнөөдрийн байдлаартус сургуульд нь бакалаврын 5 хөтөлбөр, магистрын нэг хөтөлбөртэйгээр сургалтын үйл ажиллагаагаа эрхлэн явуулж байна.

№	Индекс	Хөтөлбөрийн нэр	Суралцах жил	Цуглуулах кредит	ЭЕШ 1	ЭЕШ 2	Босго оноо
1	023101	Гадаад хэлний орчуулга	4	120	Англи хэл, Нийгэм судлал	Математик, Монгол хэл	Төрийн захиргааны төв байгууллагаас баталсан үндэсний босго оноо
2	022203	Олон улс, орон судлал	4	120	Англи хэл, Орос хэл	Нийгэм судлал, түүх	Төрийн захиргааны төв байгууллагаас баталсан үндэсний босго оноо
3	101501	Аялал жуулчлал	4	120	Математик	Англи хэл, Нийгэм судлал	Төрийн захиргааны төв байгууллагаас баталсан үндэсний босго оноо
4	061302	Программ хангамж	4	120	Математик, физик	Нийгэм судлал, түүх	Төрийн захиргааны төв байгууллагаас баталсан үндэсний босго оноо
5	031101	Эдийн засаг	4	120	Математик	Нийгэм судлал, Англи хэл	Төрийн захиргааны төв байгууллагаас баталсан үндэсний босго оноо
6	023203	Гадаад хэл шинжлэл	1,5-2	32			Магистрийн хөтөлбөр

Сургуулийн бас нэг онцлог нь Япон улсын Велнес спортын их сургуультай Программ хангамжийн 2+2 хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлээд байгаа явдал юм.

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГААНЫ АЖИЛ:

СЭДС-ийн мэргэжлийн тэнхимүүдийн судалгааны тэргүүлэх чиглэлүүд:

1. Япон хэл утга зохиол судлал, орчуулга зүй
2. Мэдээлэл харилцааны технологи
3. Монгол судлал, Монгол утга зохиол судлал

Япон судлалын тэнхимийн чиглэл:

1. Япон хэл утга зохиол судлал
2. Япон монгол, Монгол япон хэлний орчуулга зүй
3. Япон хэл заах арга
4. Япон хэл соёл судлал
5. Монгол Япон, Япон Монголын харилцаа судлал
6. Япон орон судлал

Мэдээллийн технологийн тэнхим:

1. Сүлжээний аюулгүй байдал
2. Программ хангамжийн хэрэглээ
3. Автоматжуулалт

Ахисан түвшний судалгаа

1. Япон хэл утга зохиол судлал
2. Япон монгол, Монгол япон хэлний орчуулга зүй
3. Япон хэл заах арга
4. Япон хэл соёл судлал
5. Монгол судлал, Монгол утга зохиол судлал

Тус сургуулийн эрдэмтэн багш нар судалгааны чиглэлээр судалгааны профессорын баг байгуулан үйл ажиллагаагаа явуулдаг.

Программ хангамжийн мэргэжлийн оюутнуудыг 2023 оноос эхлэн **CISCO академийн** албан ёсны гэрчилгээтэй төгсдөг болсноор олон улсад IT компаниудад ажиллах боломжийг олгодог. Мөн мэдээллийн аюулгүй байдлын мэргэшүүлэх сургалт, компьютерын сүлжээ, Internet of Things, Программ хангамж, OS & IT, Packet Tracer сургалтуудыг Дээд сургуулийн оюутанд үнэ төлбөргүй зааж мөн сургалт явуулж байна.

Тус хичээлийн жилээс эхлэн СЭДС нь онлайн болон цахим сургалтандаа MOODLE зайн сургалтын пратформыг хэрэглэж эхэллээ. Ингэснээр гадаадаас элсэн суралцаж байгаа магиструуд болон интерншип хөтөлбөрт хамрагдсан бакалаврын хөтөлбөрийн оюутнууд хугацаа алдахгүй сургалтаа үргэлжлүүлэн суралцах боломж нээгдэж байна.

СУРГУУЛИЙН ГАДААД, ДОТООД ХАМТЫН АЖИЛЛАГАА

Соёл Эрдэм Дээд Сургууль нь байгуулагдсан цагаасаа эхлэн гадаад харилцааны асуудлыг түлхүү анхаарч ирсэн. Япон улсын олон их дээд сургууль, хувийн хэвшил, олон улсын байгууллагуудтай сургалт, эрдэм шинжилгээний хамтын ажиллагааг хөгжүүлэхээс гадна оюутан, багш солилцооны хөтөлбөрийг хэрэгжүүлдэг.

Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд оюутан солилцооны хөтөлбөр хэрэгжүүлдэг нь оюутнуудад Япон улсын их дээд сургуулиудад 50-100%-ийн тэтгэлэгээр суралцах таатай боломжийг олгодог. Одоогийн байдлаар энэхүү оюутан солилцооны хөтөлбөрт 100 гаруй оюутан хамрагдаад байна. Ирэх 2024-2025 оны хичээлийн жилд Программ хангамжийн хөтөлбөрөөр 2+2 хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр Япон улсын Велнесс спортын их сургуультай хамтран ажиллах гэрээ байгуулан оюутнуудыг суралцуулах боломжтой болоод байна.

СЭДС нь Монголд анх удаа Интерншип буюу цалинтай дадлага хөтөлбөрийг 2014 оноос хэрэгжүүлж эхэлсэн. Энэхүү хөтөлбөр нь оюутнууд 3 сараас 1 жилийн хугацаатай япон улсад ажиллаж амьдран, хэлний мэдлэгээ сайжруулахын зэрэгцээгээр Япон улсын түүх соёл, аж амьдралын хэв маягаас суралцаж халуун рашаан, зочид буудалд ажиллан олон талын мэдлэг олж авах ач холбогдолтой дадлага юм. Энэ хөтөлбөрийн хүрээнд оюутнууд сард 160,000 иен буюу монгол мөнгөөр 2,500,000 гаруй төгрөгийн цалин авдаг.

Мөн гадагшаа чиглэсэн сургалт, семинар явуулахаас гадна хамтран ажиллагаатай их дээд сургуулиудын багш, оюутнуудтай хамтарсан Олон Улсын Эрдэм Шинжилгээний Хурлыг жил бүр зохион байгууладаг. Япон улсын Оберлин их сургуультай хамтарсан “Монгол, Япон улсын өнгөрсөн, одоо,

ирээдүй” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлыг жил бүр Япон улсад болон Монгол улсад ээлжлэн тасралтгүй зохион байгуулсаар байна. Улаанбаатар хотноо 2024 оны 8 сарын 4-нд тус хурлыг зохион байгуулж олон хүндтэй төлөөлөгчид оролцсон.

2006 оноос эхлэн жил бүр Япон улсын Оберлин их сургуультай хамтран хоёр улсын оюутнуудын байгаль экологийн хамтарсан дадлагыг зохион байгуулсаар ирсэн юм. Уг дадлагын хүрээнд хоёр орны оюутнууд харилцан мэдлэг солилцож, соёл, гадаад харилцаа, олон улс, түүх, хүрээлэн байгаа орчны тухай судалгаа хийдэг. Энэ хамтарсан дадлага нь цар хүрээгээ тэлэн 2016 оноос Риккёо их сургууль, 2017 оноос Чюоугакүин их сургууль оролцох болсон. Оюутнууд хүрээлэн байгаа орчны тандалт ажиглалт хийж, Туул голын эрэг орчмын дагуу хог хаягдлыг түүж, байгаль орчинд ээлтэй сайн дурын ажлыг хамтдаа хийдэг нь дадлагыг улам илүү ач холбогдолтой болгодог.

Хамтын ажиллагаатай японы компани, байгууллага, сургуулиуд:

1. Сэйжо их сургууль
2. Кайнан их сургууль
3. Хакүхо Жёши Танки их сургууль
4. Такүшёкү их сургууль
5. Оберлин их сургууль
6. Гакко Хоүжин Охара Гакүэн
7. Ёкохама Дэзайн Гакүин
8. Токёо Бүнгакүин
9. Гакко Хоүжин Дэнпа Коүка их сургуулийн групп
10. Нийгата Сангёо их сургууль
11. Тоүкай Гакүин Бүнка Кёоёо мэргэжлийн сургууль
12. Нихонго Кокүсай Гакүин
13. Гакко Хоүжин Норт Ази их сургууль
14. Чюоү Гакүин их сургууль
15. Хоккай Гакүэн их сургууль
16. Хассан II Касабланкагийн Их Сургууль
17. Чанаккале Онсекиз Мартын их сургууль
18. Нихон Вэлнэс Спорт их сургууль
19. Нихон Вэлнэс Хоикү мэргэжлийн сургууль
20. Кёорицү олон улсын солилцооны байгууллага
21. Олон улсын оюутныг дэмжих байгууллага
22. Нихон спортын шинжлэх ухааны их сургууль
23. Гакко Хоүжин АВК коллеж, АВК Гаккан япон хэлний сургууль
24. Кёорицү Япон хэлний академи
25. Японы хувийн их дээд сургуулиудын холбоо
26. Фүкүока Мал Эмнэлэгийн мэргэжлийн сургууль
27. Риккё Их Сургууль
28. Нихон эм зүйн их сургууль
29. Хокүто Бүнка Гакүэн
30. Токива их сургууль
31. Ниппон академи
32. Нийгата эм зүйн их сургууль
33. Комэзава охидын их сургууль

НОМЫН САН

Номын сан нь сургуулийн болон номын сангийн дотоод журам, удирдамжийг мөрдлөг болгон өөрийн ажилдаа хэрэгжүүлэн ажиллаж уншигчиддаа мэдээлэл арга зүйн нээлттэй үйлчилгээ үзүүлэх, сургалтын үйл ажиллагааг дэмжин, түшиц газар нь болон ажиллах эрхэм зорилго тавин ажиллаж байна

Номын сан нь сургалт, судалгаа, танин мэдэхүйн 15,5 ном, сурах бичиг болон танин мэдэхүйн номтой. Фондондоо мэргэжлийн мөн гадаад болон дотоод хэл дээрх уран зохиол, ном сурах бичгээр байнга нэмэгдүүлж байдаг.

Номын сангийн системд хангагдсан: Lib4U.net программ хангамжийг ашиглан номын сангийн уншигч, хэрэглэгчдэд зориулсан электрон каталог, номын бүртгэл, номны болон уншигчийн кодтой зураасан код, формуляр хэвлэх, номын фондны тооллого болон уншигчийн бүртгэл- уншлага үйлчилгээ, Номын сантай холбоотой төрөл бүрийн тайлан, статистик мэдээгээр хангагдсан.

Сургууль Соёл-Эрдэм “Хэлтэй бол Далавчтай” сонинг тогтмол эрхлэн гаргадаг бөгөөд эдүгээ 71 дэх дугаараа гаргаад байна. Энэхүү сонин нь тус сургуулийн гадаад болон дотоод сурталчилгааны гол хэрэгсэл болсоор байна.

ОЮУТНЫ БАЙР

СЭДСургуулийн хичээлийн байрны 5 давхарт 30 хүртэл оюутан байрлах хүчин чадалтай 9 өрөөтэй оюутны дотуур байр байрладаг. СЭДС-д элссэн оюутны байранд байрлах хүсэлтгаргасан оюутан бүрт дотуур байранд байрлах боломж олгодог. Манай сургуулийн дотуур байрны давуу тал нь тохь тух хангасан өрөө бүр дотроо ОО, уян душ, гал тогооны иж бүрэн тавилгатай, хөргөгч, ус буцалгагч, плитка, хоолны сав суулга байх ба өрөө бүр хувцас угаах угаалгын машинаар бүрэн хангагдсан байдаг.

СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛДАГ ЖУРМУУД

1. СЭДС-ийн сургалтын хөтөлбөрийн журам
2. СЭДС-ийн сургалтанд багц цаг буюу кредитийг хэрэглэх журам
3. СЭДС-ийн оюутны мэдлэгийг үнэлэх журам
4. СЭДС-ийн оюутан төгсгөх журам
5. СЭДС-ийн оюутны дадлагын журам
6. Үйлдвэрлэлийн дадлагыг зохион байгуулахад баримтлах аюулгүй ажиллагааны үлгэрчилсэн дүрэм
7. Шилийн булаг баазад хийх Япон хэл соёлын дадлагын удирдамж

Тухайн хичээлийн жилийн сургалтын үйл ажиллагаа нь “Сургалтын нэгдсэн календар”-ын дагуу явагдана.

ОЮУТНЫ МЭДЛЭГИЙН ҮНЭЛГЭЭ

1. Оюутны мэдлэгийг хоёр үе шаттайгаар үнэлнэ. Тухайн хичээлийн үнэлгээ. Уг хичээлээр оюутан эзэмшвэл зохих мэдлэгийг ол
2. ж авахын тулд улирлын турш хэрхэн сурч хөдөлмөрлөснөө тухайн хичээл заасан багшаар 70 хүртэл оноогоор, жинхэнэ мэдлэгийн түвшнийг улирлын шалгалтын 30 хүртэл оноогоор үнэлүүлнэ. Багшийн үнэлгээний 70 оноо нь дөрвөн улирлын хугацаанд хүчинтэй байна. Эдгээрийн нийлбэр 100 хүртэл оноог доорх хүснэгтийг ашиглан үсгэн үнэлгээнд шилжүүлнэ.

Хувьчилсан оноо	Үсгээр илэрхийлсэн үнэлгээ	Тоогоор илэрхийлсэн үнэлгээ /голч оноо/
95-100	+A	4.0
90-94	A	3.7
87-89	+B	3.3
83-86	B	3.0
80-82	-B	2.7
77-79	+C	2.3
73-76	C	2.0
70-72	-C	1.7
65-69	D	1.3
60-64	-D	1.0
0-59	F	0.5
	WF	0

Үсгээр илэрхийлсэн үнэлгээ дараах 5 үнэлгээний түвшний агуулгад хамаарна.

1. +A болон A үнэлгээ – сурлагын дээд амжилтыг илтгэх дүн. Тухайн хичээлийн агуулгыг дээд зэрэг бүрэн гүйцэд, бүтээлчээр ойлгосон, ухагдахуун, ойлголтуудыг чадварлаг ашигладаг.
2. +B, B болон -B үнэлгээ-дээгүүр амжилтыг илтгэх дүн. Тухайн хичээлийн агуулгыг сайн ойлгосон, тухайн хичээлтэй холбоотой аливаа асуудал шийдвэрлэхдээ ухагдахууныг ашиглах чадвартай.
3. +C, C болон -C үнэлгээ-тухайн хичээлийн агуулгыг дундаж түвшинд эзэмшсэнийг илтгэх дүн. Тухайн хичээлийн ухагдахууны хангалттай ойлгосон, дундаж түвшний асуудлыг шийдвэрлэх чадвартай, цаашид энэ чиглэлээр хичээл судлах хангалттай бэлтгэлтэй.
4. D, -D үнэлгээ-дундаж түвшнээс доогуур амжилтыг илтгэх дүн. Тухайн хичээлийн ухагдахуунуудыг жигд ойлгоогүй, энгийн хялбар асуудлыг шийдвэрлэх чадвартай ерөнхийдөө мэдлэг, чадвар, дадал дутмаг.

5. F үнэлгээ-сургалтын үйл ажиллагаанд оролцсон хэдий ч мэдлэг, чадвар, дадал хангалтгүйг илтгэх дүн.

6. WF үнэлгээ-сургалтын үйл ажиллагааны тодорхой хэсэгт оролцоогүйн улмаас хангалтгүй үнэлгээ авах боломжгүй болсныг илтгэх дүн.

7. Суралцагч тухайн хичээлийг судлан +A, A, -A, +B, B, -B, +C, C, -C, D, -D үнэлгээ авч бүрэн дүгнэгдэж дууссан тохиолдолд тухайн хичээлийг амжилттай судалсанд тооцно.

2. Суралцагчийн сурлагын чанарыг улирал бүрийн, мөн нийт суралцсан хугацааны голч оноо болон голч дүнгээр тодорхойлно.

2.1 Голч оноо нь багц цаг бүхий хичээл бүрээр суралцагчийн авсан голч оноог харгалзах багц цагаар нь үржүүлж, тэдгээрийн нийлбэрийг багц цагийн нийлбэрт харьцуулсан үзүүлэлт бөгөөд дараах томъёогоор тооцно.

$$\text{Голч оноо (ГО)} = \frac{O_1K_1 + \dots + O_nK_n}{K_1 + \dots + K_n} = \frac{\sum_1^n O_iK_i}{\sum_1^n K_i},$$

Үүнд: $i=1, \dots, n$; нь $O_1, O_2, \dots, O_n$ дугаар хичээлд харгалзах голч оноо

$K_1, K_2, \dots, K_n$ нь $1, 2, \dots, n$ дугаар хичээлд харгалзах багц цаг/кредит/

2.2 Голч дүн нь багц цаг бүхий хичээл бүрээр суралцагчийн авсан хувьчилсан оноог харгалзах багц цагаар нь үржүүлж, тэдгээрийн нийлбэрийг багц цагийн нийлбэрт харьцуулсан үзүүлэлт бөгөөд дараах томъёогоор тооцно.

$$\text{Голч дүн (ГД)} = \frac{D_1K_1 + \dots + D_nK_n}{K_1 + \dots + K_n} = \frac{\sum_1^n D_iK_i}{\sum_1^n K_i}$$

Үүнд: $i=1, \dots, n$; нь $D_1, D_2, \dots, D_n$ дугаар хичээлд харгалзах хувьчилсан оноо

$K_1, K_2, \dots, K_n$ нь $1, 2, \dots, n$ дугаар хичээлд харгалзах багц цаг/кредит/

2.3 Төгсөлтийн голч оноо (дүн) нь зөвхөн амжилттай дүгнэгдсэн хичээлүүдийн хувьд тодорхойлогдож төгсөлтийн албан ёсны баримт бичигт бичигдэнэ.

2.4 Суралцагчийн голч оноог улирал бүр сургуулийн мэдээллийн системд бүртгэнэ.

2.5 Суралцагчийн системд бүртгэгдсэн голч онооны үзүүлэлт нь оюутан цэрэг хөтөлбөр болон зээл, тэтгэлэг, япон улсад дадлага хийх, оюутан солилцооны хөтөлбөрт хамрагдах сонгон шалгаруулалтад оролцох үндэслэл болно.

2.6 Шалгалтын үр дүнгийн тэмдэглэгээ

Хүснэгт 1

Үсгэн тэмдэглэгээ	Тайлбар	Голч дүн бодоход уг тэмдэглэгээ бүхий дүнг тооцох эсэх	Дүнгийн тодорхойлолтод уг тэмдэглэгээ бичигдэх эсэх	Төгсөлтийн баримт бичигт уг тэмдэглэгээ бичигдэх эсэх
NA	Одоогоор дүгнэгдээгүй буюу судалж байгаа хичээлийн тэмдэглэгээ. (final grade Not yet Available)	Үгүй	Үгүй	Үгүй
G	Бүрэн дүгнэгдэж дууссаныг илтгэх тэмдэглэгээ. (Graded)	Тийм	Тийм	Тийм
W	Хичээлийн агуулгын 2/3-аас багагүйг судалсан, явцын үнэлгээний нийлбэр 60 хувийг хангасан боловч хичээлийн эцсийн үнэлгээгээ зохих түвшинд хүрэхгүй гэж суралцагч үзвэл улирал дуусахаас 7 хоногийн өмнө өөрийн хүсэлтээр багшид хүсэлт гаргасныг илтгэх тэмдэглэгээ. Тус хичээлийг дахин судлах бол шинээр үзэх хичээлийн нэгэн адил бүртгүүлж судална. (Withdraw)	Үгүй	Тийм	Үгүй
WF	Суралцагч хичээлийн аль нэг хэлбэрийн 1/3-ээс илүүд суугаагүй тохиолдолд багш тухайн хичээлийн улирал дуусахаас 7 хоногийн өмнө тавих тэмдэглэгээ. Энэхүү тэмдэглэгээ нь суралцагчдад F үнэлгээтэй адилаар тооцогдоно. (Withdrawal Fail) Тус хичээлийг дахин судлахдаа шинээр үзэх хичээлийн нэгэн адил бүртгүүлж судална.	Үгүй	Тийм	Үгүй
NR	Багш нь дүгнэх хугацаанд багтааж дүгнээгүй тохиолдолд тавих тэмдэглэгээ. Дүнгийн гомдол маргааны хугацаанд суралцагчийн зүгээс дүнгийн гомдол гаргаагүй тохиолдолд тухайн хугацаа	Тийм	Тийм	Үгүй

	дууссаны дараа суралцагчийн цуглуулсан онооноос хамааруулан харгалзах үсгэн үнэлгээнд шилжүүлнэ. (No grade Reported)			
R	Тухайн хичээлийг амжилттай судалсан ч дахин судлах хүсэлт гаргасан бол дахин судлах боломжоор хангах тэмдэглэгээ. (Repeat)	Үгүй	Тийм	Үгүй
I	Хүндэтгэн үзэх шалтгаанаар явцын үнэлгээ дутуу эсвэл улирлын шалгалтад ороогүй үед багшийн үед тавих тэмдэглэгээ. Суралцагч нөхөн шалгуулах хугацаанд багтааж шалгуулан дүгнүүлэх ба уг хугацаанд багтаж дүгнүүлээгүй тохиолдолд суралцагчийн цуглуулсан онооноос хамааруулан харгалзах үсгэн үнэлгээнд шилжүүлнэ. (Incomplete)	Үгүй	Тийм	Үгүй
E	Улирлын шалгалтад ороогүй бол багш энэ тэмдэглэгээг тавина. Суралцагч нөхөн шалгуулах хугацаанд багтааж шалгуулан дүгнүүлэх ба уг хугацаанд багтаж дүгнүүлээгүй тохиолдолд суралцагчийн цуглуулсан онооноос хамааруулан харгалзах үсгэн үнэлгээнд шилжүүлнэ. (Examine incomplete by student)	Үгүй	Тийм	Үгүй
CA	Суралцагч хугацаат цэргийн албанд татагдсан, хязгаарлалт хорио цээр тогтоосон нутаг дэвсгэрт 2 сараас их хугацаанд байсан, гэнэтийн осолд өртсөн, хүнд өвчний улмаас мэс засал хийлгэсэн тохиолдолд тавигдах тэмдэглэгээ. Суралцагч дахин судлах тохиолдолд төлбөр шаардахгүйгээр үргэлжлүүлэн суралцах боломжийг олгоно. (Cancelled)	Үгүй	Тийм	Үгүй
CR	Өөр сургуулийн дүйцүүлсэн хичээлийг тодотгох тэмдэглэгээ. (Credit gRanted)	Тийм	Тийм	Тийм
RC	Дүнгийн гомдол маргаанаар засварлагдсан дүнг илэрхийлэх тэмдэглэгээ (ReConsidered)	Тийм	Тийм	Үгүй

3. Оюутны мэдлэгийн үнэлгээ, улирлын шалгалт

- 3.1 Хичээлийг судалж дууссаны дараа оюутан уг хичээлийн хөтөлбөрт заагдсан мэдлэг, чадварыг хэрхэн эзэмшсэнийг үнэлэх улирлын шалгалтыг өгнө. Тухайн хичээлээр авах улирлын шалгалтыг улиралд зөвхөн нэг удаа зохион байгуулна.
- 3.2 Оюутны мэдлэгийг явцын үнэлгээ – 70 оноо хүртэл, улирлын шалгалтын үнэлгээ – 30 оноо хүртэл, нийт 100 оноо хүртэл үнэлэнэ.
- 3.3 Багшийн 70 онооны үнэлгээ нь ирцийн оноо /20 оноо хүртэл/+ явцын оноо /30 оноо хүртэл/+бие даалтын оноо /20 оноо хүртэл/ гэсэн бүтцээр гарна.
- 3.4 Багш нар өөрийн заасан хичээлээр оюутны суралцах үйл ажиллагааны явцыг үнэлсэн дүнг гаргаж /70 оноо/ улирлын төгсгөл 16 дахь долоо хоногт сургалтын албанд биеэр хүлээлгэн өгнө.
- 3.5 Үнэлгээний дүнгийн хуудсыг бичихдээ багш ямар нэг алдаа, засваргүй хар өнгийн балаар гаргацтай бичнэ. Багшийн бичсэн дүнгийн хуудсыг тэнхимийн эрхлэгч хянаж гарын үсэг зурж баталгаажуулсан байна.
- 3.6 Шалгалтыг тест, аман болон бичгийн хэлбэрээр эсвэл хосолсон хэлбэрээр авч болно. Улирлын шалгалтыг ямар хэлбэрээр авч байгаагаас үл хамааран шалгалт авах асуулт, асуултын сан зэрэг материалыг сургалтын албаар баталгаажуулж тамгалуулсан байна.
- 3.7 Шалгалтанд төлбөрийн үлдэгдэлгүй сургалтын төлбөрөө бүрэн төлсөн оюутныг бүртгэлээр оруулна.
- 3.8 Багш улирлын шалгалтыг авсан өдрөө дүнгийн хуудсыг бичиж тэнхимийн эрхлэгчээр хянуулж, баталгаажуулан сургалтын албанд хүлээлгэж өгнө.
- 3.9 Багш шалгалт авах платформ, шалгах хэлбэр, шалгалт үргэлжлэх хугацаа зэргийг оюутанд урьдчилан сайн тайлбарласан байна.
- 3.10 Оюутан улирлын эцэст өөрийн сурлагын амжилтандаа дүн шинжилгээ хийж, сургуулийн нэгдсэн стандартад заасан Үнэлгээний голч дүнгийн түвшний шаардлагыг хангаж байгаа эсэхээ хянаж, цаашид суралцах арга барилаа төлөвлөнө.
- 3.11 СЭДС-ийн бакалаврын зэргийн дипломыг 2.0 ба түүнээс дээш, магистрын зэргийн дипломыг 3.0 ба түүнээс дээш голч дүнтэй суралцсан төгсөгчдөд олгоно.
- 3.12 Тухайн хичээлийн хөтөлбөрийн дагуу оюутны мэдлэг чадварыг үнэлэх зорилгод нийцүүлэн шалгалтын хэлбэрийг багш өөрөө тогтооно.
- 3.13 Хоёр шалгалтын хооронд 1-3 өдөр байхаар тооцон шалгалт авах хуваарийг сургалтын алба, мэргэжлийн тэнхмүүдтэй хамтран гаргаж, захирлаар батлуулан улирал дуусахаас нэг сарын өмнө оюутнуудад мэдэлнэ. Энэ хуваарийг профессор, багш нар өөрчлөхгүй.
- 3.14 Оюутан шалгалтанд холбогдолгүй зүйлс авч орох, хуулах, бусдад саад учруулах, мөн сурлагын дэвтэргүй ирэхийг хориглоно.

- 3.15 Шалгалтанд орох оюутан биеэ авч явах болон хувцаслалтын соёлд онцгой анхаарсан байвал зохино.
- 3.16 Оюутан тогтоосон хугацаанд хүндэтгэх бус шалтгаанаар шалгалт өгөөгүй, эсвэл заалтыг зөрчсөн бол тухайн шалгалтанд унасан гэж үзэн “WF” үнэлгээ тавина.
- 3.17 Шалгалт авч дуусмагц шалгагч багш үнэлгээний хуудсыг сургалтын албанд өөрийн биеэр хүлээлгэн өгнө.
- 3.18 Үнэлгээний талаар маргаан гарвал сургалтын албанаас томилсон комисс шийдвэрлэнэ.
- 4. Дахин болон нөхөн шалгалт**
- 4.1. Аливаа хичээлийн улирлын үнэлгээгээр хангалтгүй дүн үзүүлсэн суралцагч дахин шалгалт өгч болно. Дахин нэг хичээлээр шалгалт өгөхөд оюутнаас авах төлбөрийн хэмжээг захиргааны зөвлөлийн хурлаар шийдвэрлэнэ. Хэрэв тухайн хичээлээр дахин WF үнэлгээ авбал оюутан хүсэлт гаргасан тохиолдолд тухайн хичээлийн кредитийн төлбөрийг дахин төлж, судалж, шалгалт өгч болно.
- 4.2. Хүндэтгэх шалтгаанаар /өвчилсөн буюу хүнд өвчтөн асарсан, аливаа гамшигт хөл хоригдсон, сургуулийн захиргааны чөлөөтэй байсан зэргийг хүндэтгэх шалтгаан гэж үзнэ/ шалгалтаа хугацаанд нь өгч чадаагүй оюутан нөхөн шалгалт өгч болно. Шалгалтанд орж чадахгүй болсон шалтгаанаа оюутан сургалтын албанд 3-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдсэн байна. Энэ тохиолдолд төлбөр төлөхгүй.
- 4.3. Дахин болон нөхөн шалгалтын товыг эхний удаад дараагийн улирлын хичээл эхлэхээс өмнө багтсан байхаар тооцож, сургалтын албанаас багш, оюутнуудад мэдэгдэнэ.
- 5. Бусад зүйл**
- 5.1. Дараах тохиолдолд оюутныг хангалтгүй суралцсанд тооцон анги дэвшин суралцахыг хориглоно. Үүнд:
- 5.1.1. Тухайн улиралд өгөх ёстой шалгалтуудыг бүрэн өгөөгүй бол;
- 5.1.2. Улирлын үнэлгээний голч дүн нь 1.0- ээс доош бол.
- 5.2. Хангалтгүй суралцсан үнэлгээг 3 улирал дараалан авбал сурлагаар тэнцээгүйд тооцож сургуулиас хасна.
- 5.3. Оюутан хувийн хүсэлтээ сургалтын албанд бичгээр гаргаж, албан ёсны тушаал гаргуулалгүй нэг улирлын турш сураг алдарсан тохиолдолд сургуулиас хасна.
- 5.4. Оюутан аль нэг хичээлдээ амжилтгүй суралцаж, дахин судлах тохиолдолд дараах журмын дагуу хичээллэж кредит цагаа нөхнө. Ингэхдээ суралцагч танхимын болон бие даалтын цагуудыг заавал гүйцээх ёстой.
- 5.4.1. Тухайн хичээл нь хэлний хичээл бол нэг кредит цаг тутамд танхимд заавал судлах цаг нь 6 цагаас доошгүй, мэргэжлийн хичээл бол танхимд судлах цаг нь 4 цагаас доошгүй байх ба хичээлийн болон хичээлийн бус цагаар заавал танхимын сургалтыг гүйцээсэн үед кредит цаг нөхсөнд тооцож, авсан үнэлгээг баталгаажуулна.
- 5.4.2. Оюутны кредит цаг нөхөхөд багш сургалтын албанд танхимын цаг бүртгүүлэх ёстой. Хэрвээ бүртгүүлээгүй бол кредит нөхөлтийн тооцоонд оруулахгүй болно. Тухайн оюутанд хичээлийн болон хичээлийн бус цагаар танхимын сургалтыг заавал заана.
- 6. Сургалтын төлөвлөгөө, хичээлийн стандарт**
- 6.1 Тухайн мэргэжлийн сургалтын төлөвлөгөөнд мэргэжлийн зориулалт, тодорхойлолт, оюутны эзэмших мэдлэг, чадвар, дадал, оюутны судлах хичээлийн жагсаалт, тэдгээрийн багц цаг, өмнөх хичээлийн холбоо зэргийг тусгана. Оюутныг суралцах үйл ажиллагаагаа зөв төлөвлөхөд туслах "Оюутан танд зөвлөж байна" төлөвлөгөөг гарган оюутанд хүргэнэ.
- 6.2 Сургалтын төлөвлөгөө нь дээд боловсролын суурь, мэргэжлийн суурь, мэргэшүүлэх гэсэн 3 үндсэн багц хичээлүүдээс гадна дадлага, бакалаврын төгсөлтийн ажлыг агуулсан байна. Хичээлүүд нь заавал ба сонгон судлах хэлбэртэй байна.
- 6.3 Бакалаврын түвшинд заагдах бүх хичээл кодтой байна. Код нь латин 2 үсэг ба түвшнийг илэрхийлэх 3 оронтой дугаараас тогтоно. Үүнд:
- 100-199 дугаартай бол дээд боловсролын суурь ухааны хичээл,
 - 200-299 дугаартай бол мэргэжлийн суурь хичээл,
 - 300-399 дугаартай бол мэргэжлийн хичээл.
- Хичээлийн нэр, код нь сургуулийн хэмжээнд давхардахгүй байна.
- 6.4 Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээлийн агуулга нэг улиралд багтаан заах боломжтой байна.
- 6.5 Хичээлийн стандарт нь тухайн хичээлийн лекц, семинар, лаборатори, мөн хичээлээр судлах сэдэвчилсэн төлөвлөгөө, оюутныг үнэлэх багшийн үнэлгээ зэргийг багтаасан байна.

СЭДС-ийн ОЮУТНЫ ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ ЖУРАМ

Нэг. Нийтлэл үндэслэл

1.1. СОЁЛ ЭРДЭМ ДЭЭД СУРГУУЛЬ-ийн оюутанд чөлөө олгох, оюутан өөрийн авъяас сонирхолдоо нийцсэн мэргэжил, сургуулиа сонгох үүднээс гадаад, дотоодын их, дээд сургууль, дээд боловсрол олгодог коллежоос оюутан шилжин ирж суралцах зэрэг үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

Хоёр. Оюутанд чөлөө олгох

- 2.1 Суралцагч оюутан нь хүндэтгэн үзэх шалтгаанаар хичээлд сууж чадахгүйд хүрвэл богино хугацааны чөлөөг авахдаа хүсэлтээ өргөдлөөр гаргана. Хичээлийн нэг хоногийн чөлөөг анги удирдсан багш, 3 хоног хүртэлх чөлөөг хариуцсан тэнхмийн эрхлэгч, 1 сар хүртэлх чөлөөг сургалтын албанаас шийдвэрлэнэ.
- 2.2 Сургалтын үйл явцыг тодорхой хүндэтгэн үзэх шалтгааны улмаас цаашид үргэлжлүүлэн суралцах боломжгүй болсон оюутан нэг улирлын, эсвэл нэг жилийн хугацааны чөлөө авч болно.
- 2.3 Чөлөө авах хүсэлтэй оюутан өргөдөл гаргаж, Сургалтын албанд хандана.
- 2.4 Өргөдлийн дагуу Сургалтын алба тухайн оюутны нийт цуглуулсан кредит, хуримтлуулсан үнэлгээний голч дүн, тухайн улирлын хичээлийн зөрүү, нийт кредитийг тус тус баталгаажуулан гаргаж өгнө. Мөн оюутны төрийн сангийн зээл, буцалтгүй тусламжаар суралцаж байгаа эсэхийг тодорхойлно. Оюутанд тойрох хуудас олгогдоно.
- 2.5 Оюутан сургалтын албанаас гаргаж өгсөн баримт бичгийг өөрийн өргөдлийн хамт мэргэжлийн харъяа тэнхмүүдэд танилцуулан зөвшөөрөл авна.
- 2.6 Оюутан тойрох хуудсаа бүрдүүлж дууссаны дараа Сургалтын албанд өгөх бөгөөд уг хуудсан дахь “Тооцоогүй” гэсэн тэмдэглэгээний он, сар, өдрийг үндэслэн, оюутанд чөлөө олгосон тухай Захирлын тушаал гарна.
- 2.7 Оюутан суралцах хугацааныхаа турш нийт 3 хүртэл жилийн чөлөө авч болно. Гэхдээ оюутан хоёр удаа чөлөө авах тохиолдолд тэдгээрийн хооронд намар, хаврын бүтэн 2 улиралд хэвийн ачаалалтайгаар суралцсан байх шаардлагатай. Оюутан чөлөөг сунгах хүсэлт гаргасан тохиолдолд чөлөөг нэг удаагийн чөлөөнд тооцно.
- 2.8 Олон улсын тэмцээн, уралдаанд оролцох оюутныг жилд нэг удаа 1 сараас хэтрэхгүй хугацааны хичээлийн чөлөө олгоно.
- 2.9 Улсын хэмжээний тэмцээнд оролцох оюутанд жилд нэг удаа 15 хоногоос хэтрэхгүй хугацааны хичээлийн чөлөө олгоно.

Гурав. Оюутны шилжилт

- 3.1 Гадаад болон дотоодын их, дээд сургуулиудаас СОЁЛ ЭРДЭМ ДЭЭД СУРГУУЛЬ-д шилжин суралцах хүсэлтэй оюутан тус сургуулийн сургалтын албанд хандана.
- 3.2 Дараах нөхцлүүдийн аль нэгийг хангасан сургуулиудаас зохих болзол хангасан оюутныг СЭДС-д шилжин суралцахыг зөвшөөрнө. Үүнд:
 - Дотоодын их, дээд сургууль, коллежийн хувьд Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлөөр байгууллагын буюу тухайн хөтөлбөрийн магадлан итгэмжлэл хийлгэсэн сургууль;
 - Гадаадын их сургууль нь тухайн улсынхаа хууль тогтоомжийн дагуу дээд боловсролын байгууллагын буюу хөтөлбөрийн магадлан итгэмжлэл хийлгэсэн сургууль;
 - Гадаадын их сургуулийн дэргэдэх хэлний бэлтгэл ангид 2 жил амжилттай суралцаж төгссөн оюутнаас түвшин тогтоох шалгалт авч, СЭДС-ийн харгалзах гадаад хэл, орон судлалын ангид шилжин суралцахыг зөвшөөрнө.
- 3.3. СЭДС-д шилжин суралцах оюутан дараах болзлыг хангасан байна. Үүнд:
 - Журмын 2-т заасан нөхцлийг хангасан сургуульд суралцаж байсан;
 - СЭДС-ийн аль нэг ангид хөнгөлөлттэй нөхцлөөр элсээгүй байх.
- 3.4. Шилжин суралцах хүсэлт гаргаж буй оюутан доорхи бичиг баримтыг бүрдүүлсэн байна.
 - Хувийн өргөдөл
 - Иргэний үнэмлэх
 - Ерөнхий шалгалтын батламж
 - Анх элсэн орсон сургуулийн томилолт /эх хувь/
 - Оюутнаар батлагдсан тухай шилжүүлж буй сургуулийн захирлын тушаалын хуулбар

- Суралцаж байсан сургуулийн тодорхойлолт
- Сурлагын дүнгийн баталгаажсан жагсаалт
- Хувийн хэрэг
- Бүрэн дунд боловсролын гэрчилгээ зэрэг болно.

- 3.5. Хүсэлт гаргасан оюутныг шилжин суралцуулах эсэхийг захиргааны зөвлөлийн хуралд хэлэлцэнэ
- 3.6. Тухайн оюутныг шилжүүлж авах хүсэлтийг хичээлийн жилийн улирал эхлэхээс өмнө эцэслэн шийдвэрлэх бөгөөд энэ журмын 2 дахь заалтын биелэлтийг СЭДС-ийн сургалт хариуцсан алба хүлээн авч судлан, шийдвэрлэнэ.
- 3.7. Оюутны өмнө үзсэн хичээлийн багц цагийг тооцох асуудлыг сургалтын албаны эрхлэгч, мэргэжлийн тэнхмийн эрхлэгч нар судлан тогтоож баталгаажуулна. Үүнд:
- Хичээлийн багц цагийг СЭДС-д баримталдаг багц цагийн журмаар тооцно.
 - Хэрэв уг сургуулийн багц цагийн тодорхойлолт СЭДС-ийнхаас өөр буюу сургалтын агуулгыг цагаар тооцдог бол СЭДС-д баримталдаг багц цагийн тодорхойлолтыг үндэслэн багц цагт шилжүүлж (0,5-ын нарийвчлалтай) бодно.
 - Хичээлийн багц цаг нь СЭДС-ийнхтай адил боловч оюутны шалгалтын дүн 80%-аас доош, мөн хичээлийн агуулга хангалтгүй гэж үзвэл сургууль комисс байгуулан гол хичээлүүдийн бүрэн агуулгаар түвшин тогтоох шалгалт авч багц цагийг тооцох, эсэхийг шийднэ.
 - Шалгалтын үнэлгээг оноонд үндэслэн тооцно. Хэрэв уг сургуулийн үнэлгээний тогтолцоо онооноос өөр бол оноонд хэрхэн харгалзуулах тухай албан ёсны тайлбар, бичвэр авчиргахыг шаардана. Хэрэв ийм боломжгүй бол амжилттай дүнгийн хуваарийг 60-95 онооны завсарт жигд харгалзуулах замаар шилжүүлэн тооцож болно.
- 3.8. Багц цагийн тооцоо, шилжин суралцах анги дүүргэлтийн байдлыг үндэслэн уг оюутныг шилжүүлэн суралцуулах боломжтой гэж үзвэл зохих төлбөрийг төлсний дараа сургалтын албаны зөвшөөрлөөр хичээлд суулгаж, СЭДС-ийн захирлын тушаал гаргаж баталгаажуулна.
- 3.9. Шилжин ирсэн оюутны тооцуулсан багц цагийн тооцоог сургалтын алба үйлдэж, тооцооны хувийг уг оюутанд өгөхөөс гадна захирлын тушаалын төсөлд хавсаргана.
- 3.10. Шилжих зөвшөөрөл олгогдсон оюутантай Сургалтын алба “Оюутны гэрээ”-г байгуулна. Тухайн мэргэжлийг хариуцаж байгаа тэнхим нь оюутны сурлагын дүнгийн жагсаалтыг үндэслэн, өмнөх сургуульд үзэж судалсан хичээлүүдээс агуулгын хувьд дүйцүүлэн тооцох хичээл байгаа эсэхийг нягтлан, өөрийн сургуулийн сургалтын албаар уламжлуулан, дүн болон кредитийг дүйцүүлэхийг шийдвэрлэнэ.
- 3.11. “Оюутны гэрээ”-г байгуулснаар оюутан сургалтын төлбөрөө төлж, сургалтын үйл явцад оролцох эрхтэй болно.
- 3.12. Тухайн мэргэжлээр төрийн буцалтгүй тусламж, зээлээр суралцаж буй оюутан нь шилжин суралцсан тохиолдолд сургалтын төлбөрийг төр хариуцахгүй бөгөөд төрийн сантай хийсэн гэрээ хүчингүй болж оюутан хувийн зардлаар цаашид суралцана.

Дөрөв. Оюутныг үргэлжлүүлэн суралцуулах

- 4.1 Чөлөө авсан оюутан чөлөөний хугацаагаа дуусгаж, үргэлжлүүлэн суралцах тухай хүсэлтээ өргөдлөөр гаргаж, тэнхмийн эрхлэгчид танилцуулан баталгаажуулсны үндсэн дээр Сургалтын албанд өгч шийдвэрлүүлнэ.
- 4.2 Үргэлжлүүлэн суралцах хүсэлт гаргасан оюутны хүсэлтийг сургалтын алба захиргааны зөвлөлийн хурлаар шийдвэрлүүлж, захирлын тушаалаар баталгаажсаны үндсэн дээр суралцах эрхтэй болно.

Тав. Оюутныг анхааруулах, сургуулиас хасах

- 5.1. Дараалан хоёр улирал нэр нь бичигдсэн оюутан харьяа тэнхмийн эрхлэгчтэй уулзах шаардлагатай.
- 5.2. Тэнхмийн эрхлэгчийн тодорхойлолтыг үндэслэн тухайн оюутныг сургуулиас шууд хасах, эсвэл хасахыг сануулах болно.
- 5.3. Хэрэв сануулга авсан оюутан нь 3 дахь улиралдаа дахин хангалтгүй суралцвал түүнийг сурлагаар тэнцэхгүй байна гэж үзэн сургуулиас хасна.
- 5.4 Чөлөө авалгүй нэг улирал сураг алдарсан, эсвэл сургуультай байгуулсан гэрээгээ зөрчсөн бол сургуулиас хасна.

БАГЦ ЦАГ ТООЦОХ БОЛОН ДҮН ДҮЙЦҮҮЛЭХ ЖУРАМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

- 1.1 БШУ-ы сайдын 2024 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн А/216 тушаалыг үндэслэн СЭДС-д багц цаг хэрэглэх, багшийн ачааллыг тооцох, гадаад болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад амжилттай судалсан хичээлийг дүйцүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад энэхүү журмыг баримтлана.
- 1.2 Суралцагчийн өмнө нь судалсан мэдлэг, чадвар, хандлага төлөвшлийг хүлээн зөвшөөрөх нөхцөлийг тодорхойлоход энэхүү журмын зорилго оршино.
- 1.3 Суралцагчийн өмнө нь амжилттай судалсан, тодорхой түвшний суралцахуйн үр дүнг эзэмшсэн хичээл, түүнтэй адилтгах сургалт (цаашид “хичээл” гэнэ), түүний үнэлгээг СЭДС-д хэрэгжиж буй хичээлийн агуулга, багц цаг, үнэлгээтэй дүйцүүлэн тооцоход холбогдох харилцааг зохицуулахад энэхүү журмыг (цаашид “журам” гэнэ) мөрдөнө.
- 1.4 СЭДС -ийн боловсролын ижил түвшний хөтөлбөрт шилжин суралцах, өмнө нь дээд (дипломын болон бакалавр, магистрын) боловсрол эзэмшсэн ТӨГСӨГЧ эсвэл олон улсын хөтөлбөрөөр сургалт эрхэлдэг ахлах сургууль, СЭДС -д шинээр элсэн суралцах, СЭДС -тай байгуулсан гэрээний дагуу бусад их, дээд сургууль, коллежийн зэргийн болон зэргийн бус хөтөлбөрт суралцаад буцаж ирэх, хичээл солилцооны гэрээний дагуу дотоодын их, дээд сургууль, коллежид хичээл судлах, хэд хэдэн хөтөлбөрөөр зэрэгцэн суралцах, сургуулиас чөлөөлөгдсөн суралцагч СЭДС -д эргэн суралцах, СЭДС -ийн хөтөлбөрийн онцлогоос хамааран хичээл дүйцүүлэх тохиолдолд энэхүү журмыг баримтлана.
- 1.5 Суралцагч гадаадын их, дээд сургууль, коллежид суралцах эсвэл гадаадын их, дээд сургууль, коллежоос СЭДС -д суралцах үед дүнгийн системийг хөрвүүлэх, СЭДС -ийн багц цаг болон тухайн сургуулийн багц цагийн харьцааг тодорхойлоход энэхүү журамд тусгагдсан дүн болон багц цагийн хөрвүүлэлтийн аргачлалыг ашиглана.

ХОЁР. Нэр томъёоны тодорхойлолт

- 2.1 Хичээл дүйцүүлэх: Нэг сургалтын байгууллагад судалсан хичээлийн суралцахуйн үр дүн, багц цаг, үнэлгээг нөгөө сургуулийн харгалзах хичээлийн суралцахуйн үр дүн, багц цагийн агууламж, стандарт болон үнэлгээний системээс хамааруулан дүйцүүлэн тооцох үйл ажиллагааг хэлнэ.
- 2.2 Багц цаг хөрвүүлэх: Нэг сургалтын байгууллагад судалсан хичээлд ноогдуулсан багц цагийг ачааллаас хамааруулан нөгөөд сургалтын ачааллаас хамааруулан хөрвүүлэн тооцох үйл ажиллагааг хэлнэ.
- 2.3 Дүн дүйцүүлэх: Нэг сургалтын байгууллагад суралцаж үнэлэгдсэн хичээлийн дүнг нөгөөд, үнэлгээний системээс хамааруулан дүйцүүлэх үйл ажиллагааг хэлнэ.
- 2.4 Зэргийн бус сургалт: Үндсэн хөтөлбөрт элсэх зорилго бүхий бэлтгэл хөтөлбөр (япон хэлний бэлтгэл, англи хэлний бэлтгэл хөтөлбөр гэх мэт) болон үндсэн хөтөлбөрт суралцаж байх хугацаандаа өөрийн мэргэжлийн дагуу оюутан солилцоо, мэргэших дадлага (интерншип), зуны буюу богино хугацааны сургалтын хөтөлбөрт хамрагдахыг хэлнэ.
- 2.5 Хамтын ажиллагааны гэрээ: Гадаадын болон дотоодын гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагууд Сургалтын үйл ажиллагаатай холбогдуулан оюутан солилцооны, зэргийн болон зэргийн бус хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх тухай харилцан тохиролцож байгуулсан баримт бичиг.
- 2.6 Суралцах гэрээ (Learning agreement): Хамтын ажиллагааны гэрээнд заагдсан нөхцөлүүдийг хүлээн зөвшөөрч гадаадын гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцаж ирэх тухай сургуулийн удирдлага, мэргэжлийн тэнхим болон суралцагчийн хооронд байгуулсан гурвалсан гэрээ.

ГУРАВ.Хичээл дүйцүүлэхэд баримтлах ерөнхий шаардлага

- 3.1 Хичээл дүйцүүлэх үйл ажиллагаа нь албан ёсны дүнгийн тодорхойлолт болон тухайн хичээлийн хөтөлбөр болох эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлага (суралцахуйн үр дүн)-д үндэслэх ба дараах шалгууруудыг хангасан тохиолдолд дүйцүүлэх боломж нээгдэнэ. Үүнд:
 - 3.1.1 Агуулга болон суралцахуйн үр дүнгийн 80-аас багагүй хувийн давхцалтай, цааш үргэлжлүүлэн суралцахад бэрхшээл учруулахааргүй
 - 3.1.2 Дүйцүүлэх хичээл нь СЭДС -ийн дүйцэх хичээлийн багц цагийн хэмжээнээс 0.5 багц цагаар бага байж болно.

3.1.3 Дүйцэх хичээл өмнөх залгамж холбоогүй байх, эсвэл өмнөх холбоотой хичээлийг амжилттай судалсан байх

3.1.4 Үнэлгээ нь тодорхойгүй буюу дүнд хувиргах боломжгүй (“тооцов” гэх мэт дүгнэгдсэн) хичээлийг дүйцүүлэн тооцохгүй

3.1.5 СЭДС -ийн харгалзах хичээл нь өмнөх залгамж холбоотой бөгөөд залгамж холбооны өмнөх хичээлүүдийг дүйцүүлэх (судалсанд тооцох) боломжгүй тохиолдолд уг хичээлийг дүйцүүлэхгүй. Залгамж холбооны өмнөх хичээлийг СЭДС -д амжилттай судалсан ч тухайн хичээлийн дүйцүүлэлтийг нөхөж хийхгүй.

3.1.6 Төгссөнөөс хойш 6 жил хэтэрсэн бол тухайн хөтөлбөрийн хичээлүүдийг дүйцүүлэхгүй.

3.1.7 Ижил түвшний хөтөлбөрүүдэд тусгагдсан байх;

3.1.8 СЭДС -д зөвхөн харгалзах хөтөлбөрийн, бакалаврын түвшний бол ерөнхий суурийн болон мэргэжлийн суурийн багцын, магистрын түвшин бол ерөнхий суурь болон мэргэжлийн багцын мэргэжлийн багцын хичээлүүдээс дүйцүүлж болно.

3.2 Хөтөлбөр хооронд шилжин суралцах

3.2.1 Бусад дээд боловсролын сургалтын байгууллагаас шилжин суралцах үед 3.1-т заагдсан журмын шаардлагыг хангасан байх бадотоодын Их, дээд сургууль, коллежийн хувьд магадлан итгэмжлэл хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаар магадлан итгэмжлэгдсэн сургуулийн хичээлийг дүйцүүлнэ.

3.2.2 Бусад дээд боловсролын сургалтын байгууллагаас шилжин ирэх үеийн дүнг СЭДС -ийн үнэлгээний системд хөрвүүлсний дараа СЭДС-ийн харгалзах хичээлийн дүн нь 70-с доош үнэлгээтэй болсон тохиолдолд дүйцүүлэн тооцохгүй

3.2.3 Бусад дээд боловсролын сургалтын байгууллагаас шилжин суралцагчийн өмнө нь судалсан хичээлүүдээс бакалаврын өдрийн хөтөлбөрт бол 45 хүртэл, магистрын хөтөлбөрт бол 6 хүртэл багц цагийн хичээлийг дүйцүүлэн тооцож болно

3.2.4 Дэлхийн шилдэг 500-д эрэмбэлэгдсэн гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагаас Шилжин суралцах тохиолдолд журмын 3.1.7-д тусгасан багцын хязгаарлалт, 3.2.2-т тусгасан дүнгийн босгыг мөрдөхгүй бөгөөд бакалаврын хөтөлбөрт бол 60 хүртэлх, магистрын хөтөлбөрт бол 9 хүртэлх хүртэлх багц цагийн хичээлийг дүйцүүлэн тооцож болно

3.2.5 Бусад дээд боловсролын сургалтын байгууллагаас шилжин суралцагчийн хичээлийг дүйцүүлэхдээ хөтөлбөр, хичээлийн онцлог, бусад шаардлагаас хамааруулж журмын 3.2.3, 3.2.4-т тусгагдсан багц цагийн хэмжээг мэргэжлийн тэнхимийн шийдвэрээр бууруулж болно.

3.2.6 СЭДС-ийн хөтөлбөр хооронд шилжих болон суралцах хэлбэрээ солих тохиолдолд журмын 3.1.1-3.1.6 дахь шаардлагыг хангасан хичээлүүдийг дүйцүүлж болох ба журмын 3.1.7-д заасан багцын хязгаарлалтыг мөрдөхгүй.

3.3 Хичээл солилцон суралцах

3.3.1 СЭДС -тай байгуулсан хичээл солилцон судлах гэрээний дагуу СЭДС-ийн суралцагч дотоодын их, дээд сургуульд судалж ирсэн хичээлийг шууд тооцож болно.

3.3.2 СЭДС-тай байгуулсан хичээл солилцооны гэрээний дагуу өөр сургуулийн суралцагч СЭДС-д судалсан хичээлээ эргэн СЭДС-д тооцуулах тохиолдолд дүйцүүлэлтийг шууд хийх ба энэ нь журмын 3.1.7-д заасан багцын хязгаарлалтад хамаарахгүй. Бакалаврын түвшний хөтөлбөрийн суралцагчийн хувьд 15, ахисан түвшний хөтөлбөрийн суралцагчийн хувьд 6 багц цаг хүртэл дүйцүүлнэ.

3.5 Дараагийн түвшний сургалтад элсэн суралцах

3.5.1 СЭДС-аас бусад сургуулийн төгсөгч нь СЭДС-ийн дараагийн түвшний хөтөлбөрт элсэн суралцах Тохиолдолд хичээл дүйцүүлэхгүй.

3.6 Ижил түвшинд шинээр элсэн суралцах

3.6.1 СЭДС-ийн төгсөгч нь ижил түвшний өөр хөтөлбөрт элсэн суралцах тохиолдолд өмнөх хөтөлбөрийн хичээлээс журмын 3.1.1-3.1.6-д тусгасан шаардлага хангасан хичээлийг дүйцүүлж болох ба журмын 3.1.7-д тусгасан багцын хязгаарлалтыг мөрдөхгүй.

3.6.2 Бусад их, дээд сургуулийн төгсөгч нь СЭДС-ийн ижил түвшний хөтөлбөрт элсэн суралцах тохиолдолд журмын 3.1.1-6 дэх шаардлагыг хангасан СЭДС-ийн ерөнхий суурийн хичээлийг дүйцүүлж болно.

3.7 Эргэн суралцах

3.7.1 Өмнө нь СЭДС-д суралцаж байсан (захирлын тушаалаар чөлөөлөгдсөн) суралцагч нь чөлөөлөх тушаал гарснаас хойш 3 жилийн дотор суралцагч элсүүлэх журмын дагуу эргэн суралцах тохиолдолд журмын 3.1.1-3.1.6-д тусгасан шаардлагыг хангасан хичээлийг дүйцүүлж болно.

3.7.2 Бусад их, дээд сургуульд суралцаж байсан суралцагч СЭДС-д суралцагч элсүүлэх журмын дагуу элсэн суралцах тохиолдолд өмнө нь судалсан хичээлийг дүйцүүлэхгүй.

3.8 Зэрэгцэн (хос) сургалтын үед хичээл дүйцүүлэх

3.8.1 СЭДС дотроо ижил түвшний хөтөлбөрт зэрэгцэн суралцаж буй тохиолдолд журмын 3.1.1-3.1.6-д заасан шаардлагыг хангасан хичээлүүдийг дүйцүүлнэ.

3.8.2 Ижил түвшний хөтөлбөрт зэрэгцэн суралцаж буй тохиолдолд бакалаврын хөтөлбөрийн чөлөөт сонголт, магистр бусад, тэнхим, салбар нэгжийн судлах багцын гүйцэтгэлийг зэрэгцэн суралцаж буй нөгөө хөтөлбөрийн хичээлээр дүйцүүлж болно.

ДӨРӨВ. Багц цаг шилжүүлэн тооцох аргачлал

4.1 Багц цагийн тодорхойлолт нь СЭДС-тай ижлээр тодорхойлогдсон хичээлийн багц цагийг тэр хэвээр нь ашиглах бөгөөд багц цагийг СЭДС-аас өөрөөр тодорхойлсон гадаадын их, дээд сургууль, коллежид судалсан хичээлийг СЭДС-д тооцохдоо тухайн сургуулийн сургалтын цагийн тухай албан ёсны тайлбар заавал шаардана. Энэ тохиолдолд тухайн багц цагийн тодорхойлолт дахь суралцагчийн ачааллыг СЭДС-ийн багц цагийн харгалзах үзүүлэлтүүдэд шилжүүлэн тооцно.

4.2 Гадаадын их, дээд сургуулиудад түгээмэл хэрэглэгддэг ялгаатай багц цагийг Хүснэгт 1-д заасны дагуу шилжүүлэн тооцно.

4.3 Журмын 3.1.2-т тусгасан нөхцөлөөс бусдаар СЭДС-д дүйцэх хичээлийн багц цагт хүрэхгүй бол шилжүүлэн тооцохгүй. Багц цагийн дутууг харгалзах цагийн хэмжээгээр нэмж судлах мэтээр нөхөн гүйцээхгүй.

4.4 Бусад дээд боловсролын сургалтын байгууллагаас хичээл дүйцүүлэхэд СЭДС-ийн дүйцэх хичээлийн, СЭДС дотроо бол анхны дүйцэгдэх хичээлийн нэр, багц цагаар хөтөлбөрийн биелэлтэд тооцно.

4.5 Суралцагчийн судалсан хэд хэдэн хичээлийн багц цаг болон агуулга, суралцахуйн үр дүн нь нийлээд СЭДС-ийн харгалзах хичээлийн багц цаг, агуулга, суралцахуйн үр дүнгийн шаардлагыг хангаж байвал тухайн хичээлүүдийг нэгтгэн дүйцүүлж болно.

4.6 Суралцагчийн судалсан нэг хичээл нь СЭДС-ийн хэд хэдэн хичээлийн агуулга, суралцахуйн үр дүн, багц цагийн шаардлагыг хангасан бол тэдгээр хичээлүүдийг тус тусад нь дүйцүүлж болно.

ТАВ. Суралцагчийн үнэлгээ (дүн)-г дүйцүүлэх аргачлал

5.1 Бусад дээд боловсролын сургалтын байгууллагуудад түгээмэл хэрэглэгддэг үнэлгээний системийг Хүснэгт 2-т заасны дагуу СЭДС-д хөрвүүлэн ТООЦНО.

5.2 Суралцагчийн хичээлийн үнэлгээ нь СЭДС-ийн үнэлгээний системээс (дүнгийн шатлал) өөр бол тухайн сургуулийн дүнгийн шатлалын тухай албан ёсны тайлбарыг шаардах бөгөөд хэрэв боломжгүй бол амжилттай дүнг 60-95 онооны завсарт жигд харгалзуулах замаар шилжүүлэн тооцно. Тухайлбал, тухайн сургууль оюутны мэдлэгийг онц, сайн, дунд, муу гэж үнэлдэг бол 60-71, 72-83, 84-95 оноог амжилттай дүнд харгалзуулан дунд -66, сайн -78, онц -90 гэж оноох юм уу, эсвэл үнэлгээг тооцсон багц цагийн нарийвчлалтай холбож багц цагийг бууруулан тооцсон бол интервалын дээд оноог харгалзуулж болно.

5.3 СЭДС-д дүйцүүлэн тооцох дүн нь СЭДС-ийн үнэлгээний системийн аль нэг интервалаар тодорхойлогдож байвал уг интервалын дундаж утгаар эцсийн үнэлгээг тогтооно.

5.4 Дүн дүйцүүлэхдээ тухайн хичээлээр дүгнэгдсэн нийт суралцагсдын сүүлийн 2-3 жилийн дүнгийн тархалтад үндэслэн тооцоолж болно. Ийм тохиолдолд тухайн хичээлийн дүн нь дүнгийн тархалтын дээд 10%-д хамаарагдаж байвал А дүнтэй, дараагийн 25%-д харгалзаж байвал В, дараагийн 30% нь С, дараагийн 25% нь D, харин сүүлийн 10%-д харгалзаж байвал F үнэлгээ тавина.

- 5.5 Журмын 4.4-т заасны дагуу хэд хэдэн хичээлийг нэгтгэн дүйцүүлж байгаа тохиолдолд үнэлгээг тухайн хичээлүүдийн багц цаг ба дүнгийн жигнэсэн дунджаар тооцоолох ба бутархай дүнг ойролцоолж бүхэл болгоно.
- 5.6 Журмын 4.5-д заасны дагуу нэг хичээлээр СЭДС-ийн хэд хэдэн хичээлийг дүйцүүлж байгаа тохиолдолд СЭДС-ийн хичээл бүрийн үнэлгээ нь дүйцүүлэх хичээлийн үнэлгээтэй адилхан байна.
- 5.7 Олон улсын шалгалтын А түвшний А үнэлгээг 95, В үнэлгээг 85, С үнэлгээг 75; AS түвшний А үнэлгээг 85 оноогоор тооцно.

ЗУРГАА. Хэлний шалгалтын оноог дүйцүүлэх

- 6.1 Мэргэжлийн суурь болон мэргэжлийн хичээлийн бүлэгтээ гадаад хэл судлуулахаар тусгасан бакалаврын сургалтын хөтөлбөрийн анхан шатны хэлний хичээлүүдийг харгалзах хэлний олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн шалгалтын оноогоор дүйцүүлэн тооцуулж болох боловч шалгалтын Оноо нь тухайн шалгалтаар авч болох хамгийн их онооны 60 хувиас багагүй байх тохиолдолд дүйцүүлэх боломж нээгдэнэ. Дүйцүүлэлт хийх үед тухайн шалгалтыг өгсөн тухай албан ёсны сертификатыг хавсаргана.
- 6.2 Дүйцүүлж болох олон улсын шалгалтын нэр, түвшин тогтоосон сертификатын хүчинтэй хугацаа болон дүйцүүлж болох хичээлийн нэр, багц цагийг мэргэжлийн тэнхим хэлэлцэж шийдвэрлэнэ.
- 6.3 СЭДС-ийн бакалаврын түвшний суралцагчид тавигдах гадаад хэлний ерөнхий шаардлагыг тухайн хэлний олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн шалгалтын оноогоор хангасанд тооцож болох ба 6.3-д заагдсанаас бусад тохиолдолд олон улсын шалгалтын оноогоор СЭДС-ийн хичээл дүйцүүлэхгүй.
- 6.4 Гадаад хэлний шалгалтын сертификатын оноогоор СЭДС-ийн ахисан түвшний хөтөлбөрийн хичээл дүйцүүлэхгүй.

ДОЛОО. Хичээл дүйцүүлэх үйл ажиллагаа

- 7.1 СЭДС-ийн хичээл дүйцүүлэлтийн үйл ажиллагааг Дүн, бүртгэл хариуцсан нэгж/ мэргэжилтэн нь суралцагч, мэргэжлийн тэнхимтэй хамтран зохион байгуулна.
- 7.2 Суралцагч хичээл дүйцүүлэх тухай өргөдлийг маягтын дагуу (Маягт 1) холбогдох материалуудын хамт дүн бүртгэл хариуцсан нэгжид гаргах ба дүн бүртгэл хариуцсан мэргэжилтэн өргөдлийг хянан үзэж, журмын шаардлага хангасан тохиолдолд хичээл дүйцүүлэлтийн маягтыг (Маягт 2) бөглөж харьяа тэнхимд хандана.
- 7.3 СЭДС-д дүйцүүлж буй хичээл нь СЭДС-ийн хичээл дүйцүүлэлтэд баримтлах зарчим болон харгалзах хичээлтэй агуулгаараа давхцаж байгаа эсэх (журмын 3-р бүлэг), багц цагийн хэмжээ нь шаардлага (журмын 4-р бүлэг) хангаж буй эсэх талаар тухайн хичээлийг хариуцан заадаг мэргэжлийн тэнхим (тэнхимийн эрхлэгч эсвэл тухайн хичээлийг заадаг багш)-ийн дүгнэлт/зөвшөөрлийг заавал авсан байх ба харгалзах тэнхимийн эрхлэгч нь баталгаажуулсан байна.
- 7.4 Журмын 7.3-д заасан мэргэжлийн тэнхимийн зөвшөөрөл бүхий дүйцүүлж болох хичээлийн дүнгийн дүйцүүлэлтийг энэхүү журмын 5-р бүлэгт заасан аргачлалын дагуу Дүн, бүртгэл хариуцсан мэргэжилтэн хийнэ.
- 7.5 Хичээл дүйцүүлэлтийн бөглөгдсөн маягтыг суралцагчийн зөвшөөрөл болон Дүн бүртгэл хариуцсан нэгжийн даргын баталгаажуулалтад үндэслэн дүн, бүртгэл хариуцсан мэргэжилтэн системд оруулна.
- 7.6 Зэргийн бус хөтөлбөрт хамрагдаад ирсэн суралцагчийн хичээлийг ирсэн улиралд нь дүйцүүлж оруулна.

НАЙМ. Бусад

- 8.1 Хичээл дүйцүүлэлтийн үйл ажиллагааг элссэн, ШИЛЖСЭН, эргэн суралцсан тухайн улиралд суралцагчийн хүсэлтээр нэг удаа хийнэ.
- 8.2 Хичээл дүйцүүлэлтийг аргачлалын дагуу зөв хийгээгүй тохиолдолд дүйцүүлэлтийг буцааж, дахин засварлаж оруулна.
- 8.3 Оюутан солилцооны болон бусад гэрээнд тусгайлан заагаагүй бол СЭДС -д хичээл дүйцүүлэхэд төлбөр авахгүй.
- 8.4 СЭДС-ийн хичээл дүйцүүлэх тухай гэрээ байгуулсан гэрээний дагуу судалсан ахлах сургууль, дээд боловсролын сургалтын байгууллага, бусад байгууллагад судалсан хичээлийг гэрээний дагуу тооцно.

1.5 Энэхүү журмаар зохицуулагдахгүй асуудал гарвал СЭДС-ийн захиргааны зөвлөл хэлэлцэж шийдвэрлэнэ.

Түгээмэл хэрэглэгддэг багц цаг болон СЭДС-ийн багц цагийн харьцааны

Монгол	ECTS	АНУ	БНХАУ	Энэтхэг	Япон	БНСУ	ОХУ	Австрали	Канад	Сингапур
1 багц цаг	2	1	1	1	1	1	2	2	0,17	1,6

*Улирлын багц цагт суурилсан кредит системтэй сургууль бол багц цагийг 3/2 коэффициентэд хувааж тооцно.

**Багц цагаар хэмжигддэггүй, танхимын цагаар тодорхойлогддог сургалтын системтэй бол 72 танхимын цагийг 1 багц цаг гэж үзнэ.

Хүснэгт 2-А. Ялгаатай дүнгийн шатлалыг СЭДС-ийн дүнгийн шатлалд хөрвүүлэх хүснэгт

Соёл Эрдэм ДС	Хувилбар 1	Хувилбар 2	Хувилбар 3	Хувилбар 4	
95-100	96-100	98-100	96,0-100,0		
		94-97		90-100	
90-94	91-95	91-93	90,0-95,9		
	88-90	88-90	87,0-89,9		
85-89	84-87	84-87	83,1-86,9	80-89	
80-84	81-83	81-83	80,0-82,9		
75-79	78-80	78-80	77,0-79,9		
70-74	74-77	74-77	73,0-76,9	70-79	
	71-73	71-73	70,0-72,9		
65-69	68-70	68-70	67,0-69,9		
60-64	64-67	64-67	63,0-66,9	60-69	
	60-63	60-63	60,0-62,9		
0-59	0-60	31-60	0-59,9	0-60	
		0-30			

СОЁЛ ЭРДЭМ ДЭЭД СУРГУУЛИЙН ОЮУТАН ТӨГСГӨХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1 СЭДС-ийн бакалаврын сургалтанд суралцаж зохих шаардлагыг хангасан оюутанд дээд боловсролын зэргийн диплом олгоход энэхүү журмыг мөрдөнө.
- 1.2 Төгсөгч нь зохих журмын дагуу СЭДС-ийн захирлын тушаалаар элссэн байна.
- 1.3 Төгсөлт хичээлийн жилийн намар, хаврын улиралд явагдана.
- 1.4 Сургууль төгсөлтийн буюу Улсын шалгалтын комисс, төгсөгчийн дүн тулгалтын комиссыг захирлын тушаалаар байгуулна.
- 1.5 Сургуулийн Сургалтын алба сургалтын төлөвлөгөөнд тусгасан авбал зохих кредитийг бүрэн цуглуулсан, үнэлгээний голч дүн 2.0-оос багагүй суралцсан оюутныг төгсөх оюутнаар бүртгэн авна.
- 1.6 Сургууль төгсөгч нь мэргэжил харгалзахгүй дипломын төсөл, ажил бичиж хамгаална.
- 1.7 Ахисан түвшний төгсөлтийн үйл ажиллагааг магистрын сургалтын журмаар зохицуулна.
- 1.8 Дүн тулгалтын комиссын тайлан, төгсөгчийн дүнгийн хавтгайг баталгаажуулан чанарын үнэлгээний алба хянана.
- 1.9 Оюутан дипломын ажлын сэдэв, удирдагчаа харьяалагдах тэнхимээс гаргасан хуваарийн дагуу тохирч тодорхойлсон байна.
- 1.10 Оюутан сургалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу дипломын ажлын кредитийн төлбөрийг төлсөн байна.
- 1.11 Төгсөх оюутны код, овог нэр, дипломын төсөл, ажлын сэдэв, удирдагч багшийн нэр, зөвлөх болон шүүмжлэгч нарын нэрс, дипломын төсөл, ажил хамгаалах хугацааг тодорхойлсон тушаалыг харьяа тэнхимүүд төлөвлөж Сургалтын алба нэгтгэн гаргана.

- 1.12 Тухайн улиралд бакалаврын зэрэгтэй төгсөхөөр бүртгүүлсэн төгсөгч оюутан нь дипломын төсөл, ажлаас гадна 13 хүртэлх кредитийн хичээл сонгож үзэх эрхтэй ба түүнд дээд боловсролын суурь ухааны нэгээс илүүгүй хичээлийг сонгон суралцахыг зөвшөөрнө.
- 1.13 Төгсөгчийн бичсэн дипломын төсөл, ажлын хуулбарлалтын хувийг диплом хамгаалалтаас өмнө заавал тогтоож холбогдох мэргэжлийн тэнхимээс дүгнэлт гаргасан байна.
- 1.14 Дипломын төсөл, ажлыг захирлын тушаалаар батлагдсан загварын дагуу бичиж хэвлүүлэн бакалаврын ажлыг цахим хэлбэрээр, магистрын ажлыг цахим болон цаасан хэлбэрээр тус тус номын санд өгч хадгалуулна.
- 1.15 Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 8.2.4-ийн дагуу төгсөгч нь даатгалд бүрэн хамрагдсан байна.
- 1.16 Улсын шалгалтын комисс нь төгсөлттэй холбоотой аливаа маргаан, санал, гомдлыг холбогдох журмын дагуу зохицуулна.

Хоёр. Дипломын төсөл, ажилд өгөх үэлгээ

- 2.1 Сургалтын албанаас дипломын хавсралтад бичигдэх дүнгийн тулгалт баталгаажуулагдсаны дараа тухайн оюутны нэрийг “Дипломын ажлын сэдэв, удирдагчийг батлах тухай” Захирлын тушаалд оруулна. Дүн тулгалт оюутны төгсөх улирлын өмнөх улиралд хийгдсэн байна. Тушаалд нэр нь ороогүй оюутан хамгаалалтад орохгүй. Төгсөгч оюутнаар бүртгэгдсэн оюутнаас өөрөө хүсэлт гаргасан тохиолдолд диплом, дипломын хавсралтын үнэт цаас, дипломын хавтасны үнийг хураан авч хамгаалалтаас 2 сарын өмнө Үнэт цаасны үйлдвэрт захиална.
- 2.2. Дипломын төсөл, ажлын явцын үнэлгээг дипломын гүйцэтгэлийг шалгах хэлэлцүүлгүүдийн үнэлгээний дундажаар тогтооно. Явцын хэлэлцүүлэг хийх тоо, хугацаа, үнэлэх хэлбэр, загварыг холбогдох тэнхимүүд тогтооно.
- 2.3 Дипломын төсөл, ажлын хамгаалалт Захирлын тушаалаар батлагдсан Улсын шалгалтын комиссууд удирдан явуулна. Комисс нь дарга, орлогч дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдсэн 5-7 хүний бүрэлдэхүүнтэй ажиллана.
- 2.4 Улсын шалгалтын комиссын дарга нь СЭДС-д үндсэн орон тоон дээр ажилладаггүй, гаднын байгууллагын эрдэмтэн байх ба комиссын нийт бүрэлдэхүүний 30-аас багагүй хувь нь гаднын гишүүдээс бүрдсэн байна.
- 2.5 Дипломын төсөл, ажлын хамгаалах хугацааг СЭДС-ийн тухайн хичээлийн жилийн сургалтын нэгдсэн хуанлид тусгасан байна.
- 2.6 Удирдагч багшийн үнэлгээ: Багшийн үнэлгээний дээд оноо 50 байх бөгөөд ямар шалгуураар төгсөх оюутны дипломын төсөл, ажлыг үнэлэхээ тэнхим дээр зөвшилцсон байна. Удирдагч багш урьдчилсан хамгаалалтаас нэг долоо хоногийн өмнө төгсөх оюутны үнэлгээг, тодорхойлолтын хамт Дипломын төсөл, ажил хамгаалалтын комиссын нарийн бичгийн даргад хүргүүлнэ.
- 2.7 Урьдчилсан хамгаалалт: Урьдчилсан хамгаалалтыг холбогдох тэнхим, салбар комиссын нарийн бичгийн дарга нар хариуцан зохион байгуулж, дипломын төсөл, ажлын хамгаалалтаас нэг долоо хоногийн өмнө зарлан хуралдуулна. Урьдчилсан хамгаалалтаар төгсөх оюутанд олгох оноо нь 20 хүртэл байх бөгөөд ажлын гүйцэтгэл, хамгаалсан байдлаас шалтгаалан удирдагч багшийн үнэлгээг бууруулж болно.
- 2.8 Удирдагчийн болон урьдчилсан хамгаалалтын дүнгийн нийлбэрийг төгсөх оюутны дипломын төсөл, ажил хамгаалалтын урьдчилсан дүн гэнэ. Энэ үед мөн төгсөх оюутны дипломын төсөл, ажлын гүйцэтгэлийг хангалтгүй гэж үзвэл “SP”, “NP” тэмдэглэгээ тавьж болно. “SP” satisfactory progress – тэмдэглэгээг оюутны дипломын төсөл, ажлаа хамгаалах хугацаа болсон байхад ажлын гүйцэтгэл дутуу хэдий ч (75 хувиас дээш тохиолдолд) цаашид бие даан ажиллаж тодорхой үр дүнд хүрэх боломжтой гэж удирдагч багш үзэж зөвшөөрвөл, төгсөгч оюутны дүнгийн хуудсанд “SP” тэмдэглэгээг тавьж болно. Энэ тохиолдолд оюутны дипломын төсөл, ажлын сэдэв болон удирдагч багшийг өөрчлөхгүй ба оюутан нэг улирлын дотор нэмж 2 кредитийн төлбөр төлснөөр дипломын төсөл, ажлаа хийж гүйцэтгэн хамгаалалтад орох эрхтэй. “NP” No progress тэмдэглэгээг оюутны дипломын төсөл, ажлаа хамгаалах хугацаа болсон байхад ажлын гүйцэтгэл дутуу (75 хувиас доош тохиолдолд) удирдагч багш нь оюутнаа цаашид энэ ажлыг дуусгах чадваргүй гэж дүгнэвэл, төгсөгч оюутны дүнгийн хуудсанд “NP” тэмдэглэгээг тавих болно. Энэ тохиолдолд оюутны дипломын төсөл, ажлын сэдэв болон удирдагч багш
- 2.9 Төгсөх оюутны диплом дээр бичигдэх албан ёсны төгсөлтийн голч оноо болон голч дүн, диплом хамгаалалтын үнэлгээ БШУ-ы Сайдын 2024 оны 03 сарын 20-ы өдрийн А/144 тоот тушаалын дагуу үнэлж, тодорхойлно.

Гурав. Дипломын төсөл, ажил хамгаалах

- 3.1. Сургалтын алба улсын шалгалтын комисст хуралдаан эхлэхээс өмнө дараах бичиг баримтыг бүрдүүлэн өгсөн байна.
 1. Төгсөх оюутны нэрсийн жагсаалт, захирлын тушаалаар
 2. Төгсөх оюутнуудын сурлагын дүнгийн жагсаалт – дүнгийн хавтгай
- 3.2. Дипломын төсөл, ажлыг комиссын гишүүдийн гуравны хоёроос доошгүй ирцтэйгээр хамгаалуулна. Шалгалтанд оролцсон сургуулийн төв ба салбар комиссын гишүүдийн ирцийг комиссын нарийн бичгийн дарга ирсэн, явсан цагаар нь бүртгэнэ. Комиссын нарийн бичгийн даргад шалгалт үргэлжилсэн хугацаанаас 2 цагийг илүү тооцно.
- 3.3. Дипломын төсөл, ажлын хамгаалалтын хурлыг комиссын дарга, түүний эзгүйд орлогч дарга удирдана.
- 3.4. Дипломын төсөл, ажлын хамгаалалтыг комиссын нээлттэй хуралдаанаар хэлэлцэж, дүн тавих үед хаалттай явуулна. Хамгаалалтын дүнг комиссын хурлын тэмдэглэл гарсны дараа тэр өдөрт нь багтааж оюутнуудад албан ёсоор мэдэгдэнэ.
- 3.5. Төгсөх оюутан нь дипломын төсөл, ажлаа хамгаалахдаа 10 минутад багтаан илтгэлээ тавих бөгөөд салбар комиссын нарийн бичгийн дарга удирдагч багшийн тодорхойлолтыг уншиж танилцуулна. Комиссын гишүүд дипломын төсөл, ажлын болон төгсөж буй оюутны суралцсан мэргэжлийн сургалтын төлөвлөгөөний хүрээнд асуулт тавьж хариулт авна.
- 3.6. Комисс төгсөж буй оюутны илтгэл, асуултад хариулсан байдал, шүүмж, удирдагч багшийн тодорхойлолт зэргийг үндэслэн, дипломын төсөл, ажлын хамгаалалтын дүнг ± 30 хүртэл оноогоор дүгнэх бөгөөд шаардлагатай гэж үзвэл урьдчилсан хамгаалалтын дүнг бууруулж болно.
- 3.7. Шүүмжлэгч төгсөгч оюутны ажлыг уншиж танилцан 30 хүртэлх оноогоор дүгнэх ба энэ үнэлгээг хамгаалалтын үнэлгээнд оруулан тооцно.
- 3.8. Хамгаалалтын үнэлгээг комиссын гишүүд тус бүрдээ тавьж, ерөнхий үнэлгээг шүүмжлэгчийн үнэлгээг ороцуулан тэдгээрийн дундажаар гаргаж шийдвэрлэнэ.
- 3.9. Төгсөх оюутан дипломын төсөл, ажлыг “С” ба түүнээс дээш дүнтэй хамгаалах үүрэгтэй. Дипломын төсөл, ажлаа “С”-ээс доош үнэлгээгээр амжилтгүй хамгаалсан оюутныг төгсөхийг тодорхой хугацаагаар хойшлуулах ба уг хугацааг улсын шалгалтын комиссоос тогтоон, энэ тухай тогтоолд тусгана.

Дөрөв. Боловсролын диплом олгох

- 4.1 Төгсөлтийн ёслолын үйл ажиллагааг тусгай удирдамжийн дагуу зохион байгуулна.
- 4.2 Дипломын төсөл, ажлаа амжилттай хамгаалсан оюутанд улсын шалгалтын комиссын шийдвэрийг үндэслэн СЭДС-ийн Захирлын тушаалаар мэргэжил, боловсролын зэрэг, түүнийг гэрчлэх диплом, энгэрийн тэмдэг олгох ба энэ тухай төгсөгчдийг бүртгэх тусгай дэвтэрт бүртгэсэн байна.
- 4.3 Төгсөгчдөд олгох диплом, дүнгийн хавсралтыг БШУ-ы Сайдын 2024 оны 03 сарын 20-ы өдрийн А/143 тоот тушаалд заасан журмын дагуу олгоно.
- 4.4 Улсын шалгалтын комисс нь шалгалт дууссаны дараа тайлан бичиж сургуулийн захиргаанд өгөх ба бэлтгэж байгаа мэргэжилтний чанарын түвшин, сургалтын агуулга технологийн талаар дүгнэлт өгч, ажлыг цаашид сайжруулах арга хэмжээний талаар тодорхой санал, зөвлөмжийг тайландаа оруулсан байвал зохино.
- 4.5 Улсын шалгалтын комисс нь дараах бичиг баримтыг бүрдүүлж сургалтын албанд хүлээлгэн өгнө. Үүнд:
 - Улсын шалгалтын комиссын хурлын тогтоол;
 - Дипломын төсөл, ажил хамгаалуулсан шийдвэр - нэгдсэн дүнгийн хуудас;
 - Комиссын гишүүдээс өгсөн дүнгийн хуудас;
 - Комиссын хурлын протокол /оюутан бүрийг хамруулна/;
 - Комиссын гишүүдийн ирцийн бүртгэл зэрэг болно.
- 4.6 Сургалтын алба төгсөлтийн үйл ажиллагааны дараа сургуулийн архивт төгсөж байгаа оюутантай холбогдсон дараах материалыг бүрдүүлж өгнө. Үүнд:
 1. Элсэлтийн шалгалтын дүнгийн хуудас
 2. Төгсөх үеийн анкет
 3. Дипломын хуулбар
 4. Сурлагын дүнгийн эх хувь -1 ш /дипломын хавсралт/
 5. Оюутны үнэмлэх
 6. Улсын шалгалтын комиссын протокол
 7. Тойрох хуудас
- 4.7 Төгсөлтийн баримт бичгийг засварлах буюу хуурамчаар үйлдвэл зохих хуулийн хариуцлагыг хүлээнэ.

Тав. Боловсролын дипломыг шинэчлэн солих, дахин олгох

- 5.1 Блокчейнд баталгаажсан дипломыг иргэн өөрийн эрхээр нэвтэрч хэвлэн ашиглана.
- 5.2 Блокчейнд баталгаажихаас өмнөх үеийн дипломыг иргэн үрэгдүүлсэн, гэмтээсэн, хувийн мэдээлэлд өөрчлөлт орсон тохиолдолд сургууль дахин олгоно.
- 5.3 Дээд боловсролын диплом, дипломын хавсралтыг шинэчлэн солиулах, дахин авах хүсэлт гаргасан төгсөгч дараах материалыг бүрдүүлсэн байна. Үүнд:
- Диплом дахин авах болсон шалтгаанаа бичсэн хүсэлт
 - Хуучин диплом, дипломын хавсралтын эх хувь (Шинэчлэн авах үед),
 - Гээсэн ба үрэгдүүлсэн тохиолдолд энэ тухай сонинд зарлуулсан бичиг,
 - Овог нэр сольсон бол нотлох баримтын хуулбар,
 - Диплом хэвлэх, дахин олгох зардал төлсөн баримт (Хураамжийн хэмжээ нь тухайн жилийн 5 кредитийн үнэлгээтэй тэнцүү байна).
- 5.4 Сургалтын алба нь шинэчлэн солих, дахин олгох ажлыг хариуцан гүйцэтгэнэ.
- 5.5 Дахин олгогдох дипломд төгссөн үеийн захирлын тушаалын огноог тавина.
- 5.6 Иргэнд анх олгосон дипломын улсын дугаар дахин олгох дипломд хэвээр хадгалагдана.
- 5.7 Иргэнд анх олгосон дипломын дугаар тодорхойгүй тохиолдолд шинэ дипломын дугаар тавигдана.
- 5.8 Үнэлгээг хөрвүүлэн солиулж буй дипломын хавсралт дахь хичээлийн кредитийг одоогийн мөрдөж буй сургалтын төлөвлөгөөг үндэслэн, тухайн тэнхимийн эрхлэгч шийдвэрлэн тавих бөгөөд тухайн хичээл бүрийн хуучин үнэлгээг “Оюутны мэдлэгийг үнэлэх журам”-ын дагуу шинэчлэн хөрвүүлнэ.
- 5.9 Холбогдох материалтай танилцсаны эцэст дээд боловсролын дипломыг шинэчлэн солих, дахин олгох тухай асуудлыг Сургалтын алба эцэслэн шийдвэрлэж, Захирлын тушаал гаргана.
- 5.10 Шинэчлэн солиулж буй диплом, дипломын хавсралтын хуучин эх хувийг хураан авна. Дахин олгож буй диплом дээр “Дахин олгов” тэмдэг дарна.
- 5.11 Диплом дахин олгосон бүртгэлийн хөтлөн, холбогдох бичиг баримтын хамт архивт хадгална.

СОЁЛ ЭРДЭМ ДЭЭД СУРГУУЛИЙН ОЮУТАН СУРАЛЦАГЧДЫН ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэ дэг нь СОЁЛ ЭРДЭМ ДЭЭД СУРГУУЛЬ-ийн оюутан суралцагчдын ёс зүйтэй холбоотой харилцааг зохицуулна.
- 1.2. Уг дэг оюутан суралцагчдыг ёс зүйн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, зөрчлийг цаг алдалгүй таслан зогсоох, зөрчлийн улмаас хамт олон, сургуульд учирсан хохирлыг нөхөн барагдуулах хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх зорилготой.
- 1.3. СОЁЛ ЭРДЭМ ДЭЭД СУРГУУЛЬ-ийн дүрэм, дотоод журмын хэрэгжилт, оюутны байгууллагаас захиргаатай байгуулсан гэрээг хэрэгжүүлэх ажлыг уг дэгээр чиглүүлнэ.
- 1.4. Оюутны зөвлөл, сургалтын алба, ангийн зөвлөх багш болон нийт багш ажилтнууд ёс зүйн дэгийг мөрдүүлэхэд шаардлага тавьж ажиллана.

Хоёр. Оюутан суралцагчдын ёс зүйн асуудлыг шийдвэрлэх тухай

- 2.1 СОЁЛ ЭРДЭМ ДЭЭД СУРГУУЛЬ-ийн Оюутны зөвлөл, ангийн ахлагч нар ёс зүйн зөрчил гаргасан оюутны асуудлыг зөвлөл болон ангийн хурлаар авч хэлэлцэж, гаргасан шийдвэрээ сургуулийн удирдлагад танилцуулж шийдвэрлүүлнэ.
- 2.2 Оюутны зөвлөлийн хурлын саналыг нууцаар хураана.
- 2.3 Ёс зүйн зөрчлийн улмаас сахилгын шийтгэл хүлээсэн оюутан суралцагч 48 цагийн дотор Соёл Эрдэм дээд сургуулийн захиралд давж мэдүүлж болно.

Гурав. Оюутан суралцагчийн ёс зүйн зөрчлийн зарим хэлбэр хүлээлгэх арга хэмжээ

- 3.1 Ёс зүйн зөрчил гэдэг ойлголтонд ёс зүйн үндсэн зарчмуудад болон нийгмийн зан суртахууны түгээмэл хэм хэмжээнд харшилсан үйлдлүүд орно.

№	Зөрчлийн хэлбэр	Хүлээлгэх арга хэмжээ
1	Улиралд 12 хүртэл цагийн хичээл тасалж, ангийн зөвлөх багшийн зөвлөмжийг удаа дараа биелүүлээгүй	Ангийн хурлаас, сануулах, ар гэрийнхэнд нь мэдэгдэх

2	Багш, ажилтан, ажилчдаас тавьсан зүй ёсны шаардлага биелүүлээгүй	Ангийн хурлаар оруулж сануулах Ёс зүйн зөрчлийг тэмдэглэх, удаа дараа давтагдвал оюутны
3	Хичээл дээр бохь зажилсан, гар утас хэрэглэсэн, шуугин үймүүлж бусдын анхаарлыг сарниулах зэрэг хичээл дээр дэг журам зөрчсөн.	Зөвлөлийн хурлаар оруулж хэлэлцэх
4	Сургуулийн орчинд тамхины иш, хог цаас хаях, шүлс цэр хаясан Бусдыг дарамталж сүрдүүлсэн, бүдүүлэг үг хэллэг хэрэглэж хэл амаар доромжилсон, багш оюутны биед халдсан	Тэнхмийн хурлаар оруулж арга хэмжээ авах
5	Хичээлд удаа дараа байнга хоцорч ирдэг.	Тэнхмийн хурлаар оруулж арга хэмжээ авах
6	Сургуулийн анги танхмийг цэвэрлээгүй зэрэг жижүүрийн үүргээ удаа дараа гүйцэтгээгүй	Тэнхмийн хурлаар оруулж арга хэмжээ авах
7	Сургуулийн хичээлийн болон дэвсгэр нутагт архиан согтуурах, мансууруулах бодис хэрэглэх	Ёс зүйн хорооны хурлаар оруулж арга хэмжээ авах, удирдлагад мэдээлэх

	Сургалтын	алба,	факультет,	тэнхимын	Тэнхмийн хурлаар оруулж арга
8	удирдлагаас	өгсөн	үүрэг,	зөвлөмжийг	хэмжээ авах
9	Сургуулийн	болон	бусдын	эд хогшлыг	Ёс зүйн хороогоор оруулж, арга хэмжээ авах, хохирлыг төлүүлэх
10	хичээлийн хэрэгсэл, үзүүлэн, цахим техник хэрэгслийг эвдэж гэмтээсэн, үрэгдүүлсэн	хулгайлах			Тэнхмийн хурлаар оруулж, арга хэмжээ авах, холбогдох хохирлыг төлүүлэх ноцтой бол захирлын зөвлөлийн хурлаар оруулах
11	Номын сангийн номын хуудсыг урж гэмтээсэн				Тэнхмийн хурлаар оруулж, засвар хийлгэх хохирол төлүүлэх
12	Ангийн болон тэмцээн уралдааны фондыг үрж шамшигдуулсан				Тэнхмийн хурлаар оруулж, төлбөр төлүүлэх
13	Танилцах хуурамч хийсэн	болон	үйлдвэрлэлийн	дадлага	Тэнхмийн хурлаар оруулж кредит цаг хасуулах
14	Хүндэтгэн	үзэх	шалтгаангүйгээр	дахин	Факультет, тэнхмийн хурлаар оруулах, шалгалт гүйцээн авах, торгох
15	Ёс зүйн зөрчлийг 3-аас дээш гаргасан				Ёс зүйн хороогоор оруулах, сургуулиас хасах хүртэл арга хэмжээ авах
16	Сонгуульт албаа урвуулан ашигласан				Оюутны зөвлөлийн хурлаар оруулах, огцруулах
	Эрүүгийн гэмт хэрэгт холбогдсон болох нь				Захирлын зөвлөлийн хурлаар

17						оруулж, хуулийн байгууллагад шилжүүлэх, сургуулиас хасах		
	тогтоогдсон							
	Хамт олны дунд хов жив хутгаж, үндэслэлгүй					Ёс зүйн хороогоор оруулж арга		
18	цуу яриа дэгдээсэн нь ноцтой үр дагаварт					хэмжээ авах		
	хүргэсэн бол							
	Сургууль болон сургуулиас зохиож байгаа олон					Захирлын	зөвлөлийн	хурлаар
19	нийтийн газарт согтууруулах ундаа хэрэглэсэн, хэв журмын зөрчил гаргасан					оруулж арга хэмжээ авах		
20	Бусдыг айлган сүрдүүлсэн, дарамталсан эрх чөлөөнд нь халдсан					Захирлын	зөвлөлийн	хурлаар
						оруулж арга хэмжээ авах		
21	Бусдыг санаатай гүтгэсэн, нэр төрийг гутаасан					Ёс зүйн хорооны хурлаар оруулж арга хэмжээ авах		
22	Багш, ажилтан, эрх		бүхий хүмүүст		хандан	Ёс зүйн хорооны хурлаас арга хэмжээ авах		
	авилгал өгөх буюу өгөхийг завдах							
23	Ёс зүйн зөрчил гаргасан этгээдийг мэдсэн атлаа нуун дарагдуулсан бол					Ёс зүйн хорооны хурлаас арга хэмжээ авах		

№	Зөрчлийн хэлбэр					Хүлээлгэх арга хэмжээ			
1	Улиралд 12 хүртэл цагийн хичээл тасалж, ангийн зөвлөх багшийн зөвлөмжийг удаа дараа биелүүлээгүй					Ангийн хурлаас, сануулах, ар гэрийнхэнд нь мэдэгдэх			
2	Багш, ажилтан, ажилчдаас тавьсан зүй ёсны шаардлага биелүүлээгүй					Ангийн хурлаар оруулж сануулах			
3	Хичээл дээр бохь зажилсан, гар утас хэрэглэсэн, шуугин үймүүлж бусдын анхаарлыг сарниулах зэрэг хичээл дээр дэг журам зөрчсөн.					Ёс зүйн зөрчлийг тэмдэглэх, удаа дараа давтагдвал оюутны зөвлөлийн хурлаар оруулж хэлэлцэх			
4	Сургуулийн орчинд тамхины иш, хог цаас хаях, шүлс цэр хаясан Бусдыг дарамталж сүрдүүлсэн, бүдүүлэг үг хэллэг хэрэглэж хэл амаар доромжилсон, багш оюутны биед халдсан					Тэнхмийн хурлаар оруулж арга хэмжээ авах			
5	Хичээлд удаа дараа байнга хоцорч ирдэг.					Тэнхмийн хурлаар оруулж арга хэмжээ авах			
6	Сургуулийн анги танхмийг цэвэрлээгүй зэрэг жижүүрийн үүргээ удаа дараа гүйцэтгээгүй					Тэнхмийн хурлаар оруулж арга хэмжээ авах			
	Сургуулийн хичээлийн болон дэвсгэр нутагт					Ёс зүйн хорооны хурлаар оруулж			
7	архидан согтуурах,		мансууруулах		бодис	арга	хэмжээ	авах,	удирдлагад
	хэрэглэх					мэдээлэх			
	Сургалтын	алба,	факультет,		тэнхимын	Тэнхмийн хурлаар оруулж арга			
8	удирдлагаас	өгсөн	үүрэг,		зөвлөмжийг	хэмжээ авах			
	биелүүлээгүй								
9	Сургуулийн	болон	бусдын	эд	хогшлыг	Ёс зүйн хороогоор оруулж, арга			
	хулгайлах					хэмжээ авах, хохирлыг төлүүлэх			
						Тэнхмийн хурлаар оруулж,			
	Сургуулийн эд хогшил, ширээ сандал,					арга	хэмжээ	авах,	холбогдох

10	хичээлийн хэрэгсэл, үзүүлэн, цахим техник					хохирлыг төлүүлэх ноцтой бол				
	хэрэгслийг эвдэж гэмтээсэн, үрэгдүүлсэн					захирлын		зөвлөлийн		хурлаар
						оруулах				
11	Номын сангийн номын хуудсыг урж гэмтээсэн					Тэнхмийн		хурлаар		оруулж,
						засвар хийлгэх хохирол төлүүлэх				
12	Ангийн болон тэмцээн уралдааны фондыг үрж					Тэнхмийн		хурлаар		оруулж,
	шамшигдуулсан					төлбөр төлүүлэх				
13	Танилцах	болон	үйлдвэрлэлийн		дадлага	Тэнхмийн		хурлаар		оруулж
	хуурамч хийсэн					кредит цаг хасуулах				
	Хүндэтгэн	үзэх	шалтгаангүйгээр		дахин	Факультет,		тэнхмийн		хурлаар
14	шалгалт, нөхөн шалгалтыг тогтоосон хугацаанд					оруулах, шалгалт гүйцээн авах,				
	өгөөгүй					торгох				
	Ёс зүйн зөрчлийг 3-аас дээш гаргасан					Ёс	зүйн	хороогоор		оруулах,
15										
	тохиолдолд					хэмжээ авах				

16	Сонгуульт албаа урвуулан ашигласан				Оюутны	зөвлөлийн	хурлаар	
					оруулах, огцруулах			
17	Эрүүгийн гэмт хэрэгт холбогдсон болох нь тогтоогдсон				Захирлын зөвлөлийн хурлаар оруулж, хуулийн байгууллагад шилжүүлэх, сургуулиас хасах			
18	Хамт олны дунд хов жив хутгаж, үндэслэлгүй цуу яриа дэгдээсэн нь ноцтой үр дагаварт хүргэсэн бол				Ёс зүйн хороогоор оруулж арга хэмжээ авах			
19	Сургууль болон сургуулиас зохиож байгаа олон нийтийн газарт согтууруулах ундаа хэрэглэсэн, хэв журмын зөрчил гаргасан				Захирлын зөвлөлийн хурлаар оруулж арга хэмжээ авах			
20	Бусдыг айлган сүрдүүлсэн, дарамталсан эрх чөлөөнд нь халдсан				Захирлын зөвлөлийн хурлаар оруулж арга хэмжээ авах			
21	Бусдыг санаатай гүтгэсэн, нэр төрийг гутаасан				Ёс зүйн хорооны хурлаар оруулж арга хэмжээ авах			
22	Багш, ажилтан, эрх бүхий хүмүүст хандан авилгал өгөх буюу өгөхийг завдах				Ёс зүйн хорооны хурлаас арга хэмжээ авах			
23	Ёс зүйн зөрчил гаргасан этгээдийг мэдсэн атлаа нуун дарагдуулсан бол				Ёс зүйн хорооны хурлаас арга хэмжээ авах			

Тайлбар:

- Зөрчлийн хэмжээ, үр дагаврыг харгалзан шийтгэлийн хөнгөн, хатуу хэлбэрийг хэрэглэнэ. Хөнгөн хэлбэрт амаар буюу бичгээр сануулга, анхааруулга өгөх, уучлал гуйлгах арга хэмжээ орно.
- Учруулсан хохирлыг төлүүлнэ. Ингэхдээ эрх бүхий субъектээс шийдвэр гаргана.
- Сургуулиас хасах шийдвэрийг ёс зүйн хорооноос буюу захирлын зөвлөлөөс гаргана. Ёс зүйн хорооноос гаргасан шийдвэрийг захирлын зөвлөл хэлэлцэж баталгаажуулах буюу цуцална. Цуцалсан нөхцөлд өөр тохирсон шийтгэлийг оногдуулна.
- Эрүү, иргэний хуулиар шийтгэгдэх ёстой зөрчлийг сургуулийн субъектүүд авч хэлэлцэхгүй бөгөөд хуулийн байгууллагад шилжүүлэн шийдвэрлүүлнэ.

СОЁЛ ЭРДЭМ ДЭЭД СУРГУУЛИЙН ХИЧЭЭЛИЙН БАЙРАНД МӨРДӨХ ДЭГ

Нэг. Нийтлэг зүйл

- 1.1. Энэхүү дэг нь сургуулийн эрхэм зорилгын салшгүй хэсэг болсон ёс суртахуун, гоо зүйн хүмүүжлийг суралцагчдад төлөвшүүлж, хичээлийн байрны дэг журмыг хангахад чиглэгдэнэ.

Хоёр. Хичээллэх дэг

- 2.1. Хичээлийн шинэ жил 9 дүгээр сарын 1-нд эхлэх бөгөөд 2 улиралтай болно. Танхимд хичээллэх бүх төрлийн хичээл (ганцаарчилсан хичээлээс бусад) хоорондоо 10 минутын завсарлагатай 90 минутаар үргэлжилнэ.
- 2.2. Сургалтын төлөвлөгөөг үндэслэн Сургалтын албанаас батласан хичээлийн хувиараар хичээллэнэ. Хичээлийн хуваарийг (хагас жил тутам) сургалтын менежер, тэнхмийн эрхлэгчтэй хамтран боловсруулах ба багш, оюутны цагийн ачааллыг оновчтой хуваарилах үүрэг хүлээнэ.
- 2.3. Шаардлагатай тохиолдолд тэнхмийн эрхлэгч нь хуваарьт хичээлийг өөр багшаар заалгах, сургалтын менежертэй зөвшөөрөөр хичээлийн хуваарийг өөрчилж болно. Хичээлийн хуваарийн хэрэгжилтэнд сургалтын менежер, тэнхмийн эрхлэгчид хяналт тавина. Тэд хичээлийн хуваарь зөрчсөн, хуваарьт анги болон танхимд хичээл ороогүй, хожимдож орсон, түрүүлж завсарласан хичээлийг тасарсанд тооцох эрхтэй.
- 2.4. Сургалтын менежер болон захирлын зөвшөөрөлгүйгээр хичээлийн цагаар багш, оюутныг хичээлээс хөндийрүүлэх, тэднээр өөр ажил гүйцэтгүүлэхийг хориглоно. Хичээлд гадны хүн суух зайлшгүй шаардлага гарвал сургалтын менежерээс, эсвэл захирлаас зөвшөөрөл авна.
- 2.5. Тэнхмийн лаборант нар хичээл эхлэхээс өмнө ирж, хичээлийн танхим, тухайн хичээлд шаардагдах эд зүйлс, техник хэрэгслийг бэлэн болгохын зэрэгцээ, өөрийн салбарын нийтийн эзэмшилд буй эд хөрөнгө, хогшлыг бүрэн бүтэн байлгах асуудлыг биечлэн хариуцна. Тэнхмийн эрхлэгч 16 цаг хүртэл ажлын байрандаа байх ба багш, ажилтнуудын ажлын цагийн гүйцэтгэлд сургалтын албаны дарга, сургалтын менежер, захирлын нарийн бичгийн дарга хяналт тавина.
- 2.6. Хичээлийн дундуур багш, оюутнуудыг гар утсаар ярихыг хориглох ба багш хоцорсон оюутныг хичээлд оруулахгүй байх эрхтэй.
- 2.7. Соёл Эрдэм дээд сургуулийн үндсэн багш нь хуваарьт хичээллэлт, дэг журам, захирлын тушаалыг мөрдүүлэх зорилго бүхий жижүүр багшийн үүрэг гүйцэтгэнэ.
- 2.8. Анги бүлэг бүр захирлын тушаалаар томилогдсон зөвлөх багш, ангийн ахлагчтай байна.
- 2.9. Зөвлөх багш ангийнхаа оюутнуудад зөвлөгөө өгөх, бие дааж сурах, хөдөлмөрлөх, соёл хүмүүжлийн ажилд нь туслах үүрэгтэй ба ангийнхаа тохижилт, эд хогшлын бүрэн бүтэн байдал, ариун цэвэрт хяналт тавин ажиллана.

Гурав. Хичээлийн байранд баримтлах дэг

- 3.1. Хичээлийн байрны дэг зөрчигчдөд зарчмын шаардлага тавих нь хүн бүрийн үүрэг болно.
- 3.2. Хичээлийн байранд хориглох зүйл:
- Ангид малгай, гадуур хувцастай суух;
 - Хичээлийн үед бусдад нөлөөлөхүйц чанга ярих, шуугих, сэлгүүцэх, дуу хөгжим чанга дугаргах;
 - Зориулалтын бус газар цаас, хог хаях, цонхны тавцан дээр суух, хана налах, эд юмс дээр эрээчих, гэмтээх, захиргаа, эд хариуцагчийн зөвшөөрөлгүй эд хөрөнгө шилжүүлэн зөөх, авч гарах;
 - Хуваарьт өрөө, байрыг дур мэдэн солих, зориулалтын бусаар ашиглах;
 - Согтууруулах ундаа хэрэглэх, тамхи татах, бохь захилах;
 - Цонх, салхивч, усны цорго онгойлгох;
 - Сургалт, хүмүүжлээс ангид улс төр, шашны элдэв сурталчилгаа явуулах зэрэг болно.
- 3.3. Сургуулийн жижүүр үнэмлэхгүй оюутан, ажилчдыг нэвтрүүлэхгүй байх эрхтэй бөгөөд оюутнууд тусгайлсан шаардлагагүйгээр оройн 20 цагаас хойш болон амралт, ёслолын өдөр багшгүй, эсвэл захирлын бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр хичээлийн байранд байхыг хориглоно.
- 3.4. Анги, танхимыг багш, оюутнууд захирлын зөвшөөрөлгүйгээр сургалтын бус зориулалтаар ашиглах, гадны хүмүүст ашиглуулахыг хориглоно.
- 3.5. Ажил, хичээлгүй үед багш, ажилтнууд өрөө, байраа шалган түгжиж, түлхүүрээ сургуулийн жижүүрт хүлээлгэн өгнө.
- 3.6. Анги, танхимын цэвэрлэгээ, эд хогшлын бүрэн бүтэн байдлыг холбогдох ангийн оюутнууд, тэнхим, удирдлага, албадын өрөө, номын сан, нийтийн үйл ажиллагаанд зориулагдсан танхим, ариун цэврийн өрөө, талбайн цэвэрлэгээг үйлчлэгч хариуцна.
- 3.7. Хичээлийн байранд гарсан аливаа осол, зөрчлийг мэдсэн хүн жижүүрт тэр даруй мэдэгдэж байна.

СОЁЛ ЭРДЭМ ДЭЭД СУРГУУЛИЙН ОЮУТНЫГ УРАМШУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. СОЁЛ ЭРДЭМ ДЭЭД СУРГУУЛЬ-ийн тэргүүний оюутнуудыг шагнаж урамшуулахад энэхүү журмын зорилго оршино.

Хоёр. Урамшуулал болон шагнал

2.1 “Урамшууллын болзол хангасан оюутнуудын материалыг хичээлийн жилийн 15 дугаар долоо хоногоос эхлэн Оюутны зөвлөл, Сургалтын албанд хүлээн авна.

Кредитийн урамшууллын төрөл, хэмжээ

1. Шилдэг суралцагч

- 1 улирал 3.6-аас дээш үнэлгээний голч дүнтэй суралцсан 1 кр
- 2 улирал дараалан 3.6-аас дээш үнэлгээний голч дүнтэй суралцсан 2 кр хүртэл
- 3 улирал дараалан 3.6-аас дээш үнэлгээний голч дүнтэй суралцсан 3 кр хүртэл
- Хичээлийн улирлын турш 100 хувийн ирцтэй суралцсан 1 кр хүртэл

Эрдэм шинжилгээний хурал, олимпиад тэмцээнд оролцож 1-2-р байр эзэлсэн

- СЭДС-ийн эрдэм шинжилгээний хурал, чуулган, олимпиад 1 кр хүртэл
- Улсын чанартай эрдэм шинжилгээний хурал, чуулган, олимпиад 2 кр хүртэл
- Олон улсын эрдэм шинжилгээний хурал, чуулган, олимпиад 3 кр хүртэл

2. Спортын уралдаан, тэмцээнд оролцож 1-2-р байр эзэлсэн

- Их, дээд сургуулиудын оюутны тэмцээн 2 кр хүртэл
- Улсын чанартай тэмцээн, лигийн тэмцээн 2 кр хүртэл
- Олон улсын чанартай тэмцээн 2 кр хүртэл

3. Соёл, урлагийн уралдаан, тэмцээнд оролцож 1-2-р байр эзэлсэн

- Улсын хэмжээний уралдаан, тэмцээн 2 кр хүртэл
- Олон улсын хэмжээний соёл, урлагийн уралдаан, тэмцээн 3 кр хүртэл

4. Оюутны зөвлөлийн ажилд

- Сургуулийн оюутны зөвлөлийн дарга 3 кр хүртэл
- Оюутны зөвлөлийн гишүүн /2 хүртэлх оюутан/ 2 кр хүртэл

1.1. Эдээр урамшууллыг аливаа зээл тусламжаар суралцаж буй оюутнуудад бэлэн мөнгөөр олгож, бусад тохиолдолд урамшууллын хэмжээгээр сургалтын төлбөрт нь хөнгөлөлт үзүүлнэ.

Гурав. Сургалтын төлбөрийн хөнгөлөлт болон тэтгэлэг

3.1. Зуны хугацаанд жуулчны баазад мэргэшүүлэх дадлагыг амжилттай дуусгасан оюутныг Удирдах зөвлөлийн даргын шийдвэрээр урамшуулна.

3.2. Нэг өрх айлын хоёр суралцагч тус сургуульд элсэн суралцаж байгаа тохиолдолд тодорхой хэмжээний хөнгөлөлт үзүүлэх асуудлыг тухайн суралцагчийн гаргасан өргөдлийн дагуу Захиргааны Зөвлөл шийдвэрлэнэ.

3.3. Тус сургуулийн багш ажилтны хүүхэд, нөхөр, эхнэр элсэн суралцаж байгаа бол тухайн оюутанд сургалтын төлбөрийн 30%-ийн хөнгөлөлт үзүүлнэ.

**ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН СУРАЛЦАГЧИД ТЭТГЭЛЭГ, ЗЭЭЛ,
БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖ ОЛГОХ, ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ, ЗЭЭЛ ЭРГЭН ТӨЛҮҮЛЭХ ЖУРАМ**

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Гадаадын болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллага (цаашид “сургалтын байгууллага” гэх)-ын суралцагчид тэтгэлэг, сургалтын зээл, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх, сургалтын зээлийг эргэн төлүүлэхтэй холбогдох харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2.Суралцагчийн тэтгэлэг, сургалтын зээл, буцалтгүй тусламж, дэмжлэг үзүүлэх, сургалтын зээлийг эргэн төлүүлэх үйл ажиллагаанд Боловсролын ерөнхий хууль, Дээд боловсролын тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, энэ журмыг баримтална.

1.3.Энэ журамд хэрэглэсэн нэр томъёог доор дурдсан утгаар хэрэглэнэ:

1.3.1.“тэтгэлэг” гэж Дээд боловсролын тухай хуулийн 4.1.5-д заасан мөнгөн тусламжийг;

1.3.2.“зээл” гэж Дээд боловсролын тухай хуулийн 4.1.6-д заасан эргэн төлөгдөх, хөнгөлөлттэй нөхцөлөөр олгох мөнгөн хөрөнгийг;

1.3.3.“буцалтгүй тусламж” гэж энэ журмын дагуу суралцагчид олгох эргэн төлөх нөхцөлгүй сургалтын төлбөрийн зардлыг;

1.3.4.“сургалтын төлбөрийн хөнгөлөлт” гэж Дээд боловсролын тухай хуулийн 4.1.7-д заасан сургалтын төлбөрөөс тодорхой хувиар чөлөөлөхийг;

1.3.5.“бэлтгэл хөтөлбөр” гэж Дээд боловсролын тухай хуулийн 20.6-д заасан боловсролын зэрэг олгох хөтөлбөрт хамрагдахын өмнө заавал судлах нөхцөлтэй сургалтын хөтөлбөрийг;

1.3.6.“сан” гэж Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 8.1-д заасан Боловсролын зээлийн санг;

1.3.7.“2+2 хөтөлбөр” гэж дотоодын их, дээд сургуулиудын хөгжлийг дэмжих, бакалаврын түвшинд бэлтгэх хүний нөөц, сургалтын зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Дээд боловсролын тухай хуулийн 31.2-т заасан хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийг;

1.3.8.“амьжиргааны зардал” гэж суралцагчийн дотуур байрны болон хүнсний зардлыг.

1.4.Суралцагчид тэтгэлэг, сургалтын зээл, буцалтгүй тусламж, хөнгөлөлт олгох, сургалтын зээлийг эргэн төлүүлэх үйл ажиллагаанд Боловсролын ерөнхий хуулийн 5.1-д заасан зарчмыг баримтална.

1.5.Монгол Улсаас гадаадын сургалтын байгууллагад, эсхүл гадаад улсаас Монгол Улсын сургалтын байгууллагад суралцах суралцагчийн мэргэжил болон сургалтын төлбөрийн хэмжээг тухайн улсын Засгийн газар, эсхүл байгууллага хооронд байгуулсан гэрээнд зааснаар зохицуулна. Гэрээнд өөрөөр заагаагүй бол гадаадад суралцах суралцагчид олгох сургалтын төлбөрийг нэхэмжилсэн дүнгийн хэмжээгээр тооцно.

1.6.Гадаад улсад суралцагчид олгох амьжиргааны зардлын тухайн жилд олгох хэмжээг Монгол Улсын хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газраас ирүүлсэн судалгаанд үндэслэн боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн жил бүрийн 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор батална.

1.7.Гадаадын сургалтын байгууллагад тэргүүлэх, эсхүл эрэлттэй мэргэжлийн чиглэлээр тэтгэлэгтэй суралцахад Засгийн газраас баталсан тэргүүлэх, эрэлттэй мэргэжлийн чиглэлийн хөтөлбөрийг баримтална.

1.8.Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн суралцагчийг суралцуулах хяналтын тоог тухайн жилийн батлагдсан төсөвтөө багтаан жил бүрийн 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор дараах байдлаар тогтооно:

1.8.1.дотоодын сургалтын байгууллагад суралцагчид хөнгөлөлт, тэтгэлэг, сургалтын төлбөрийн хөнгөлөлттэй зээл олгох;

1.8.2.дээд боловсролын түвшин тус бүрээр гадаадын сургалтын байгууллагад суралцагчид тэтгэлэг, сургалтын төлбөрийн хөнгөлөлттэй зээл олгох.

1.9.Энэ журмын 1.8-д заасан хяналтын тоонд хөгжлийн бэрхшээлтэй суралцагч хамаарахгүй.

**Хоёр.Тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламж, дэмжлэг олгох
суралцагчид тавих нийтлэг шаардлага**

2.1.Тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламж, дэмжлэг авах дотоодын сургалтын байгууллагын суралцагч дараах нийтлэг шаардлагыг хангасан байна:

- 2.1.1.Монгол Улсын иргэн байх;
2.1.2.тэргүүлэх, эсхүл эрэлттэй мэргэжлийн чиглэлийн үндсэн хөтөлбөрт элсэн суралцагч байх;
2.1.3.боловсролын цахим мэдээллийн системд бүртгэгдсэн байх;
2.1.4.магадлан итгэмжлэгдсэн сургалтын хөтөлбөр, эсхүл сургалтын байгууллагын үндэсний эрэмбийн үнэлгээний “сургалт” хэсэгт 50-аас дээш хувийн үнэлгээ авсан сургалтын байгууллагад суралцдаг байх;
2.1.5.дэд бакалавр, бакалавр, магистр, докторын хөтөлбөрт анхлан суралцагч байх;
2.1.6.суралцагч зээл авснаас бусад тохиолдолд сангийн хөрөнгөөр суралцаагүй байх;
2.1.7.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасны дагуу “Өрийн мэдээллийн нэгдсэн сан”-д зээлийн үлдэгдэлгүй байх.
2.2.Гадаадын сургалтын байгууллагын суралцагч дараах нийтлэг шаардлагыг хангасан байна:
2.2.1.Монгол Улсын иргэн байх;
2.2.2.тэргүүлэх, эсхүл эрэлттэй мэргэжлийн чиглэлээр үндсэн хөтөлбөрт элсэн суралцагч байх;
2.2.3.магистр, докторын хөтөлбөрт анхлан суралцагч байх;
2.2.4.суралцагч зээл авснаас бусад тохиолдолд сангийн хөрөнгөөр суралцаагүй байх;
2.2.5.элсэн суралцагч бол үндсэн хөтөлбөрөөр суралцах шаардлага хангаж, урилга авсан, үргэлжлүүлэн суралцагч бол өмнөх улирлын голч дүнгийн авбал зохих үнэлгээний 75 хувиас доошгүй байх;
2.2.6.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасны дагуу “Өрийн мэдээллийн нэгдсэн сан”-д зээлийн үлдэгдэлгүй байх.

Гурав.Бүрдүүлэх баримт бичиг, сонгон шалгаруулалт

- 3.1.Дотоодын сургалтын байгууллагад тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламж, хөнгөлөлтөөр суралцахаар хүсэлт гаргагч нь дараах баримт бичгийг бүрдүүлж бичгээр, эсхүл цахим хэлбэрээр тухайн сургалтын байгууллагадаа хүргүүлнэ:
3.1.1.хүсэлт (батлагдсан маягтаар);
3.1.2.иргэний үнэмлэх (лавлагаа);
3.1.3.дэд бакалавр, бакалаврын үндсэн хөтөлбөрт элсэгч бол элсэлтийн шалгалтын батламжийн хуулбар, техникийн боловсролын сургалтын байгууллагын төгсөгч бол дипломын хуулбар, магистр, докторын үндсэн хөтөлбөрт элсэгч бол өмнөх боловсролын зэргийн дипломын хуулбар;
3.1.4.үргэлжлүүлэн суралцагч бол өмнөх улирлын голч дүнгийн хуудас, тухайн улиралд судлах хичээлийг баталгаажуулсан сургалтын байгууллагын тодорхойлолт;
3.1.5.зорилтот бүлгийн суралцагч бол хувийн байдлыг тодорхойлох эрх бүхий байгууллагын тодорхойлолт;
3.1.6.сургалтын төлбөрийн нэхэмжлэл.
3.2.Гадаадын сургалтын байгууллагад тэтгэлэг болон зээлээр суралцах хүсэлт гаргагч дараах баримт бичгийг бүрдүүлж, цаасаар, эсхүл цахим хэлбэрээр санд хүргүүлнэ:
3.2.1.хүсэлт (батлагдсан маягтаар);
3.2.2.иргэний үнэмлэх (лавлагаа);
3.2.3.тэргүүлэх мэргэжлийн чиглэлээр магистр, докторын үндсэн хөтөлбөрөөр суралцах бол ажилласан жилийг тодорхойлсон албан бичиг;
3.2.4.докторын үндсэн хөтөлбөрөөр суралцах бол эрдэм шинжилгээний бүтээлийн жагсаалт, тодорхойлох захидал (суралцах арга барил, судалгааны урьдчилсан сэдэв, арга зүй, эрдэм шинжилгээний ажлын туршлага, зан төлөвийн онцлогийг тодорхойлсон удирдагч багш, эрдэмтэн, байгууллага тус бүрийн тодорхойлолт);
3.2.5.цагдаагийн байгууллагын тодорхойлолт (гадаадын сургалтын байгууллагад суралцагч);
3.2.6.энэ журмын 4.2.2-т заасан суралцагч бол олимпиадад оролцож медальт байрт шалгарсныг гэрчлэх баримт бичгийн хуулбар;
3.2.7.сургалтын төлбөрийн нэхэмжлэхийн хуулбар;
3.2.8.төрийн албан хаагч бол ажлын гүйцэтгэлийн үнэлгээний хуудас болон ажилласан жилийг тодорхойлсон албан бичиг;
3.2.9.гадаадын сургалтын байгууллагын үндсэн ангид нэмэлт нөхцөлгүйгээр суралцах эрхийг авсан байх.
3.3.Ажлын хэсэг тухайн суралцагчийн зөвшөөрөлтэйгөөр иргэний үнэмлэх, боловсролын баримт бичиг, цагдаагийн байгууллагын тодорхойлолт болон бусад баримт бичгийг төрийн үйлчилгээний “И-

Монгол” цахим системээс нэмэлтээр авч болно. Ажлын хэсэг суралцагчид тавьж буй шаардлага хангасан эсэх талаар нэмэлт тодруулгыг холбогдох байгууллагаас ажлын 5 өдрийн дотор авч болно.

3.4.Тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламж, хөнгөлөлтөөр дотоодын сургалтын байгууллагад суралцуулах сонгон шалгаруулалтыг жил бүрийн I, III улиралд, гадаадын сургалтын байгууллагад суралцуулах сонгон шалгаруулалтыг жил бүрийн II улиралд багтаан цахимаар зохион байгуулна.

3.5.Сонгон шалгаруулалтын зарыг хүсэлт хүлээн авах хугацаанаас хуанлийн 30-аас доошгүй өдрийн өмнө боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, сан болон сургалтын байгууллагын цахим хуудсаар нээлттэй зарлана.

3.6.Тэтгэлэг, зээл, хөнгөлөлт, буцалтгүй тусламжид хамрагдах хүсэлтийг сонгон шалгаруулалтын зарын дагуу тогтоосон хугацаанд дотоодын сургалтын байгууллагад суралцах бол тухайн сургалтын байгууллагад, гадаадын сургалтын байгууллагад суралцах бол санд гаргана.

3.7.Дотоодын сургалтын байгууллага хүсэлт ирүүлсэн суралцагчийн баримт бичгийг хүсэлт хүлээн авах хугацаа дууссанаас хойш хуанлийн 30 өдрийн дотор хянаж, тэтгэлэг, зээл, хөнгөлөлт, буцалтгүй тусламжид хамрагдах шаардлага хангасан суралцагчийн нэрсийг хяналтын тоонд багтаан санд хүргүүлнэ. Сан ирүүлсэн мэдээллийг хянаж, баталгаажуулна.

3.8.Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр гадаадын сургалтын байгууллагад суралцах суралцагчийн сонгон шалгаруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг (цаашид “Ажлын хэсэг” гэх)-ийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, холбогдох төрийн захиргааны төв байгууллага болон сан, их, дээд сургууль, төрийн бус байгууллага, мэргэжлийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн 13 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулна. Ажлын хэсгийн бүрэлдэхүүний 50-аас доошгүй хувь нь төрийн болон хувийн өмчийн их, дээд сургууль, төрийн бус байгууллага болон мэргэжлийн холбооны төлөөлөл байна.

3.9.Ажлын хэсгийн ажиллах удирдамжийг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. Ажлын хэсгийн удирдамжаар ажлын хэсгийн дотоод зохион байгуулалт болон шалгаруулалттай холбоотой санал, хүсэлтийг зохицуулна.

3.10.Ажлын хэсэг энэ журмын 5.3.1-д заасан төрийн албан хаагчаас бусад гадаадын сургалтын байгууллагад суралцах суралцагчийн баримт бичгийн бүрдлийг сонгон шалгаруулалтын материал хүлээж авах хугацаа дууссанаас хойш ажлын 15 өдрийн дотор хяналтын тоонд багтаан шаардлага хангасан суралцагчийг дараах шалгуурыг үндэслэн 100 хүртэл оноогоор үнэлж жагсаана:

3.10.1.дэлхийн шилдэг их сургуулиудын зэрэглэл тогтоодог олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн “Таймс Хайэр Эдүкейшн Вөрлд Юниверсити Ранкингс”-аас цаг хугацааны хувьд хамгийн сүүлд тогтоосон эрэмбийн жагсаалтыг үндэслэн 25 хүртэл оноо;

3.10.2.тэтгэлгийн хэмжээг үндэслэн 40 хүртэл оноо;

3.10.3.сургалтын төлбөрийн нийт хэмжээнээс хамаарч 35 хүртэл оноо.

3.11.Шалгаруулалтад оролцогчийн нийт оноо тэнцсэн тохиолдолд тухайн суралцагчийн суралцах сургалтын байгууллагаас олгох тэтгэлгийн хэмжээ, сургалтын байгууллагын эрэмбэ, сургалтын төлбөрийн хэмжээ гэсэн дарааллын дагуу шийдвэрлэнэ.

3.12.Ажлын хэсэг сонгон шалгаруулалт дууссанаас хойш ажлын 3 өдрийн дотор сонгон шалгаруулалтын тайлан, хяналтын тоонд багтсан суралцагчийн нэрсийн жагсаалт, түүнд холбогдох баримт бичгийг санд хүлээлгэн өгнө.

3.13.Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн сонгон шалгаруулалт дууссанаас хойш ажлын 2 өдрийн дотор хяналтын тоонд багтаан нэрсийг баталгаажуулах бөгөөд шийдвэрийг суралцагчид цахим шуудан, эсхүл утсаар мэдэгдэж, цахим хуудсаар олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлнэ.

3.14.Суралцагч сонгон шалгаруулалтын дүнг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд сангийн дэргэдэх Орон тооны бус зөвлөлд гомдол гаргаж болно.

3.15.Орон тооны бус зөвлөл гомдлыг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор хянаж, дүгнэлт гаргана. Шаардлагатай тохиолдолд энэ хугацааг ажлын 3 хүртэл өдрөөр нэг удаа сунгаж болно.

3.16.Ажлын хэсэг Орон тооны бус зөвлөлийн дүгнэлтийг харгалзан энэ журмын 3.15-д зааснаас гадна холбогдох хуулийн хүрээнд гомдлыг шийдвэрлэнэ.

Дөрөв.Монгол Улсын Ерөнхийлөгчийн тэтгэлэг

4.1.Монгол хүн бүрийг чанартай боловсрол эзэмших тэгш боломжоор бүрэн хангаж, орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулах, эх оронч сэтгэлтэй, зөв хандлагатай, олон улсад өрсөлдөх мэдлэг, чадвартай, бүтээлч, манлайлагч иргэнийг бэлтгэх зорилгоор тухайн жилийн сонгон шалгаруулалтад тэнцсэн 500 хүртэлх суралцагчид Монгол Улсын Ерөнхийлөгчийн тэтгэлэг олгоно.

4.2.Ерөнхийлөгчийн тэтгэлэг дараах төрөлтэй байна:

4.2.1.Монгол Улсын бүх сум, хорооны түвшинд шалгарсан суралцагчид олгох бэлтгэл болон үндсэн хөтөлбөрийн тэтгэлэг;

4.2.2.олон улсын олимпиадад медальт байранд шалгарсан суралцагчид олгох тэтгэлэг.

4.3.Энэ журмын 4.2.1-д заасан бэлтгэл хөтөлбөрт элсэгч дараах шаардлага хангасан байна:

4.3.1.сүүлийн 3-аас доошгүй жил ерөнхий боловсролын сургуулийн хамран сургах тойргийн дагуу харьяалагдах сум, хороондоо суралцаж төгссөн байх, ахлах сургуульгүй сумын суралцагч бол харьяалагдах аймгийн аль нэг ердийн сургалттай сургуульд тасралтгүй 3-аас доошгүй жил суралцсан байх;

4.3.2.тухайн жилийн элсэлтийн шалгалтын “гадаад хэл-математик”, “гадаад хэл-физик”, “гадаад хэл-хими”, “гадаад хэл-биологи” гэсэн хувилбарын хэмжээст онооны дунджаар 550, түүнээс дээш оноо авсан байх;

4.3.3.энэ журмын 4.3.2-т заасан хэмжээст онооны дунджаар хамгийн өндөр оноо авч, сум, хороондоо тэргүүлсэн байх.

4.4.Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагын шийдвэрээр хамран сургах тойргийг өөрчилсөн бол энэ журмын 4.3.1-д заасан хугацааны шаардлага хамаарахгүй.

4.5.Суралцагч англи хэл, орос хэлний хичээлийн элсэлтийн шалгалтыг зэрэг өгсөн тохиолдолд аль өндөр оноо авсан гадаад хэлний хичээлийн шалгалтын оноогоор тооцно.

4.6.Энэ журмын 4.2.1-д заасан үндсэн хөтөлбөрийн тэтгэлэгт хамрагдах суралцагч дараах шаардлага хангасан байна:

4.6.1.тэтгэлгийн бэлтгэл хөтөлбөрийг 60, түүнээс дээш хувийн үнэлгээтэй төгссөн байх;

4.6.2.дэлхийн шилдэг их сургуулиудын зэрэглэл тогтоодог олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн тухайн жилд тогтоосон эрэмбийн жагсаалтын эхний 20-д багтсан сургалтын байгууллагад (Таймс Хайер Эдүкейшн Вөрлд Университи Ранкингс) бакалаврын үндсэн хөтөлбөрөөр суралцах урилга авсан бол мэргэжил харгалзахгүй, 21-100-д багтсан сургалтын байгууллагад бакалаврын үндсэн хөтөлбөрөөр суралцах урилга авсан бол тэргүүлэх, эсхүл эрэлттэй мэргэжлийн чиглэлээр суралцах;

4.6.3.энэ журмын 4.9-д заасан тухайн гадаадын сургалтын байгууллагын шаардлага хангасан байх.

4.7.Энэ журмын 4.2.2-т заасан тэтгэлэгт хамрагдах суралцагч олон улсын олимпиадын хорооноос зохион байгуулдаг хиймэл оюун, математик, физик, хими, биологи, газарзүй, мэдээлэл зүйн хичээлийн олимпиадад сүүлийн 3 жил медальт байранд шалгарсан байх шаардлагыг хангасан тохиолдолд энэ журмын 4.13.3-т заасан хугацаанд ирүүлсэн материалд үндэслэн боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн суралцах эрхийг баталгаажуулна.

4.8.Энэ журмын 4.2.1-д заасан бэлтгэл хөтөлбөрийн сургалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх дотоодын сургалтын байгууллага дараах шаардлага хангасан байна:

4.8.1.байгууллагын магадлан итгэмжлэлийн хугацаа хүчин төгөлдөр байх;

4.8.2.математик, байгалийн шинжлэх ухаан, гадаад хэлний мэргэжлийн чиглэлээр хөтөлбөр хэрэгжүүлдэг байх;

4.8.3.боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй бэлтгэл хөтөлбөрийг хэрэгжүүлэх гэрээ байгуулсан байх.

4.9.Энэ журмын 4.2.1-д заасан тэтгэлгээр суралцагчийг Засгийн газар хоорондын болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, сангаас хийсэн хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийн хүрээнд гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад бакалаврын үндсэн хөтөлбөрөөр суралцуулна.

4.10.Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, холбогдох төрийн байгууллага, иргэн, төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдсэн 11 гишүүний бүрэлдэхүүнтэй Ажлын хэсгийг байгуулж, тэтгэлгийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулна.

4.11.Тэтгэлгийн сонгон шалгаруулалт бэлтгэл болон үндсэн хөтөлбөрийн гэсэн үе шаттай байна.

4.12.Ажлын хэсэг бэлтгэл хөтөлбөрийн сонгон шалгаруулалтыг тухайн жилийн III улиралд багтаан дараах байдлаар зохион байгуулна:

4.12.1.боловсролын үнэлгээ, арга зүйн байгууллага элсэлтийн шалгалт зохион байгуулагдсаны дараа энэ журмын 4.3-т заасан шаардлага хангасан суралцагчийн нэрсийн жагсаалтыг сум, хороо бүрээр гаргаж, боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн болон улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тухайн жилийн 07 дугаар сарын 20-ны өдрийн дотор хүргүүлнэ;

4.12.2.энэ журмын 4.12.1-д заасан нэрсийн жагсаалтын дагуу хамран сургах тойргийн шийдвэрт үндэслэн сургууль, сум, хороо бүрээр хянаж баталгаажуулсан мэдээллийг боловсролын асуудал

эрхэлсэн орон нутгийн байгууллага, суралцагч, түүний эцэг, эх, асран хамгаалагчийн оршин суугаа хаяг, сүүлийн 3 жилд шилжилт хөдөлгөөн хийсэн эсэх мэдээллийг улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага ажлын 3 өдөрт багтаан боловсролын үнэлгээ, арга зүйн байгууллагад тус тус хүргүүлнэ;

4.12.3.энэ журмын 4.12.2-т заасны дагуу улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас ирүүлсэн мэдээллийг Боловсролын мэдээллийн технологийн төвд хүргүүлэх бөгөөд тус байгууллага суралцагчийн хаягийн бүртгэлийн мэдээлэлд үндэслэн түүний сүүлийн 3 жил сурсан сургуулийн мэдээллийг ажлын 3 өдөрт багтаан боловсролын үнэлгээ, арга зүйн байгууллагад хүргүүлнэ;

4.12.4.боловсролын үнэлгээ, арга зүйн байгууллага энэ журмын 4.12.2, 4.12.3-т заасны дагуу холбогдох байгууллагаас ирүүлсэн суралцагчийн мэдээллийг хянаж, баталгаажуулсан нэрсийн жагсаалтыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тухайн жилийн 08 дугаар сарын 05-ны өдрийн дотор хүргүүлнэ;

4.12.5.боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нэрсийн жагсаалтын дагуу ажлын 2 өдрийн дотор бэлтгэл хөтөлбөрт хамрагдах суралцагчийн нэрсийг гаргаж Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт албан бичгээр хүргүүлнэ;

4.12.6.боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага ажлын 5 өдөрт багтаан энэ журмын 4.12.5-д заасан суралцагчийн суралцах гадаад хэл, мэргэжлийн чиглэлийн дагуу холбогдох сургалтын байгууллагад хуваарилалт хийж хүргүүлнэ;

4.12.7.бэлтгэл хөтөлбөрийг хэрэгжүүлэх сургалтын байгууллага ажлын 10 өдрийн дотор энэ журмын 4.12.6-д заасан хуваарийн дагуу суралцагчаас санал авч баталгаажуулан, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ;

4.12.8.боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр энэ журмын 4.10.7-д заасан бэлтгэл хөтөлбөрт хамрагдах суралцагчийн нэрсийг ажлын 3 өдрийн дотор эцэслэн баталгаажуулж, сан, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын цахим хуудсаар нээлттэй, ил тод мэдээлнэ;

4.12.9.суралцагч бэлтгэл хөтөлбөр эхлэхийн өмнө суралцахаас татгалзсан тохиолдолд тухайн орон нутгаас түүний дараагийн шаардлага хангасан суралцагчийг элсүүлж болно. Бэлтгэл хөтөлбөр эхэлснээс хойш суралцагчийг нөхөн элсүүлэхгүй;

4.12.10.суралцагч бэлтгэл хөтөлбөрийн үргэлжлэх хугацаанд эрүүл мэндийн болон бусад шалтгаанаар суралцах боломжгүй болсон тохиолдолд сонгон шалгаруулалтыг дахин зохион байгуулахгүй;

4.12.11.бэлтгэл хөтөлбөрийн үргэлжлэх хугацаа хичээлийн 1 жил байна. Суралцагч англи хэлнээс бусад гадаад хэлээр суралцах тохиолдолд шаардлагатай гэж үзвэл үндсэн хөтөлбөрт хамаарах бэлтгэл хөтөлбөрт хичээлийн 1 хүртэл жилд дахин суралцаж болно;

4.12.12.бэлтгэл хөтөлбөрийн эхний улиралд амжилттай суралцсан суралцагчид дараа оны I улиралд Монгол Улсын Ерөнхийлөгчийн илгээлт (батламж)-ийг гардуулна.

4.13.Ажлын хэсэг үндсэн хөтөлбөрийн сонгон шалгаруулалтыг тухайн жилийн II улиралд багтаан дараах байдлаар зохион байгуулна:

4.13.1.суралцагч бэлтгэл хөтөлбөрт 60 хувиас доош үнэлэгдсэн тохиолдолд энэ журмын 4.10-д заасан тэтгэлэгт хөтөлбөрийн сонгон шалгаруулалтад оролцох боломжгүй бөгөөд суралцагчийг дотоодын сургалтын байгууллагад хувийн зардлаар үргэлжлүүлэн суралцах боломжоор хангана;

4.13.2.үндсэн хөтөлбөрийн сонгон шалгаруулалтын мэдээллийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон сан бэлтгэл хөтөлбөрийн суралцагчид нээлттэй хүргэнэ;

4.13.3.суралцагч энэ журмын 3.2-т заасан баримт бичгийг бүрдүүлж, тухайн жилийн 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад цахимаар хүргүүлнэ;

4.13.4.суралцагчийн сонгон шалгаруулалтын оноо тэнцүү үнэлэгдсэн тохиолдолд энэ журмын 4.2.1-д заасан тэтгэлэгт гадаадын сургалтын байгууллагын эрэмбэ, бэлтгэл хөтөлбөрийн сурлагын амжилт, элсэлтийн шалгалтын оноо, энэ журмын 4.2.2-т заасан тэтгэлэгт гадаадын сургалтын байгууллагын эрэмбэ, олимпиадад эзэлсэн байр, гадаад хэлний мэдлэгийн түвшнийг тус тус харгалзан хяналтын тоонд багтаан сонгон шалгаруулна;

4.13.5.Ажлын хэсэг суралцагчийн баримт бичгийн бүрдлийг материал хүлээн авч дууссанаас хойш ажлын 15 өдрийн дотор хянаж энэ журмын 4.4-т заасан шаардлага хангасан суралцагчид тэтгэлэг олгох санал, дүгнэлтийг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулна;

4.13.6.боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр тэтгэлэгт шалгарсан суралцагчийн нэрсийг ажлын 2 өдрийн дотор баталгаажуулж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт албан бичгээр хүргүүлнэ;

4.13.7.сонгон шалгаруулалтын дүнг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, сангийн цахим хуудсаар олон нийтэд нээлттэй, ил тод мэдээнэ.

4.14.Энэ журмын 4.12.5, 4.12.8-д заасан жагсаалт батлагдсаны дараа цахим хуудсаар дамжуулан тухайн суралцагчид мэдэгдэж, нэрсийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар олон нийтэд зарлана.

4.15.Сан бэлтгэл хөтөлбөрт шалгарсан суралцагч болон суралцах сургалтын байгууллагатай гурван талт гэрээ, үндсэн хөтөлбөрийн суралцагч болон түүний харьяалагдах аймаг, нийслэлийн Засаг даргатай гурван талт гэрээ, энэ журмын 4.2.2-т заасан суралцагчтай хоёр талт гэрээг тус тус байгуулна.

4.16.Бэлтгэл хөтөлбөрийн суралцагчид сургалтын төлбөрийн тэтгэлэг олгох бөгөөд орон нутгаас ирсэн суралцагч бол дотуур байрны зардал нэмж олгож болно.

4.17.Тэтгэлгийн үндсэн хөтөлбөрийн суралцагчид сургалтын төлбөр, амьжиргааны зардал олгоно.

4.18.Энэ журмын 4.9-д заасан гэрээ, хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол гадаадын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөр, амьжиргааны зардлын тэтгэлгийг давхардуулахгүй олгоно.

4.19.Үндсэн хөтөлбөрт тэтгэлгээр суралцагчийг төгссөнөөс хойш 1 жилийн дотор түүний харьяалагдах аймаг, нийслэлийн Засаг дарга мэргэжлийн дагуу тухайн Засаг захиргаа, нутаг дэвсгэр дэх аж ахуйн нэгж, байгууллагад ажлын байраар хангах арга хэмжээ авах бөгөөд хөгжлийн бодлоготой уялдуулан төгсөгчийг өөр газарт томилон ажиллуулж болно. Төгсөгч нь аймаг (сумаас шалгарсан бол)-т, нийслэл (хорооноос шалгарсан бол)-д 5-аас доошгүй жил тогтвортой ажиллана.

4.20.Энэ журмын 4.2.2-т заасан суралцагч төгсөөд 1 жилийн дотор эх орондоо мэргэжлээрээ ажилд орсон байх бөгөөд 5-аас доошгүй жил тогтвортой ажиллана.

4.21.Энэ журмын 4.1-д заасан тэтгэлгээр суралцагч болон төгсөгч ерөнхий боловсролын сургууль болон бусад сургалтын байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, оролцох үүрэг хүлээнэ.

Тав.Монгол Улсын Засгийн газрын тэтгэлэг

5.1.Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх, олон улсад өрсөлдөх мэдлэг чадвартай, нийгэм, эдийн засаг, шинжлэх ухааны хөгжилд бодит хувь нэмрээ оруулах манлайлагчийг бэлтгэх зорилгоор дотоодын болон гадаадын сургалтын байгууллагад тэргүүлэх, эсхүл эрэлттэй мэргэжлийн чиглэлээр эзэмших суралцагчид Засгийн газрын тэтгэлэг (цаашид “Засгийн газрын тэтгэлэг” гэх) олгоно.

5.2.Төрийн албан хаагчийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, манлайлах чадварыг хөгжүүлэх, төрийн албан хаагчийг мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийн хүрээнд ажлын гүйцэтгэл, үр дүнгээр шалгарч, магистрын зэргийн өмнөх хэлний бэлтгэл, ахисан түвшний сургалтад суралцах албан хаагчид сангаас болон бусад эх үүсвэрээс тэтгэлэг олгоно.

5.3.Засгийн газрын тэтгэлэгт дараах иргэн хамрагдана

5.3.1.магистрын зэргийн өмнөх бэлтгэл хөтөлбөр (хэлний бэлтгэл), магистр болон докторын хөтөлбөрөөр сургалтад суралцах төрийн албан хаагч;

5.3.2.тэргүүлэх мэргэжлийн чиглэлээр суралцагч;

5.3.3.техникийн боловсролын сургалтын байгууллагын олон улсын хөтөлбөрийг дотоодын сургуульд төгсөж, тухайн мэргэжлийн чиглэлээрээ гадаадын сургалтын байгууллагад үндсэн хөтөлбөрөөр дэвшин суралцагч.

5.4.Төрийн албан хаагчийн магистрын зэргийн өмнөх хэлний бэлтгэл, ахисан түвшний сургалтад суралцах албан хаагч энэ журмын 2.2-т заасан нийтлэг шаардлага болон дараах тусгай шаардлага хангасан байна:

5.4.1.төрийн албанд 5-аас доошгүй жил, тухайн байгууллагад 3-аас доошгүй жил ажилласан үндсэн ажилтан байх;

5.4.2.төрийн албан хаагчийн хувьд сүүлийн 3 жилийн гүйцэтгэлийн үнэлгээгээр холбогдох журамд заасан хамгийн өндөр үнэлгээний ангилалд багтсан байх;

5.4.3.ажиллаж буй байгууллага захиалга өгсөн байх;

5.4.4.гадаадын сургалтын байгууллагад суралцан төгсөж ирээд 5 жил ажиллах боломжтой байх (өндөр насны болон цэргийн тэтгэвэр тогтоолгох насны хязгаар, төрийн тусгай албаны 20-25 жил ажилласан байх нөхцөлөөс үлдсэн хугацаа 10 жилээс доошгүй байх).

5.5.Энэ журмын 5.3.2-т заасан дотоодын сургалтын байгууллагад суралцагч энэ журмын 2.1-д заасан нийтлэг шаардлага болон дараах тусгай шаардлага хангасан байна:

5.5.1.дэд бакалавр, бакалавр, магистр, докторын үндсэн хөтөлбөрөөр суралцагч байх;

5.5.2.дэд бакалавр хөтөлбөрт элсэн суралцагч бол элсэлтийн шаардлага хангасан, бакалаврын үндсэн хөтөлбөрт элсэн суралцагч бол элсэх мэргэжлийн хичээлийн элсэлтийн шалгалтад 600, түүнээс дээш оноо авсан, үргэлжлүүлэн суралцагч бол өмнөх улирлын голч дүн 3.0-аас доошгүй байх;

5.5.3.магистрын үндсэн хөтөлбөрт элсэн суралцагч бол тухайн мэргэжлийн бакалаврын зэрэгтэй, мэргэжлээрээ 2-оос доошгүй жил ажилласан, өмнөх боловсролын зэргийн дипломын голч дүн 3.0-аас доошгүй, үргэлжлүүлэн суралцагч бол өмнөх улирлын голч дүн 3.0-аас доошгүй байх;

5.5.4.докторын үндсэн хөтөлбөрт элсэн суралцагч бол тухайн мэргэжлийн магистрын зэрэгтэй, мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан, судалгаа шинжилгээний ажлын бүтээл нийтлүүлсэн, өмнөх боловсролын зэргийн дипломын голч дүн 3.2-оос доошгүй, үргэлжлүүлэн суралцагч бол өмнөх улирлын голч дүн 3.2-оос доошгүй байх.

5.6.Энэ журмын 5.3.2-т заасан гадаадын сургалтын байгууллагад суралцагч энэ журмын 2.2-т заасан нийтлэг шаардлагаас гадна дараах тусгай шаардлага хангасан байна:

5.6.1.магистр, докторын үндсэн хөтөлбөрөөр суралцах урилга авсан байх;

5.6.2.үргэлжлүүлэн суралцагч бол өмнөх улирлын голч дүн авбал зохих үнэлгээний 75 хувиас доошгүй байх.

5.7.Энэ журмын 5.3.3-т заасан техникийн боловсролын сургалтын байгууллагын олон улсын хөтөлбөрийг дотоодын сургуульд төгсөж, тухайн мэргэжлийн чиглэлээр гадаадын сургалтын байгууллагад үндсэн хөтөлбөрөөр дэвшин суралцагч энэ журмын 2.2-т заасан нийтлэг шаардлагаас гадна тэргүүлэх, эсхүл эрэлттэй мэргэжлийн чиглэлээр суралцагч байх тусгай шаардлагыг хангасан байна.

5.8.Энэ журмын 5.3.1-д заасан суралцагчид нэр дэвшүүлэх албан хаагчийг тухайн байгууллага дотроо нээлттэй зарлан, ил тод сонгон шалгаруулах бөгөөд холбогдох мэдээллийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор тухайн салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, сум, дүүргийн Засаг даргын тамгын газар нь аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тус тус хүргүүлнэ.

5.9.Салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь энэ журмын 5.8-д заасан тэтгэлэгт хамрагдах нэр дэвшигчдийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, тэнцсэн нэр дэвшигчийн мэдээллийг тухайн жилийн 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

5.10.Энэ журмын 5.3.1-д заасан суралцагчийг сонгон шалгаруулах, суралцах сургалтын байгууллагыг тодорхойлох, гэрээ байгуулахтай холбогдох үйл ажиллагааг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар зохион байгуулж, энэ журмын 1.8-д заасан хяналтын тоонд багтаан тэтгэлэгт хамрагдах албан хаагчийн мэдээллийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

5.11.Энэ журмын 5.10-д заасны дагуу боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлсэн тэтгэлгээр суралцуулах төрийн албан хаагчдын нэрсийг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр баталгаажуулж, санд хүргүүлнэ.

5.12.Сан энэ журмын 5.3.1-д заасан төрийн албан хаагчтай (захиалагч төрийн байгууллагыг оролцуулан) гурван талт гэрээ, 5.3.2, 5.3.3-т заасан суралцагчтай хоёр талт гэрээ байгуулна.

5.13.Энэ журмын 5.3.1, 5.3.3-т заасан суралцагчид сургалтын төлбөр, дотуур байрны зардал, 5.3.2-т заасан суралцагчид сургалтын төлбөрийн тэтгэлэг олгоно.

5.14.Энэ журмын 5.3.3-т заасан үргэлжлүүлэн тэтгэлгээр суралцагч нь дараагийн улиралд дэвшин суралцах эрхээ авсан бол, 5.3.1, 5.3.2-т заасан үргэлжлүүлэн тэтгэлгээр суралцагчийн өмнөх улиралд авсан голч дүн тухайн сургалтын байгууллагын үнэлгээний 75 хувиас доошгүй оноо авсан тохиолдолд тэтгэлгийн санхүүжилтийг үргэлжлүүлэн олгоно.

5.15.Төрийн албан хаагчийг төгссөний дараа захиалга өгсөн төрийн байгууллага өөрчлөн байгуулагдсан (нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх хэлбэрээр), эсхүл зохион байгуулалтын бүтэц өөрчлөгдсөн боловч түүний албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүрэг хэвээр хадгалагдан үлдсэн бол албан тушаалд нь үргэлжлүүлэн ажиллуулах, хэрэв тухайн чиг үүргийг хэрэгжүүлэх албан тушаал (ажлын байр)-ын орон тоо хасагдсан зэрэг шалтгаанаар урьд ажиллаж байсан албан тушаалд үргэлжлүүлэн ажиллуулах боломжгүй тохиолдолд төрийн албан хаагчтай тохиролцон өмнөх нөхцөлийг дордуулахгүйгээр өөр албан тушаалд томилон ажиллуулна.

Зургаа.Засгийн газар хоорондын тэтгэлэг

6.1.Монгол Улсаас гадаад улсад суралцах суралцагч энэ журмын 1.5-д заасан гэрээнд өөрөөр заагаагүй бол энэ журмын 2.2-т заасан нийтлэг шаардлагыг хангасан байна.

6.2.Сан Монгол Улсаас гадаад улсад суралцагчтай, гадаад улсаас Монгол Улсад суралцагчтай хоёр талт гэрээ байгуулна.

6.3.Монгол Улсаас гадаад улсад суралцах суралцагчид энэ журмын 1.5-д зааснаар, эсхүл энэ журмын 1.6-д заасны дагуу баталсан хэмжээгээр амьжиргааны зардлын тэтгэлэг олгоно.

6.4.Гадаад улсаас Монгол Улсад суралцах суралцагчийн талаар тухайн улстай харилцан адил байх зарчмыг баримтлах бөгөөд тэтгэлгийн хувьд сургалтын төлбөрийн болон дотуур байрны зардлыг тухайн сургалтын байгууллагын нэхэмжилсэн дүнгээр, хүнсний зардлыг Үндэсний статистикийн хорооноос тогтоосон тухайн жилийн хүн амын амьжиргааны доод түвшнээр тооцож олгоно.

6.5.Энэ журамд заасан тэтгэлгээр үргэлжлүүлэн суралцах тохиолдолд өмнөх улирлын голч дүн нь Монгол Улсаас гадаад улсад суралцагч бол авбал зохих үнэлгээний 75 хувиас доошгүй, гадаад улсаас Монгол Улсад суралцагч бол 2.0-оос доошгүй байна.

Долоо.Зарим эрэлттэй мэргэжлийн тэтгэлэг

7.1.Монгол Улсын нийгмийн салбарт хомсдолтой байгаа зарим мэргэжлийн чиглэлээр дотоодын болон гадаадын сургалтын байгууллагад дэд бакалавр, бакалаврын үндсэн хөтөлбөрөөр суралцах суралцагчид тэтгэлэг олгоно.

7.2.Дотоодын сургалтын байгууллагад зарим эрэлттэй мэргэжлээр суралцагчид олгох тэтгэлэг дараах төрөлтэй байна:

7.2.1.сувилахуй, нийгмийн ажилтан, номын сан, хоол зүй, шим судлал мэргэжлийн үндсэн хөтөлбөрөөр суралцагчид олгох тэтгэлэг;

7.2.2.малчнаар 10-аас доошгүй жил тасралтгүй ажилласан малчны нэг хүүхдийг мал аж ахуй, тэжээл, бэлчээр судлалын чиглэлийн мэргэжил эзэмшүүлэх зорилгоор төрийн өмчийн сургалтын байгууллагын суралцагчид олгох тэтгэлэг;

7.2.3.бусад мэргэжлээр дээд боловсрол эзэмшсэн, багшийн хөтөлбөрөөр суралцаж байгаа бол суралцагчид олгох тэтгэлэг;

7.2.4.хөгжлийн бэрхшээлтэй иргэнд чиглэсэн хэл засал, хөдөлгөөн засал, хөдөлмөр засал, сэтгэл зүй, арга зүй (эрүүл мэндийн, спортын)-н мэргэжлийн үндсэн хөтөлбөрөөр суралцагчид олгох.

7.3.Энэ журмын 7.2.4-т заасан мэргэжлээр гадаадын сургалтын байгууллагад бакалаврын хөтөлбөрт суралцагчид тэтгэлэг олгож болно.

7.4.Энэ журмын 7.2.4-т заасан мэргэжлээр иргэн нь дотоодод дэд бакалавр болон бакалаврын үндсэн хөтөлбөрөөр хоёр дахь удаагаа суралцаж болно.

7.5.Энэ журмын 7.2.4-т заасан мэргэжлээр суралцагчид энэ журмын 2.1.5, 2.2.3-т заасан шаардлага хамаарахгүй.

7.6.Суралцагч энэ журмын 2.1, 2.2-т заасан нийтлэг шаардлагаас гадна төгссөнөөс хойш орон нутгийн байгууллагад 3 жил, нийслэлд 5 жил мэргэжлээрээ тогтвортой ажиллах нөхцөлийг хүлээн зөвшөөрсөн байна.

7.7.Дотоодын сургалтын байгууллагад элсэн суралцагч бол элсэлтийн шалгалтад тухайн мэргэжлийн чиглэлийн шалгалтад 501-ээс дээш оноо авсан тохиолдолд 100 хувийн, үргэлжлүүлэн суралцагч бол өмнөх улиралд 3.0, түүнээс дээш голч дүнтэй суралцсан тохиолдолд 100 хувийн, 2.8-3.0 хүртэл голч дүнтэй суралцсан тохиолдолд 70 хувийн сургалтын төлбөрийн тэтгэлэг олгоно.

7.8.Гадаадын сургалтын байгууллагад үргэлжлүүлэн суралцагчийн өмнөх улирлын голч дүн авбал зохих үнэлгээний 75 хувиас доошгүй байх тохиолдолд сургалтын төлбөр, дотуур байрны төлбөрийн тэтгэлгийг олгоно.

7.9.Сан дотоодын сургалтын байгууллагад суралцагч болон сургалтын байгууллагатай гурван талт гэрээ, гадаадын сургалтын байгууллагад суралцагчтай хоёр талт гэрээг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулна.

Найм.Зорилтот бүлгийн суралцагчид олгох буцалтгүй тусламж

8.1.Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.5-3.1.7-д заасан суралцагч (цаашид “зорилтот бүлгийн суралцагч” гэх)-д дотоодын сургалтын байгууллагад дэд бакалавр, бакалаврын үндсэн хөтөлбөрөөр суралцахад буцалтгүй тусламж олгоно.

8.2.Зорилтот бүлэгт дараах суралцагч хамаарна:

8.2.1.бүтэн өнчин суралцагч;

8.2.2.нэг гишүүн нь хөгжлийн бэрхшээлтэй өрхийн хагас өнчин суралцагч;

8.2.3.хөгжлийн бэрхшээлтэй суралцагч;

8.2.4.эцэг, эх нь хоёулаа хөгжлийн бэрхшээлтэй өрхийн нэг суралцагч;

8.2.5.хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан гишүүнтэй өрхийн нэг суралцагч;

8.2.6.цаатан, тува, урианхай үндэстний өрхийн нэг суралцагч;

8.2.7.нэг гэр бүлийн 3 болон түүнээс дээш хүүхэд дотоодын сургалтын байгууллагад бакалаврын үндсэн хөтөлбөрөөр зэрэг суралцаж байгаа бол нэг суралцагч.

8.3.Буцалтгүй тусламжаар үргэлжлүүлэн суралцах зорилтот бүлгийн суралцагчийн өмнөх улирлын голч дүн 2.0 буюу түүнээс дээш, эсхүл энэ журмын 8.2.3-т заасан хөгжлийн бэрхшээлтэй суралцагч дэвшин суралцах эрхээ авсан бол буцалтгүй тусламж олгоно.

8.4.Энэ журмын 8.2.3-т заасан суралцагчид Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 15.6-д заасны дагуу дотоод, гадаадын их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн болон техникийн боловсролын байгууллагад элсэн суралцах эрх авсан бол дараах буцалтгүй тусламжийг олгоно:

8.4.1.дотоодын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөр, дотуур байрны зардал;

8.4.2.гадаадын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөр, амьжиргааны зардал.

8.5.Сан дотоодын сургалтын байгууллагад суралцагч болон сургалтын байгууллагатай гурван талт гэрээг, гадаадын сургалтын байгууллагад суралцагчтай хоёр талт гэрээг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулна.

8.6.Энэ журмын 2.1.2-т заасан шаардлага дээрх 8.2-т заасан суралцагчид хамаарахгүй.

8.7.Дээрх 8.2.3-т заасан суралцагчид журмын 2.1.4, 2.1.5, 2.1.6, 2.2.2, 2.2.3, 2.2.4-т заасан шаардлага хамаарахгүй.

Ес. Сургалтын төлбөрийн хөнгөлөлт

9.1.Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчийн сургалтын байгууллагад дэд бакалавр, бакалавр, магистр, докторын үндсэн хөтөлбөрөөр суралцах суралцагчид сургалтын төлбөрийн 50 хувьтай тэнцэх хэмжээний хөнгөлөлт үзүүлнэ.

9.2.Суралцагч энэ журмын 2.1-д заасан нийтлэг шаардлага болон дараах тусгай шаардлага хангасан байна:

9.2.1.элсэн суралцагч дэд бакалавр, бакалаврын хөтөлбөрт элсэлтийн босго оноонд хүрсэн байх, магистр, докторын хөтөлбөрт суралцах бол өмнөх боловсролын зэргийн дипломын голч дүн 2.8-аас доошгүй байх;

9.2.2.дэд бакалавр, бакалаврын үндсэн хөтөлбөрөөр үргэлжлүүлэн суралцах суралцагчийн өмнөх улирлын голч дүн 2.8-аас доошгүй, магистр, докторын үндсэн хөтөлбөрөөр үргэлжлүүлэн суралцагчийн голч дүн 3.0-оос доошгүй байх;

9.2.3.Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.2-т заасан нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн байх.

9.3.Сан суралцагч болон сургалтын байгууллагатай холбогдох хууль тогтоомжийн дагуу гурван талт гэрээ байгуулна.

Арав. Сургалтын төлбөрийн хөнгөлөлттэй зээл

10.1.Дотоод, гадаадын сургалтын байгууллагад бакалавр, магистр, докторын үндсэн хөтөлбөрөөр, мөн дотоодын сургалтын байгууллагад дэд бакалавр хөтөлбөрөөр суралцах иргэнд сургалтын төлбөрийн хөнгөлөлттэй зээл олгоно.

10.2.Дотоодын сургалтын байгууллагад суралцагч энэ журмын 2.1-д заасан нийтлэг шаардлагаас гадна дараах тусгай шаардлагыг хангасан байна:

10.2.1.магадлан итгэмжлэгдсэн сургалтын байгууллагад дэд бакалавр, бакалавр, магистр, докторын үндсэн хөтөлбөрөөр суралцдаг байх;

10.2.2.элсэн суралцагч дэд бакалавр, бакалаврын хөтөлбөрт элсэлтийн босго оноонд хүрсэн, магистр, докторын хөтөлбөрт суралцах бол өмнөх боловсролын зэргийн дипломын голч дүн 2.8-аас доошгүй байх;

10.2.3.дэд бакалавр, бакалаврын үндсэн хөтөлбөрөөр үргэлжлүүлэн суралцагчийн өмнөх улирлын голч дүн 2.8-аас доошгүй, магистр, докторын үндсэн хөтөлбөрөөр суралцагчийн голч дүн 3.0-оос доошгүй байх;

10.2.4.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасны дагуу “Өрийн мэдээллийн нэгдсэн сан”-д зээлийн үлдэгдэлгүй байх.

10.3.Дараах иргэн гадаадын сургалтын байгууллагад суралцах сургалтын төлбөрийн хөнгөлөлттэй зээлд хамрагдана:

10.3.1.“2+2 хөтөлбөр”-ийн хүрээнд дотоодын сургалтын байгууллагад эхний хоёр жил амжилттай суралцаж, гадаадын сургалтын байгууллагад бакалаврын хөтөлбөрөөр үргэлжлүүлэн суралцах эрх авсан суралцагч;

10.3.2.бакалаврын үндсэн хөтөлбөрөөр суралцах эрх авсан суралцагч;

10.3.3.гадаадын сургалтын байгууллагад магистр, докторт суралцагч.

10.4.Гадаадын сургалтын байгууллагад суралцагч энэ журмын 2.2-т заасан нийтлэг шаардлагаас гадна дараах тусгай шаардлагыг хангасан байна:

10.4.1.дэлхийн шилдэг их сургуулиудын зэрэглэл тогтоодог олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн “Таймс Хайэр Эдүкейшн Вөрлд Юниверсити Ранкингс”-аас тухайн жилд тогтоосон эхний 100-д багтсан сургалтын байгууллагад үндсэн хөтөлбөрөөр суралцах урилга авсан байх;

10.4.2.энэ журмын 10.4.1-д заасан эрэмбийн жагсаалтын эхний 20-д багтсан сургалтын байгууллагад үндсэн хөтөлбөрөөр суралцах урилга авсан бол мэргэжил харгалзахгүй, 21-100-д багтсан сургалтын байгууллагад үндсэн хөтөлбөрөөр суралцах урилга авсан бол тэргүүлэх, эсхүл эрэлтэй мэргэжлийг сонгосон байх.

10.5.Үргэлжлүүлэн зээлээр суралцагчийн өмнөх улиралд авсан голч дүн тухайн сургалтын байгууллагын үнэлгээний 75 хувиас доошгүй оноо авсан тохиолдолд зээлийн санхүүжилтийг үргэлжлүүлэн олгоно.

10.6.Сан дотоодын сургалтын байгууллагад суралцагч болон сургалтын байгууллагатай гурван талт гэрээ, гадаадын сургалтын байгууллагад суралцагчтай хоёр талт гэрээ байгуулна.

10.7.Зээлийг энэ журмын 10.2-т заасан суралцагчид сургалтын төлбөрийн хэмжээгээр, 10.3-т заасан суралцагчид авсан тэтгэлгийн хэмжээг харгалзан сургалтын төлбөрийн үлдэх дүнгээр эргэн төлөх нөхцөлтэйгөөр олгоно.

10.8.Дотоодын сургалтын байгууллагад суралцагчид олгох зээл барьцаагүй, гадаадын сургалтын байгууллагад суралцагчид олгох зээлд үл хөдлөх эд хөрөнгө (цаашид “барьцааны зүйл” гэх) барьцаална.

10.9.Төгсөгч нь гэрээний дагуу энэ журмын 12.1.8-д заасан хугацаанд өөрөө, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан санд бүртгүүлнэ.

10.10.Сангаас энэ журмын 11.14.8-д заасны дагуу баталсан зээлийн эргэн төлөлтийн хуваарийг төгсөгч, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчид гэрээнд заасан хаягаар цахимаар болон монгол шуудангаар илгээснээр зээл төлөх хугацаа тоологдож эхэлнэ.

10.11.Дараах тохиолдолд зээл олгохгүй:

10.11.1.үл хөдлөх эд хөрөнгө зээлийн барьцааны шаардлага хангаагүй;

10.11.2.сангаас өмнө авсан зээл төлөөгүй;

10.11.3.энэ журмын 10.11.2-т зааснаас бусад гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй;

10.11.4.баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн нь тогтоогдсон.

10.12.Зээлээр үргэлжлүүлэн суралцах тохиолдолд өмнөх улирлын голч дүн дотоодын сургалтын байгууллагад суралцагч бол 2.8-аас доошгүй, гадаадын сургалтын байгууллагад суралцагч бол авбал зохих үнэлгээний 75 хувиас доошгүй байна.

10.13.Энэ журмын 2.1.2-т заасан шаардлага дотоодын сургалтын байгууллагад суралцагчид хамаарахгүй.

Арван нэг. Гэрээ байгуулах, сунгах, түдгэлзүүлэх, дуусгавар болгох

11.1.Сан нь суралцагчтай холбогдох хууль тогтоомжийн дагуу гэрээ байгуулна. Суралцагчтай байгуулах гэрээний загварыг боловсролын болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

11.2.Суралцагчтай байгуулах гэрээг хичээлийн улирлын үргэлжлэх хугацаагаар байгуулах бөгөөд гэрээнд дараах зүйлийг тусгана:

11.2.1.суралцах боловсролын зэрэг, хугацаа;

11.2.2.зээл, тэтгэлэг, хөнгөлөлт, буцалтгүй тусламжийн хэмжээ;

11.2.3.оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлага;

11.2.4.гэрээ түдгэлзүүлэх, сунгах, дуусгавар болгох нөхцөл;

11.2.5.зээлийн барьцаа, эргэн төлөлт;

11.2.6.бусад.

11.3.Суралцагчид зээл, тэтгэлэг, хөнгөлөлт, буцалтгүй тусламжийг олгохдоо дараах зохицуулалтыг баримтална:

11.3.1.тэтгэлэг, зээл, хөнгөлөлт, буцалтгүй тусламжийг гэрээнд заасан зориулалт, хэмжээгээр олгоно;

11.3.2.гадаадын сургалтын байгууллагад суралцагчтай байгуулах гэрээнд олгох санхүүжилтийн дүнг тухайн улсын мөнгөн тэмдэгтээр тусгаж, санхүүжилтийн эрх хүссэн өдрийн Монголбанкны валютын ханшийг баримталж олгоно;

11.3.3.сургалтын төлбөрийг сургалтын байгууллагын дансанд, дотуур байрны зардлыг холбогдох байгууллагын дансанд, хүнсний зардлыг суралцагчийн дансанд шилжүүлнэ.

11.4.Энэ журмын 11.3.3-т заасны дагуу шилжүүлэг хийхдээ холбогдох байгууллагаас ирүүлсэн албан ёсны баримтыг үндэслэнэ. Шаардлагатай тохиолдолд нэмэлт мэдээлэл, тодруулга авна.

11.5.Суралцагч гэрээнд заасны дагуу сурлагын дүн болон холбогдох мэдээллийг хичээлийн жилийн улирал бүр, сангаас шаардсан бусад мэдээллийг тухай бүр цахимаар санд хүргүүлнэ.

11.6.Дахин судалсан хичээлийн багц цагийн төлбөрийг суралцагч өөрөө хариуцна.

11.7.Суралцагч аливаа гэнэтийн осол, гэмтлийн улмаас амь насаа алдах, эрүүл мэндэд нь хохирол учрах, хөдөлмөрийн чадвар алдах, тооцоолоогүй санхүүгийн эрсдэлд орохоос хамгаалах зорилгоор эрсдэлийн даатгалд даатгуулсан байна.

11.8.Сан суралцагчтай байгуулсан гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж, гэрээг дүгнэсэн баримтыг хавсаргах бөгөөд дараах шаардлага хангасан тохиолдолд гэрээг улирал тутам сунгана:

11.8.1.суралцагч сурлагын дүнгийн шаардлага хангасан байх;

11.8.2.гэрээгээр хүлээсэн бусад үүргээ биелүүлсэн байх.

11.9.Дараах тохиолдолд суралцагчид олгох санхүүжилтийг зогсоож, гэрээг 1 жил хүртэлх хугацаагаар түдгэлзүүлнэ:

11.9.1.суралцагч жирэмсний, амаржсаны амралттай, хүүхэд асрах чөлөөтэй, эсхүл хүндэтгэн үзэх бусад шалтгааны улмаас нэг сараас дээш хугацаагаар суралцах боломжгүй болсныг эрх бүхий байгууллагын шийдвэрээр нотолсон бол;

11.9.2.энэ журмын 11.9.1-д заасан үндэслэлээр суралцах хугацааг түдгэлзүүлэхэд баримт үйлдэж, гэрээнд хавсаргана;

11.9.3.суралцагч холбогдох этгээдийн зөвшөөрснөөр өөр сургалтын байгууллагад шилжин суралцсан, гэрээнд заасан суралцах боловсролын зэрэг, мэргэжлийн чиглэлийг өөрчилсөн бол;

11.9.4.суралцагч сурлагын дүнгийн шаардлага хангаагүй бол.

11.10.Гэрээг түдгэлзүүлсэн хугацаанд тухайн суралцагчид тэтгэлэг, зээл, хөнгөлөлт, буцалтгүй тусламж олгохгүй.

11.11.Дараах үндэслэлээр гэрээг дуусгавар болгох шийдвэрийг сангийн Ажлын албаны даргын тушаалаар хагас жил тутамд баталгаажуулна:

11.11.1.гэрээний хугацаа дуусаж, талууд хүлээсэн үүргээ биелүүлсэн бол;

11.11.2.суралцагч нь нас барсан, эсхүл иргэний эрх зүйн чадамжгүй гэж шүүхээс тооцсон, хөдөлмөрийн чадвараа алдсаныг Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн шийдвэрээр тогтоосны дагуу барьцааны зүйлээр болон даатгалын гэрээнд заасны дагуу гэрээний үүргийн гүйцэтгэл хангасан;

11.11.3.барьцааны зүйлийг шүүхийн журмаар худалдан борлуулж, гэрээний үүргийн гүйцэтгэл хангагдсан.

11.12.Аль нэг талын санаачилгаар хугацаа дуусахаас өмнө гэрээг дараах тохиолдолд цуцална:

11.12.1.суралцагч өөр сургалтын байгууллагад шилжин суралцсан, гэрээнд заасан суралцах мэргэжлийн чиглэлийг өөрчилсөн;

11.12.2.суралцагч сургалтын байгууллагаас хасагдсан, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр сургуулиа орхисон, чөлөө авсан, чөлөөний хугацааг сунгасан;

11.12.3.тэтгэлэг, хөнгөлөлтөөр суралцагч төгсөөд жирэмсний, амаржсаны амралттай, хүүхэд асрах чөлөөтэй болон хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад тохиолдолд 12 сарын хугацаанд ажилд ороогүй, эсхүл гэрээнд заасны дагуу ажиллаагүй;

11.12.4.Монгол Улсын Ерөнхийлөгчийн тэтгэлгээр суралцагч аймаг (сумаас шалгарсан бол), нийслэлд (хорооноос шалгарсан бол) мэргэжлийн ажил санал болгоход өөрийн хүсэлтээр татгалзсан;

11.12.5.Монгол Улсын Ерөнхийлөгчийн тэтгэлгийн бэлтгэл хөтөлбөрт суралцагч бэлтгэл хөтөлбөрийг төгсөөд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гадаад улсад суралцахаас татгалзсан, эсхүл татгалзсан тухайгаа мэдэгдээгүй;

11.12.6.суралцагч хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь тогтоогдсон;

11.12.7.суралцах хугацаандаа гэмт хэрэгт холбогдож, гэм буруутайг нь шүүхээс тогтоосон.

11.13.Энэ журмын 11.11, 11.12-т заасан үндэслэлээр гэрээ дуусгавар болгох, эсхүл цуцлахад талууд гэрээ дүгнэсэн баримт үйлдэнэ.

11.14.Гэрээнд заасан барьцаа болон зээлийн эргэн төлөлтөд дараах зохицуулалтыг баримтална:

11.14.1.суралцагч барьцааны зүйлийн үнэлгээг эрх бүхий хуулийн этгээдээр хийлгэсэн байх бөгөөд барьцааны зүйлийн үнэлгээ суралцагчийн авах нийт зээлийн үнийн дүнгийн 50 хувиас доошгүй байна;

11.14.2.барьцааны зүйл суралцагчийн, эсхүл хамаарал бүхий гуравдагч этгээдийн өмчлөлд байх бөгөөд барьцааны зүйлийн талаар улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас лавлагаа авсан байна;

11.14.3.суралцагч барьцааны гэрээг холбогдох хууль тогтоомжийн дагуу улсын бүртгэлд бүртгүүлж, сан барьцаа бүртгэсэн талаарх лавлагааг суралцагчийн хувийн хэрэгт хавсаргана;

11.14.4.суралцагч барьцааны зүйлийг даатгуулсан байна;

11.14.5.зээлийн эргэн төлөлтийн хуваарийг олгосон санхүүжилтийн дүнгээр гаргана;

11.14.6.энэ журмын 12.1.8-д заасныг үндэслэн сан эргэн төлөлтийн хуваарийг үүсгэж, сургууль төгсөгчид, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчид энэ тухай мэдэгдэнэ;

11.14.7.суралцагчийн зээлийн эргэн төлөлтийн хуваарийг сан үүсгэн батлах бөгөөд дотоодын сургалтын байгууллагад суралцагч 5 хүртэлх жилийн дотор, гадаадын сургалтын байгууллагад суралцагч 20 хүртэлх жилийн дотор сургууль төгссөнөөс хойш 6 сарын дараагаас эхлэн эргэн төлнө;

11.14.8.зээлдэгч зээлийн эргэн төлөлтийг гэрээнд заасан хуваарийн дагуу сангийн дансанд шилжүүлнэ.

11.14.9.гэрээг энэ журмын 11.12-т заасны дагуу цуцалсан тохиолдолд сангаас тухайн иргэнд олгосон санхүүжилтийг 2 жилийн дотор бүрэн буцаан төлнө;

11.14.10.олгосон санхүүжилтийг эргэн төлүүлэхэд нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу валютын ханшийг тооцно.

11.15.Зээлийн эргэн төлөх хугацааг энэ журмын 11.9.1-д заасан хүндэтгэн үзэх шалтгаанаар орон нутагт ажиллаж байгаа төрийн албан хаагч 2 жил, гадаадын сургалтын байгууллагад зээлээр суралцагч 5 хүртэлх жилээр нэг удаа сунгаж болно.

11.16.Энэ журамд заасан суралцагч төгсөөд ажилласан байх хугацааны шаардлагыг нийгмийн даатгалын шимтгэл төлсөн баримтаар баталгаажуулна. Сайн дурын даатгалын төлөлт гэрээнд заасан ажилласан хугацаанд хамаарахгүй.

11.17.Төгсөгчийн ажиллаж байгаа байгууллага өөрчлөн байгуулагдсан (нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх), зохион байгуулалтын бүтэц өөрчлөгдсөн, татан буугдсан, эсхүл өөрөөс нь үл хамаарах шалтгаанаар албан тушаалын орон тоо хасагдсаны улмаас өөр ажил, албан тушаалд сэлгэн ажиллах тохиолдолд өмнө ажилласан хугацааг ажилласан хугацаанд оруулан тооцно.

11.18.Төгсөгч суралцсан мэргэжлээрээ гадаадад туршлага хуримтлуулах зорилгоор 3 хүртэлх жил ажиллаж болох бөгөөд энэ нь зээлийн эргэн төлөлтийн хугацаанд өөрчлөлт оруулах үндэслэл болохгүй.

Арван хоёр.Суралцагч, сургалтын байгууллага, сангийн эрх, үүрэг

12.1.Суралцагч дараах эрх, үүрэгтэй байна:

12.1.1.тэтгэлэг, зээл, хөнгөлөлт, буцалтгүй тусламжийн хүсэлт гаргах;

12.1.2.өргөдөл, гомдол гаргах;

12.1.3.гэрээний үүргээ биелүүлэхийг сан болон сургалтын байгууллагаас шаардах;

12.1.4.энэ журамд заасан баримт бичгийг бүрэн бүрдүүлэх;

12.1.5.суралцагчаас үл хамаарсан шалтгаанаар суралцаж байгаа мэргэжлийн чиглэл өөрчлөгдсөнөөс бусад тохиолдолд сургалтын байгууллага хооронд шилжихгүйгээр сонгосон мэргэжлээр суралцах;

12.1.6.гэрээний биелэлтийг дүгнэхэд санг шаардлагатай мэдээллээр хангах;

12.1.7.гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх;

12.1.8.гадаадын сургалтын байгууллагад тэтгэлгээр суралцагч төгсөөд дипломоо хүлээн авсан өдрөөс хойш 2 сарын дотор өөрийн биеэр санд бүртгүүлэх;

12.1.9.тэтгэлэг, хөнгөлөлтөөр суралцагч төгсөөд 1 жилийн дотор ажилд орох;

12.1.10.энэ журамд өөрөөр заагаагүй бол дотоодын сургалтын байгууллагад тэтгэлэг, хөнгөлөлтөөр суралцагч төгсөөд мэргэжлээрээ 3-5 жил, гадаадын сургалтын байгууллагад тэтгэлгээр суралцагч төгсөөд эх орондоо, мэргэжил заасан бол мэргэжлээрээ 5-аас доошгүй жил гэрээнд заасны дагуу ажиллах;

12.1.11.тэтгэлгээр суралцагч гэрээний хугацаанд сургуулиа төгсөж чадаагүй тохиолдолд энэ журмын 11.9.1-д заасан хүндэтгэн үзэх шалтгаанаас бусад тохиолдолд сангаас олгосон санхүүжилтийг буцаан төлнө.

12.2.Дотоодын сургалтын байгууллага дараах эрх, үүрэгтэй байна:

12.2.1.суралцагчид олгох тэтгэлэг, зээл, хөнгөлөлт, буцалтгүй тусламжийн талаарх тайлбар, мэдээллийг сангаас авах;

12.2.2.тогтоосон хугацаанд санхүүжилт шилжүүлэхийг сангаас шаардах;

12.2.3.сан болон суралцагчаас гэрээний үүргээ биелүүлэхийг шаардах;

12.2.4.суралцагч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцлах саналаа санд хүргүүлэх;

12.2.5.суралцагчийн тэтгэлэг, зээл, хөнгөлөлт, буцалтгүй тусламж хүссэн хүсэлтийг хүлээн авах, хянах, санд уламжлах, энэ талаар суралцагчид мэдэгдэх;

12.2.6.хяналтын тоонд багтсан суралцагчийн мэдээллийг төрөлжсөн сангийн нэгдсэн системд бүртгэх, суралцагчийн шилжилт хөдөлгөөний мэдээллийг тухай бүр шинэчлэх;

12.2.7.суралцагчийн голч дүн болон бусад мэдээллийг удирдлага мэдээллийн системд бүртгэх, улирал тутам шинэчлэх, олон нийтэд ил тод байршуулах;

12.2.8.гэрээний биелэлтийг дүгнэхэд болон бусад шаардлагатай мэдээллийг санд гаргаж өгөх, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх;

12.2.9.гэрээний хэрэгжилтийг хангуулах, биелэлтэд хяналт тавих;

12.2.10.гэрээний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 06 болон 12 дугаар сарын сүүлийн 7 хоногт санд хүргүүлэх.

12.3.Сан дараах эрх, үүрэгтэй байна:

12.3.1.дотоодын сургалтын байгууллагаас ирүүлсэн хүсэлт, баримт бичгийг хүлээн авах, хянах, шаардлага хангаагүй суралцагчийг хасах;

12.3.2.суралцагчтай гэрээ байгуулах, сунгах, түдгэлзүүлэх, цуцлах, дуусгавар болгох;

12.3.3.санхүүжилтийг гэрээнд заасны дагуу шилжүүлэх;

12.3.4.гэрээний үүргээ биелүүлэхийг суралцагч болон сургалтын байгууллагаас шаардах;

12.3.5.гэрээний биелэлтэд хяналт тавих, улирал тутам үнэлгээ хийж, хэрэгжилтийг хангуулах;

12.3.6.гэрээний үүргийн биелэлттэй холбогдуулан санхүүжилтийг зогсоох, суутгах, эргэн төлүүлэх;

12.3.7.санхүүжилтийн зарцуулалтын тайланг хагас, бүтэн жилээр гаргаж, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

12.3.8.энэ журмын 13.2-т заасан мэдээллийн сан үүсгэх, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, олон нийтэд ил тод байршуулах.

Арван гурав.Бусад

13.1.Энэ журмын хэрэгжилтэд боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавьж ажиллана.

13.2.Сан сонгон шалгаруулалт, гэрээний биелэлтийн ил тод байдлыг хангах зорилгоор мэдээллийн нэгдсэн санг үүсгэнэ.

13.3.Сан тэтгэлэг, зээл, хөнгөлөлт, буцалтгүй тусламж тус бүрээр суралцагч, төгсөгчийн мэдээллийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хуулийн дагуу олон нийтэд мэдээнэ.

13.4.Сан тухайн жилд байгуулсан, түдгэлзүүлсэн, сунгасан, цуцалсан, дуусгавар болсон гэрээний талаар дараа жилийн I улиралд багтаан боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнана.

13.5.Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газраас энэ журмын дагуу гадаадад суралцагчид тухайн улс дахь соёл, зан заншил, дотуур байрны талаар шаардлагатай зөвлөмж өгч, дэмжлэг үзүүлнэ. Тухайн улсад тэтгэлгээр суралцагчийн сурлагын явцын талаарх судалгаа, холбогдох мэдээлэл (сурлагын дүн, ёс зүй, санхүүжилт)-ийг хичээлийн жилийн улирал бүр санд хүргүүлнэ.

13.6.Сан суралцагчийн хувийн хэрэг (анкет, иргэний үнэмлэхийн хуулбар, сургалтын байгууллагын урилга, гадаад хэлний шалгалтын материал, онооны хуудас, гэрээ, үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээний тайлан, гэрчилгээний хуулбар, барьцаа бүртгэсэн талаарх лавлагаа, дипломын хуулбар болон бусад)-ийг Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн дагуу цаасаар болон цахимаар хадгална.


13.7.Зээлдэгчийн асуудлаар хуурамч бичиг баримт бүрдүүлсэн, зээлдэгчийн мэдээллийг буруу гаргаж ирүүлсэн нь хууль, хяналтын байгууллагаар тогтоогдвол сургуулийн удирдлага, албан тушаалтанд холбогдох хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

13.8.Гэрээ байгуулах, түдгэлзүүлэх, сунгах, дуусгавар болгохтой холбоотой энэ журамд заагаагүй бусад асуудлыг Иргэний хуульд заасны дагуу зохицуулна.

13.9.Энэ журамд заасан үүргээ зөрчсөн эрх бүхий албан тушаалтанд Төрийн албаны тухай хууль болон гэрээнд заасан хариуцлага хүлээлгэнэ.

13.10.Энэ журам болон зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ зээлдэгч биелүүлээгүй, зээлийн гэрээтэй холбоотой маргаан үүссэн тохиолдолд шүүхээр шийдвэрлүүлнэ.

СУРГУУЛИЙН БҮТЭЦ



СУРГУУЛИЙН ЗАХИРГААНЫ БҮРЭЛДЭХҮҮН

	Макихара Соичи (Профессор) Албан тушаал: Үүсгэн байгуулагч, Удирдах Зөвлөлийн дарга Холбоо барих хаяг: Э-Майл: info@soyolderdem.edu.mn Утас: 326947 Ажлын өрөө: 509 тоот
	Д.Эрдэнэчимэг (Доктор, Дэд профессор) Албан тушаал: Захирал Судалгааны чиглэл: Автоматжуулалт, WSN, Эрүүл мэндийн хяналтын зүүдэг төхөөрөмж, тоон системийн дизайн Холбоо барих хаяг: Э-Майл: info@soyolderdem.edu.mn Утас: 326947 Ажлын өрөө: 510 тоот
	Б.Мөнхбаяр (Доктор) Албан тушаал: Эрдэмтэн нарийн бичгийн дарга, чанарын үнэлгээний албаны дарга Судалгааны чиглэл: Уран зохиол, хэл шинжлэл Холбоо барих хаяг: Э-Майл: info@soyolderdem.edu.mn Утас: 326947 Ажлын өрөө: 504 тоот
	Ч.Батзориг (магистр) Албан тушаал: Санхүүгийн албан дарга Холбоо барих хаяг: Э-Майл: soyolderdem.finance@gmail.com Утас: 326947 Ажлын өрөө: 506 тоот
	Д.Энхчимэг (Доктор) Албан тушаал: Сургалтын албаны дарга Судалгааны чиглэл: Хэл шинжлэл Холбоо барих хаяг: Э-Майл: info@soyolderdem.edu.mn Утас: 70118584 Ажлын өрөө: 505 тоот
	Д.Гэрэлцэцэг (бакалавр) Албан тушаал: Нягтлан бодогч Холбоо барих хаяг: Э-Майл: soyolderdem.finance@gmail.com Утас: 326947 Ажлын өрөө: 506 тоот

	М.Хишигжаргал (Магистр) Албан тушаал: Номын санч Холбоо барих хаяг: Э-Майл: info@soyolderdem.edu.mn Утас: 326947 Ажлын өрөө: 406,407 тоот
	Б.Урансайхан (бакалавр) Албан тушаал: Нярав Холбоо барих хаяг: Э-Майл: soyolderdem.finance@gmail.com Утас: 326947 Ажлын өрөө: 506 тоот
	М.Батнасан (Магистр) Албан тушаал: Архив, нарийн бичиг Судалгааны чиглэл: Хэл шинжлэл Холбоо барих хаяг: Э-Майл: info@soyolderdem.edu.mn Утас: 326947 Ажлын өрөө: 508 тоот
	Т.Туул (Магистр) Албан тушаал: Оффис менежер Судалгааны чиглэл: Хэл шинжлэл Холбоо барих хаяг: Э-Майл: info@soyolderdem.edu.mn Утас: 326947 Ажлын өрөө: 511 тоот
	М.Удвал (Бакалавр) Албан тушаал: Сургалтын албаны ажилтан Судалгааны чиглэл: Хэл шинжлэл Холбоо барих хаяг: Э-Майл: info@soyolderdem.edu.mn Утас: 70118584 Ажлын өрөө: 505 тоот

МЭРГЭЖЛИЙН ТЭНХИМҮҮД, СУРГАЛТ ЯВУУЛЖ БУЙ ХӨТӨЛБӨРҮҮД ЯПОН СУДЛАЛЫН ТЭНХИМ

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Анх 1993 оны 9 сард япон хэлний дамжаа байгуулан япон хэлний сургалтын үйл ажиллагаа явуулж байгаад улмаар 1996 оноос Соёл Эрдэм дээд сургууль болон өргөжсөн. Иймд манай Япон судлалын тэнхим нь байгуулагдаад 32 жил болсон гэж үздэг. Байгуулагдсан цагаас нь эхлэн Монгол Японы олон эрдэмтэн багш нар япон хэлний тэнхмийн үйл ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, япон хэл, соёл, зан заншлыг заан таниулахад хувь нэмрээ оруулан ажиллаж байна. Япон хэлний багш-орчуулагч мэргэжлээр төгсгөж байгаад 2000 оноос Олон улсын эдийн засагч, Олон улсын сэтгүүлч, Аялал жуулчлалын менежмент зэрэг мэргэжлийн ангиуд нэмэгдсэн. Тус сургуулийн бүх ангийн оюутнууд мэргэжлээс хамаарахгүйгээр 4 жилийн турш япон хэл сурах боломжтой байдаг бөгөөд япон хэлний ангийн оюутнууд төгсөлтийн дипломын ажлыг япон хэлээр бичиж хамгаалдаг.

2022-2023 оны хичээлийн жилээс эхлэн Япон судлалын тэнхим нэртэйгээр сургалт хүмүүжлийн үйл ажиллагаагаа явуулж байна.

Япон судлалын тэнхим нь өдөр тутмын сургалт явуулахын зэрэгцээ соёл хүмүүжлийн ажлыг идэвхтэй зохион явуулдаг. Жил бүрийн 12 сард “Бүнкёосай” хэмээх япон хэл, соёлын баярыг зохиож оюутнууд япон дуу дуулан, шүлэг уншиж, уран илтгэл тавин, жүжиг тоглож, үеийн найз нөхөд эцэг эхдээ тайлагнадаг. Түүнээс гадна сар бүр Японы соёлыг танилцуулах төрөл бүрийн арга хэмжээг зохион байгуулдаг. Жишээлбэл “Миний мэдэх Япон орон” асуулт хариултын тэмцээн, Цаасан нугалбарын сургалт, “Ханз үсгээр хэн сайхан бичих вэ?” уралдаан, “Камишибай буюу зурагт үлгэрийг хэн сайн ярих вэ?”, “Япон дууг хэн сайн дуулах вэ?” зэрэг олон тэмцээн уралдааныг жил бүр амжилттай явуулж байна.

Тус тэнхимд японы мэргэжилтэн багш нар болон японд мэргэжил дээшлүүлсэн туршлагатай багш нар ажиллаж, анхан шатны япон хэл, япон хэлний ханз, дунд болон ахисан шатны дүрэм, зохион бичлэг, японы түүх, японы уран зохиол, аман орчуулга, аяллын япон хэл, харьцуулсан хэлзүй, япон монгол орчуулга зэрэг олон төрлийн хичээлийг япон хэлээр зааж байна. Багш нар жил бүр япон хэлний багш нарын сургалт семинарт оролцох, япон хэлний түвшин тогтоох шалгалтад ассистант багшаар ажиллах зэргээр Монголын япон хэлний багш нарын холбооны үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог.

Японы засгийн газрын тэтгэлгээр 1999 оноос хойш олон оюутан Япон улсад суралцсан байна. Мөн тус сургуулийн оюутнууд Япон улсад хэлний дадлага хийхийн зэрэгцээ хамтын ажиллагаатай Японы олон их дээд сургууль, коллежид элсэн суралцах боломжтой байдаг.

БАГШЛАХ БҮРЭЛДЭХҮҮН

	М.Мөнхцэцэг (Магистр) Албан тушаал: Япон судлалын тэнхимийн эрхлэгч Судалгааны чиглэл: Хэл шинжлэл, хүний нэрийн эш Холбоо барих хаяг: Э-Майл: info@soyolerdem.edu.mn Утас: 326947 Ажлын өрөө: 511 тоот
	Ц.Пүрэвсүрэн (Доктор, профессор) Албан тушаал: Ахисан түвшний сургалтын албаны дарга, япон хэлний багш Судалгааны чиглэл: Хэл шинжлэл Холбоо барих хаяг: Э-Майл: : info@soyolerdem.edu.mn Утас: 326947 Ажлын өрөө: 511 тоот
	Жаргал (дэд профессор) Албан тушаал: Япон хэлний багш Судалгааны чиглэл: Хэл шинжлэл Холбоо барих хаяг: Э-Майл: info@soyolerdem.edu.mn Утас: 326947 Ажлын өрөө: 511 тоот
	Асами Коичиро (Магистр) Албан тушаал: Япон хэлний багш Судалгааны чиглэл: Япон уран зохиол орчуулга Холбоо барих хаяг: Э-Майл: : info@soyolerdem.edu.mn Утас: 326947 Ажлын өрөө: 511 тоот
	Н.Галиймаа (Доктор, профессор) Албан тушаал: дэд профессор, аялал жуулчлалын багш Судалгааны чиглэл: Түүх, улс төр судлал Холбоо барих хаяг: Э-Майл: : info@soyolerdem.edu.mn Утас: 326947 Ажлын өрөө: 511 тоот
	М:Уянга (Магистр) Албан тушаал: Орон судлалын багш Судалгааны чиглэл: Түүх, хэл шинжлэл Холбоо барих хаяг: Э-Майл: : info@soyolerdem.edu.mn Утас: 326947 Ажлын өрөө: 511 тоот

СУРГАЛТ ЯВУУЛЖ БАЙГАА ХӨТӨЛБӨРҮҮД

Япон судлалын тэнхимээс хариуцан явуулдаг мэргэжлүүдээр суралцсанаар олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн япон хэлний орчуулагч болохоос гадна ерөнхий эрдмийн суурь хичээлүүд, орчуулгын онол, судалгааны арга зүйн суурь мэдлэг зэрэг мэргэжлийн үндсэн ур чадваруудыг эзэмшихээс гадна, бүтээлч ба шүүмжит сэтгэлгээ, багаар ажиллах болон харилцааны ур чадамжуудыг эзэмших болно. Суралцаж төгссөний дараа монгол болон япон улсад үйл ажиллагаагаа явуулж байгаа компаниудад ажиллахаас гадна өөрөө компани байгуулан бизнес эрхлэх, гадаадад мэргэжлээрээ ажиллах бүрэн боломжтой.

Хөтөлбөрийн боловсролын зорилго (PEOs)

Зорилт 1. Суурь мэдлэг эзэмшүүлэх

Орчин цагийн япон хэлийг чөлөөтэй ашиглах үндэс болохын хувьд япон хэлний түвшин тогтоох JLPT шалгалтын N1, N2 хүртэлх түвшний үгийн сан, хэл зүйн мэдлэг, сонсох, бичих, унших, ярих дадал чадварыг эзэмшүүлэх

Зорилт 2. Мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэх

Нийгэм ахуйн өргөн хүрээтэй сэдвээр хоёр хэлний аман болон бичгийн орчуулгын суурь дадал чадвар эзэмшүүлэх

Зорилт 3. Бусад чадвар

Хэл шинжлэл, соёл судлал, түүх, эдийн засаг, нийгэм судлалын онолын суурь болон мэргэжлийн мэдлэг эзэмшсэний үндсэн дээр япон судлал, харьцуулсан болон япон хэл шинжлэл, орчуулга судлалын тодорхой сэдвээр байгаль, нийгэм, хүмүүнлэгийн шинжлэлийн ухааны зааг дээр мэдээллийн сан бүрдүүлэх, баримт мэдээлэл боловсруулах, судалгаа шинжилгээ хийх, асуудал шийдвэрлэх, үр дүнг танилцуулах, ашиглах чадвар эзэмшүүлэх

Зорилт 4. Харилцаа төлөвшил

Үндэсний болон хүн төрөлхтний нийтлэг соёл, ёс суртахуун, ёс зүйн хэм хэмжээг эзэмшиж, оюуны болон бие бялдрын хөгжлийн хувьд өөрийгөө цааш хөгжүүлэх эерэг хандлага, идэвхтэй сэдэл төлөвшүүлж, тогтвортой хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх бие хүн ий суурь чадвар эзэмшүүлэх

Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгүүд (PLOs)

- 2.1 Монгол болон япон хэлний хэлзүй, үгсийн сан, найруулга, хэв маяг, соёлын ялгааг гүнзгий ойлгож хэрэглэх (Apply)
- 2.2 Япон хэлээр унших, ярих, бичих, сонсох чадварыг эзэмшиж хэрэглэх (Apply)
- 2.3 Орчуулгын онол, арга зүйн практик мэдлэгтэй байж, орчин үеийн орчуулгын технологийг хэрэглэх (Apply)
- 2.1 Монгол болон япон хэлний бүтцийн ялгааг шинжлэх дүгнэх (Identify, Analyze and Solve)
- 2.2 Орчуулгын утга, соёлын өнгө аясыг зөв тайлбарлах (Interpret), туршилтын үр дүнг хэрэглэх (Apply)
- 3.1 Мэргэжлийн орчуулгын төрлийг зөв тохируулан орчуулах (Apply)
- 3.2 орчуулгын чиглэлээр бие даан судалгаа хийж, кейс шинжилгээ хийх чадвар эзэмших (Apply and demonstrate)
- 3.3 Орчуулгын чанар, найруулгыг үнэлэх, дүгнэлт өгөх Explain, Analyze)
- 4.1 Мэргэжлийн ёс зүй, үнэнч байдлыг эрхэмлэх
- 4.2 Соёл хоорондын харилцаанд нээлттэй, эерэг байх
- 4.3 Бие даан болон багаар ажиллах чадвартай байх

БАКАЛАВРЫН СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Мэргэжил: Гадаад хэлний орчуулга

Мэргэжлийн зэрэг : Бакалавр

Мэргэжлийн индекс: 023101

Суралцах хугацаа: 4 жил

Сургалтын хэлбэр: Өдөр

Элсэгчдийн боловсролын түвшин: Бүрэн дунд

Нийт кредит: 120

№	Хичээлийн код	Хичээлийн нэр	Багц цаг	Хичээлийн залгамж холбоо	Улирал
	I. ЕРӨНХИЙ СУУРЬ БОЛОВСРОЛ ОЛГОХ ХИЧЭЭЛ		38		
Заавал суралцах хичээл					
1	D.ML101	Монгол хэл, найруулга зүй	3		1A
2	D.PE107	Биеийн тамир	2		1A
3	D.SS101	Монголын түүх, соёл	3		1A

4	D.JG109	Япон хэлний дүрэм үгийн сан	3	D.PI105	1A
5	D.JR110	Анхан шатны япон хэлний унших бичих	3	D.PI105	1A
6	D.JK112	Анхан шатны ханз	3	D.PI105	1A
7	D.PI105	Мэргэжлийн удиртгал	3		1Б
8	D.DM106	Гамшигаас хамгаалах менежмент	1		1Б
9	D.IT103	Мэдээллийн технологийн үндэс хэрэглээ	3		1Б
10	D.JS111	Анхан шатны япон хэлний ярих сонсох	3	D.PI105	1Б
11	D.JK203	Дунд шатны ханз	3	D.JK112	1Б
12	D.EL201	Англи хэл	3		2A
13	D.CE104	Иргэний боловсрол	3		2Б
14	D.RM108	Судалгааны арга зүйн үндэс	2		2A
II. МЭРГЭЖЛИЙН СУУРЬ МЭДЛЭГ ОЛГОХ ХИЧЭЭЛ			29		
Заавал суралцах хичээл					
15	D.JG200	Дунд шатны япон хэлний хэл зүй	3	D.JG109	2A
16	D.JR201	Ахисан дунд япон хэлний унших бичих	3	D.JR110	2Б
17	D.JK210	Ханз	3	D.JK203	2A
18	D.JS202	Ахисан дунд япон хэлний ярих сонсох	3	D.JS111	2A
19	D.JW204	Япон-Монгол бичгийн орчуулга	3	D.JG200	2Б
20	D.JV205	Япон хэлний үгийн сан судлал	3	D.JG200	2Б
21	D.JT206	Аялалын япон хэл	3	D.JS202	3A
22	D.EL207	Англи хэл	3	D.EN113	2Б
23	D.TT208	Орчуулгын онол	1	D.ML101	2A
24	D.LG209	Хэл шинжлэлийн удиртгал	2	D.ML101	2Б
25	D.SP114	Танилцах дадлага	2		1Б
III. МЭРГЭЖЛИЙН ХИЧЭЭЛ			50		
Заавал суралцах хичээл					
26	D.JG300	Дээд шатны япон хэлний хэл зүй	3	D.JG200	3A
27	D.JR301	Дээд шатны япон хэлний унших бичих	3	D.JR201	3Б
28	D.JS302	Дээд шатны япон хэлний ярих сонсох	3	D.JS202	3A
29	D.JW204	Монгол- япон бичгийн орчуулга	3	D.JW204	3Б
30	D.JWT304	Япон монгол аман орчуулга	3	D.JW304	3A
31	D.JS306	Дээд шатны аман ба бичгийн япон хэл	3	D.JS302	4Б
32	D.JI307	Монгол япон аман орчуулга	3	D.JS302	3Б
33	D.JH308	Японы түүх	3	D.JG300	4A
34	D.JS309	Япон орон судлал	3	D.JH309	3A
35	D.JSOT31	Мэргэжлийн япон хэлний орчуулга	3	D.JW204	4Б
36	D.JC313	Япон хэлний найруулга зүй	3	D.JAW305	3Б
37	D.JS314	Япон хэлний илтгэх ур чадвар	3	D.JS306	3A
38	D.JOT315	Япон хэлний албан бичгийн орчуулга	3	D.JWT304	4A
39	D.THES316	Бакалаврын судалгааны ажил	3	D.RM108	4A
40	D.INTE317	Үйлдвэрлэлийн дадлага	2	D.SP114	4Б
41	D.JTP318	Орчуулгын дадлага	3	D.JSO312	3Б
42	D.JE319	Англи хэл	3	D.EL207	4A
IV. СОНГОН СУРАЛЦАХ ХИЧЭЭЛҮҮД			3		
43	D.JAW305	Эрдэм шинжилгээний орчуулга	3	D.JG300	3A
44	D.JB310	Бизнесийн япон хэл	3	D.JP317	4A
45	D.JL312	Японы уран зохиолын тойм	3	D.JH306	3Б
НИЙТ КРЕДИТ			120		

Жич: Япон улсад Интерншип хөтөлбөрт хамрагдсан тохиолдолд дараах байдлаар кредит тооцно.

1. 3 сарын Интерншип хөтөлбөрт хамрагдвал 3 кредит
2. 6 сарын Интерншип хөтөлбөрт хамрагдвал 6 кредит
3. 9 сарын Интерншип хөтөлбөрт хамрагдвал 9 кредит
4. 12 сарын Интерншип хөтөлбөрт хамрагдвал 12 кредит

**ГАДААД ХЭЛНИЙ ОРЧУУЛГА БАКАЛАВРЫН ХӨТӨЛБӨРИЙН
ОЮУТАНД САНАЛ БОЛГОХ СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Улирлаар

Намар 1А			Хавар 1Б		
Код	Хичээлийн нэр	Кр	Код	Хичээлийн нэр	Кр
D.ML101	Монгол хэл, найруулга зүй	3	D.DM106	Гамшигаас хамгаалах менежмент	1
D.PE107	Биеийн тамир	2	D.IT103	Мэдээллийн технологийн үндэс хэрэглээ	3
D.SS101	Монголын түүх, соёл	3	D.JS111	Анхан шатны япон хэлний ярих сонсох	3
D.JG109	Япон хэлний дүрэм үгийн сан	3	D.SP114	Танилцах дадлага	2
D.JR110	Анхан шатны япон хэлний унших бичих	3	D.JK203	Дунд шатны ханз	3
D.JK112	Анхан шатны ханз	3	D.PI105	Мэргэжлийн удиртгал	3
Нийт		17	Нийт		15
Намар 2А			Хавар 2Б		
D.EL201	Англи хэл	3	D.JR201	Ахисан дунд япон хэлний унших бичих	3
D.JG200	Дунд шатны япон хэлний хэл зүй	3	D.LG209	Хэл шинжлэлийн удиртгал	2
D.JS202	Ахисан дунд япон хэлний ярих сонсох	3	D.JW204	Япон-Монгол бичгийн орчуулга	3
D.JK210	Ханз	3	D.JV205	Япон хэлний үгийн сан судлал	3
D.RM108	Судалгааны арга зүйн үндэс	2	D.EL207	Англи хэл	3
D.TT208	Орчуулгын онол	1	D.JR201	Ахисан дунд япон хэлний унших бичих	3
Нийт		15	D.CE104	Иргэний боловсрол	3
Намар 3А			Нийт		20
D.JG300	Дээд шатны япон хэлний хэл зүй	3	Хавар 3Б		
D.JS302	Дээд шатны япон хэлний ярих сонсох	3	D.JR301	Дээд шатны япон хэлний унших бичих	3
D.JWT304	Япон монгол аман орчуулга	3	D.JW204	Монгол- япон бичгийн орчуулга	3
D.JS309	Япон орон судлал	3	D.JI307	Монгол япон аман орчуулга	3
D.JS314	Япон хэлний илтгэх ур чадвар	3	D.JTP318	Орчуулгын дадлага	3
D.JT206	Аялалын япон хэл	3	D.JC313	Япон хэлний найруулга зүй	3
Нийт		18	Нийт		15
Намар 4А			Хавар 4Б		
D.JH308	Японы түүх	3	D.JS306	Дээд шатны аман ба бичгийн япон хэл	3
D.JOT315	Япон хэлний албан бичгийн орчуулга	3	D.JSOT31	Мэргэжлийн япон хэлний орчуулга	3
D.JE319	Англи хэл	3	D.THES316	Бакалаврын судалгааны ажил	3
D.INT317	Үйлдвэрлэлийн дадлага	2	Нийт		9
Нийт		11			

Хөтөлбөрийн боловсролын зорилтууд (PEOs)

Олон улсын жишиг стандартад нийцсэн “Аялал жуулчлал”-ын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж япон, англи хэлтэй, дотоод ба олон улсын хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээг хангаж чадах мэдлэг, чадвар, чадамжтай, ёс зүйтэй мэргэжилтнүүдийг бэлтгэн гаргахад оршино.

Зорилт 1: Соёл, уламжлалаа дээдлэх

Монголын уламжлалт соёлын талаар зохих мэдлэгтэй байж жуулчдад Монголын түүх, соёлын талаар бодит мэдээллийг өгөх мэдлэг олгох

Зорилт 2: Эрдэм мэдлэгийн эрхэмлэх

Аялал жуулчлалын үйлдвэрлэлийн системтэй мэдлэг эзэмшиж, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ бий болгох мэдлэг, чадвартай, салбарын хөгжлийн чиг хандлагыг олж хардаг, салбарт тулгарч буй асуудлыг тодорхойлж чадахуйц мэдлэгийг олгох

Зорилт 3: Даяаршсан хөгжлийг хүндэтгэх

Олон улсын жуулчдын сэтгэлгээ, зан төлвийн талаарх суурь мэдлэгийг олгож, практикт ашиглаж сургах, аялал жуулчлалын нийгэм, соёлын асуудлыг өргөн хүрээнд харах, Япон, англи хэл, технологийн мэдлэг эзэмшүүлэх, эерэг хандлага, танин мэдэх, бие даан суралцах болон харилцааны ур чадвар чадвар эзэмшүүлэх

Зорилт 4: Судалгааны төгөлдөршилд тэмүүлэх

Судалгаа, шинжилгээ хийх, аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэх чадвар чадамжийг хөгжүүлэх болон бүтээлч сэтгэлгээ, шинийг санаачлагч сэтгэлгээг эзэмших Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгүүд (PLOs)

д/д	Үр дүнгийн жагсаалт CDIO Силлабус 2-р хувилбарын 3-р түвшинд
1.	Мэдлэг ба практик ур чадвар (мэргэжлийн онолын мэдлэг, ур чадвар, насан туршийн боловсрол)
1.1.	Соёл, түүх, нийгмийн суурь мэдлэг
1.2.	Аялал жуулчлалын орчин: эдийн засаг, нийгэм, хүн ам зүй, хүрээлэн буй орчин, улс төр, олон улсын харилцаа
1.3.	Аялал жуулчлалын салбарын цогц ойлголт
1.4.	Олон улсын аялал жуулчлалын суурь мэдлэг
1.5.	Аялал жуулчлалын салбарын хууль эрхзүй, дүрэм журам, мөрддөг стандарт, стандарчиллын тухай мэдлэг
1.6.	Аялал жуулчлалын судалгааны арга, арга зүй
2.	Зөөлөн ур чадвар (Эргэцүүлэлт сэтгэлгээ, хамтран ажиллах, харилцах чадвар, бүтээлч байдал)
2.1.	Санаачилгатай гаргаж сурах, тодорхой бус нөхцөлд шийдвэр гаргахад бэлэн байх
2.2.	Бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх
2.3.	Эргэцүүлэлт сэтгэлгээнд сурах
2.4.	Ёс зүйн төлөвшил
2.5.	Харилцааны ур чадварт суралцах
2.6.	Бичгийн харилцаанд суралцах
2.7.	Япон ба хоёрдогч гадаад хэлээр ярих, бичих чадварыг эзэмших
3.	Дижитал ур чадвар, соёл (мэдээллийн технологийг ашиглах ур чадварын цогц)
3.1.	Цахим болон мультимедиа харилцааг эзэмших
3.2.	Судалгааны аль нэг программ дээр ажиллаж сурах
4.	Инноваци, бүтээлч ур чадвар
4.1.	Жуулчдын сэтгэл зүй, хандлагыг мэдэрч, зөв үйлдэл хийх
4.2.	Аялал жуулчлалын тухайн нөхцөл байдалд дүгнэлт хийж, асуудлыг шийдвэрлэх
4.3.	Аялал жуулчлалын салбарын аливаа асуудалд тогтвортой хөгжлийн байр сууринаас хандах
5.	Танин мэдэх чадвар (когнитив ур чадвар)
5.1.	Аялал жуулчлалын салбарын хөгжил, тулгамдаж буй асуудлыг олон талаас нь харж сурах
5.2.	Судалгааны ажлыг эргэлтэд оруулах

**"АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ" БАКАЛАВРЫН ХӨТӨЛБӨРИЙН
СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Мэргэжлийн индекс: 101501

Боловсролын зэрэг: Бакалавр

Суралцах хугацаа: 4 жил

Сургалтын хэлбэр: Өдөр

Элсэгчдийн боловсролын түвшин: Бүрэн дунд

№	Индекс	Хичээлийн нэр	Багц цаг	Өмнөх холбоо	Улирал
АI.Ерөнхий суурь боловсрол олгох хичээл					
Заавал судлах хичээл					
1	D.ML101	Монгол хэл, найруулга зүй	3		1А
2	D.SS101	Монголын түүх	3		1А
3	D.IT103	Мэдээллийн технологийн хэрэглээ	2		1Б
4	D.CE104	Иргэний боловсрол	3		1Б
6	D.DM106	Гамшигаас хамгаалах менежмент	1		1Б
7	D.PE107	Биеийн тамир	2		1А
8	D.JG109	Япон хэлний дүрэм үгийн сан	3	D.PI105	1А
9	D.JR110	Анхан шатны япон хэлний унших бичих дадал	3	D.PI105	1А
10	D.JS111	Анхан шатны япон хэлний ярих сонсох дадлага	3	D.PI105	1Б
11	D.JK112	Анхан шатны ханз	3	D.PI105	1А
12	D.EL201	Англи хэл	3		2А
Iхэсгийн багц цагийн дүн			29		
Б.Мэргэжлийн суурь мэдлэг олгох хичээл					
Заавал судлах хичээл					
13	D.JG200	Дунд шатны япон хэлний хэл зүй	3	D.JG109	2А
14	D.JR201	Дунд шатны япон хэлний унших бичих дадал	3	D.JR110	2Б
15	D.JS202	Дунд шатны япон хэлний ярих сонсох дадлага	3	D.JS111	2А
16	D.JK203	Дунд шатны ханз	3	D.JK112	2Б
17	D.TR200	Аялал жуулчлалын үндэс	3		1Б
18	D.TR201	Монгол орны аялал жуулчлалын газар зүй	3		1Б
19	D.TR202	Аялал жуулчлалын хэрэглэгчдийн зан төлөв	3	D.TR100	2А
20	D.EL208	Англи хэл	3	D.EL201	2Б
II хэсгийн багц цагийн дүн			24		
В.Мэргэжлийн хичээл					
Заавал судлах хичээл					
21	D.TR300	Аялал жуулчлалын судалгааны арга зүй, арга	3	D.TR200	2Б
22	D.TR301	Аялал жуулчлалын менежмент	3	D.TR202	3Б
23	D.TR302	Орчуулагч, хөтчийн үйлчилгээний технологи	3	D.TR200	3А
24	D.TR303	Зочлох үйлчилгээний маркетинг	3	D.TR202	3А
25	D.TR304	Соёл, соёлын өвийн аялал жуулчлал	3		3А
26	D.TR305	Амралт, чөлөөт цагийн бизнес	3		2А
27	D.TR306	Аялал жуулчлалын зорин очих газрын маркетинг	3		3Б
28	D.JP306	Аялал жуулчлалын япон хэл	3	D.JP306	3А
29	D.TR307	Олон улсын аялал жуулчлал	3		4А
30	D.TR308	Бүтээгдэхүүн ба тур операторын менежмент	3		3Б
31	D.TR309	Аялал жуулчлалын мэдээлэл, захиалгын системүүд	3		4А
32	D.TR310	Аялал жуулчлалын төсөл	3	D.TR300	4Б
Дадлага			8		
33	D.TR315	Танилцах дадлага /аялал/	2		2Б
34	D.TR316	Үйлдвэрлэлийн дадлага /аялал/	2		дурын

34	D.TR317	Үйлдвэрлэлийн дадлага	2		дурын
35	D.TR318	Хээрийн дадлага	2		дурын
Төгсөлтийн ажил					
36	D.TR319	Бакалаврын төгсөлтийн ажил	5		
III хэсгийн багц цагийн дүн			49		
Заавал судлах хичээлүүдийн багцын задаргаа					
1	Ерөнхий суурь		29		
2	Мэргэжлийн суурь		24		
3	Мэргэжлийн		49		
Бүгд дүн			102		
Д. Сонгон суралцах хичээлүүд					
1	D.HD103	Монголын уламжлалт соёл	2		дурын
2	D.JH308	Японы түүх	3		дурын
3	D.TR203	Аялал жуулчлалын нөөц	2		дурын
4	D.TR204	Тусгай сонирхлын аялал жуулчлал	3		дурын
5	D.TR205	Зочид буудал, зоогийн газар стандартчилал	3		дурын
6	D.TR311	Аялал жуулчлалын бизнес эрх зүй	2		дурын
7	D.TR312	Аялал жуулчлалын аюулгүй байдал, аяллын бэлтгэл	2		дурын
8	D.JB310	Бизнесийн япон хэл	3		дурын
9	D.JE319	Англи хэл	3		дурын
10	D.TR313	Эвент менежмент	3		дурын
11	D.TR314	Тогтвортой аялал жуулчлал	3		дурын
12	D.JT206	Япон монгол бичгийн орчуулга	3		дурын
Сонгон хичээл			18		
1	Заавал судлах хичээлүүд		102		
2	Сонгон суралцах хичээлүүд		18		
Бүгд дүн			120		

"АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ" БАКАЛАВРЫН ХӨТӨЛБӨРИЙН ОЮУТАНД САНАЛ БОЛГОХ СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Намар 1А

Код	Хичээлийн нэр	Кр
D.ML101	Монгол хэл, найруулга зүй	3
D.PE107	Биеийн тамир	2
D.JG109	Япон хэлний дүрэм үгийн сан (N5,N4)	3
D.JR110	Анхан шатны япон хэлний унших бичих дадал (N5)	3
D.JK112	Анхан шатны ханз	3
D.SS101	Монголын түүх	3

Нийт **17**

Намар 2А

Код	Хичээлийн нэр	Кр
D.EN113	Англи хэл	3

Улирлаар

Хавар 1Б

Код	Хичээлийн нэр	Кр
D.TR200	Аялал жуулчлалын үндэс	3
D.CE104	Иргэний боловсрол	3
D.DM106	Гамшигаас хамгаалах менежмент	1
D.JS111	Анхан шатны япон хэлний ярих сонсох дадлага (N5)	3
D.IT103	Мэдээллийн технологийн хэрэглээ	2
D.TR201	Монгол орны аялал жуулчлалын газар зүй	3
	Сонгон судлах хичээл	3

Нийт **18**

Хавар 2Б

Код	Хичээлийн нэр	Кр
-----	---------------	----

D.JG200	Дунд шатны япон хэлний хэл зүй	3
D.JS202	Дунд шатны япон хэлний ярих сонсох дадлага	3
D.TR202	Аялал жуулчлалын хэрэглэгчдийн зан төлөв	3
D.TR305	Амралт, чөлөөт цагийн бизнес	3
	Сонгон судлах хичээл	4
D.TR316	Үйлдвэрлэлийн дадлага	2

Нийт 21

Намар 3А

Код	Хичээлийн нэр	Кр
D.TR302	Орчуулагч, хөтчийн үйлчилгээний технологи	3
D.TR303	Зочлох үйлчилгээний маркетинг	3
D.TR304	Соёл, соёлын өвийн аялал жуулчлал	3
D.JP306	Аялал жуулчлалын япон хэл	3

D.JR201	Дунд шатны япон хэлний унших бичих дадал	3
D.JK203	Дунд шатны ханз	3
D.TR300	Аялал жуулчлалын судалгааны арга зүй, арга	3
D.EL208	Англи хэл	3
	Сонгон судлах хичээл	3
D.TR315	Танилцах дадлага /аялал/	2

Нийт 17

Хавар 3Б

Код	Хичээлийн нэр	Кр
D.TR308	Бүтээгдэхүүн ба тур операторын менежмент	3
D.TR306	Аялал жуулчлалын зорин очих газрын маркетинг	3
	Сонгон хичээл	4
D.TR318	Хээрийн дадлага	2

Хөтөлбөрийн зорилго

Олон улс, орон судлал хөтөлбөр нь Япон орон болон олон улсын улс төр, эдийн засаг, соёл, нийгмийн харилцааг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр судалж, олон улсын харилцаанд ажиллах чадвартай, мэдлэг ур чадвар, ёс зүй хосолсон мэдлэгтэй, бусад улс орны нийгэм улс төр, угсаатан зүй, хэл шинжлэл болон бусад онцлогийн талаар судалгаа хийж нийгмийн үйл явцад ухамсартай оролцогч, амьдралын идэвхтэй байр суурьтай, иргэн болж, цаашид өөрийгөө хөгжүүлэх онол аргазүйн мэдлэг, чадвар, соёлыг төлөвшүүлсэн мэргэжилтэн бэлтгэнэ.

Хөтөлбөрийн зорилтууд:

Зорилт 1. Хэлний мэдлэг

Орчин цагийн япон хэлийг чөлөөтэй эзэмшсэн, япон хэлний түвшин тогтоох JLPT шалгалтын N2 зэрэгт хүрэх үгийн сан, хэлзүйн мэдлэг, хэлэхүйн дадал чадварыг эзэмшүүлэх

Зорилт 2. Олон улсын харилцааны онол, ойлголт олгох

Улс төр судлал, олон улсын эрх зүй, дипломат ёс зүй, улс төрийн хэлэлцээр хийх чадвар, олон үндэстний орчинд ажиллах соёлын мэдрэмж, харилцааны чадвар, олон улсын байгууллагуудын талаар онолын мэдлэг эзэмшүүлнэ. Тухайн бүс нутгийн (япон орны болон бусад орны) түүх соёл, нийгэм улс төр, эдийн засгийн онцлогийг судлана

Зорилт 3. Шүүмжлэлт сэтгэлгээ, судалгааны арга барил эзэмшүүлэх

Нийгмийн ухааны судалгааны арга зүй, дата шинжилгээ, бодлого боловсруулах чадварыг хөгжүүлнэ

Зорилт 4. Практик туршлага олгох

Судалгааны төсөл, бодлого судлалын дадлага, олон улсын байгууллагуудтай хамтарсан хөтөлбөрт оролцох боломж олгоно.

БАКАЛАВРЫН СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Мэргэжил: Олон улс, орон судлал

Мэргэжлийн зэрэг : Бакалавр

Мэргэжлийн индекс:022203

Суралцах хугацаа: 4 жил

Сургалтын хэлбэр: Өдөр

Элсэгчдийн боловсролын түвшин: Бүрэн дунд

Нийт кредит: 120

№	Хичээлийн код	Хичээлийн нэр	Багц цаг	Хичээлийн залгамж холбоо	Улирал
I. ЕРӨНХИЙ СУУРЬ БОЛОВСРОЛ ОЛГОХ ХИЧЭЭЛ			36		
Заавал суралцах хичээл					
1	D.ML101	Монгол хэл, найруулга зүй	3		1А
2	D.PE107	Биеийн тамир	2		1А
3	D.SS101	Монголын түүх, соёл	3		1А
4	D.JG109	Япон хэлний дүрэм үгийн сан	3	D.PI105	1А
5	D.JR110	Анхан шатны япон хэлний унших бичих	3	D.PI105	1А
6	D.JK112	Анхан шатны ханз	3	D.PI105	1А
7	D.JS111	Анхан шатны япон хэлний ярих сонсох	3	D.PI105	1Б
8	D.IT103	Мэдээллийн технологийн үндэс, хэрэглээ	3		1Б
9	D.CE104	Иргэний боловсрол	3		1Б
10	D.PI105	Мэргэжлийн удиртгал	2		1Б
11	D.DM106	Гамшигаас хамгаалах менежмент	1		1Б
12	D.RM108	Судалгааны арга зүйн үндэс	2		2А
Аялал жуулчлалын судалгааны арга зүй, арга нь аялал жуулчлалын салбарын онолын болон туршилтын судалгаанд хэрэглэгддэг судалгааны үндсэн зарчим, аргачлалыг эзэмшүүлэх хичээл юм. Судалгааны асуудал тодорхойлох, судалгааны загвар боловсруулах, анкет, ярилцлага, ажиглалт зэрэг аргуудыг ашиглан бодит мэдээлэл цуглуулж, боловсруулалт хийх ур чадварыг олгоно.

D.TR301-Аялал жуулчлалын менежмент	Кредит: 3
Долоо хоногт орох лекц, семинар, лабораторийн цаг: 2:2:0	

Хичээлийн тодорхойлолт:

Аялал жуулчлалын менежмент нь аялал жуулчлалын байгууллагуудын онцлог, бүтэц, чиг үүргийг судалж, менежментийн суурь функцүүдийг (төлөвлөлт, зохион байгуулалт, манлайлал, хяналт) аялал жуулчлалын орчинд хэрэгжүүлэх арга зүйг эзэмшүүлэх хичээл юм. Оюутан менежментийн орчин үеийн онол, арга, багаж хэрэгслийг ашиглан байгууллагын гүйцэтгэл, чанарыг үнэлэх, сайжруулах арга барилд суралцана.

D.TR302- Орчуулагч хөтөчийн үйлчилгээний технологи	Кредит: 3
Долоо хоногт орох лекц, семинар, лабораторийн цаг: 2:2:0	

Хичээлийн тодорхойлолт:

Хичээл нь орчуулагч хөтөчийн үүрэг, үйлчилгээний үе шат, үйлчлүүлэгчтэй харилцах арга барил, аяллын хэл, орчуулгын арга зүй, хөтөчийн ёс зүй, соёл хоорондын харилцааны онцлогийг судлуулна. Оюутан аяллын тайлбар, орчуулгын дасгал, симуляц, кейсийн судалгаагаар мэдлэгээ бататгана.

D.TR303- Зочлох үйлчилгээний маркетинг	Кредит: 3
Долоо хоногт орох лекц, семинар, лабораторийн цаг: 2:2:0	

Хичээлийн тодорхойлолт:

Зочлох үйлчилгээний маркетинг” хичээл нь үйлчилгээний онцлогт нийцсэн маркетингийн онол, арга зүйг судалж, зочид буудал, жуулчны бааз, ресторан зэрэг байгууллагын зах зээлийн сегментчилэл, байршуулалт, бүтээгдэхүүн үйлчилгээний менежмент, үнэ, хуваарилалт, сурталчилгааны стратегийг боловсруулах арга зүйг эзэмшүүлэх зорилготой.

D.TR304-Соёл, соёлын өвийн аялал жуулчлал	Кредит: 3
Долоо хоногт орох лекц, семинар, лабораторийн цаг: 2:2:0	

Хичээлийн тодорхойлолт:

Хичээл нь соёлын аялал жуулчлалын онол, соёлын биет ба биет бус өвийн менежмент, хамгаалалтын асуудлыг судална. Оюутнууд соёлын аялал жуулчлал ба соёлын өвийн хоорондын харилцан нөлөөллийг, Монголын болон дэлхийн туршлагын жишээн дээр судалж, соёлын өвийг аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгон хөгжүүлэх менежментийн арга зүйд суралцана.

D.TR305- Амралт, чөлөөт цагийн бизнес	Кредит: 3
Долоо хоногт орох лекц, семинар, лабораторийн цаг: 2:2:0	

Хичээлийн тодорхойлолт:

Хичээл нь амралт, чөлөөт цагийн бизнесийн онол, эдийн засгийн суурь ойлголт, үйлчилгээний бүтэц, төрөл, зах зээл, хэрэглэгчийн зан төлөв, амралтын байгууллагын менежмент, төлөвлөлт, маркетинг, бизнесийн загварчлал зэрэг сэдвийг судална.Суралцагчид амралтын газрын бүтэц, бүтээгдэхүүн, үйл ажиллагааны менежментийг судалж, бодит кейс дээр бизнесийн шийдэл боловсруулах чадвар эзэмшинэ.

D.TR306- Аялал жуулчлалын зорин очих газрын маркетинг	Кредит: 3
Долоо хоногт орох лекц, семинар, лабораторийн цаг: 2:2:0	

Хичээлийн тодорхойлолт:

Хичээлийн товч тодорхойлолт: Маркетингийн онол, арга зүй, стратегийн төлөвлөлт, зах зээлийн судалгаа, брэнд бүтээлт, мэдээлэл харилцааны удирдлагыг судална.Оюутнууд аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэлгээ, зорилтот зах зээл, хэрэглэгчийн зан төлөв, өрсөлдөөн, брэндийн имиджийн талаар

судалгаа хийж, DMO буюу зорин очих газрын менежментийн байгууллагын үүрэг, стратеги, хэрэгжилтийн загварыг судална.

D.TR308-Бүтээгдэхүүн ба тур операторын менежмент	Кредит: 3
---	------------------

Долоо хоногт орох лекц, семинар, лабораторийн цаг: 2:2:0

Хичээлийн тодорхойлолт:

Бүтээгдэхүүн ба тур операторын менежмент” хичээл нь аялал жуулчлалын үйлчилгээний бүтэц, бүтээгдэхүүн хөгжүүлэлт, аяллын хөтөлбөр зохион байгуулах, борлуулалт, чанарын менежмент, инновацийн чиг хандлагыг судална. Оюутнууд тур операторын байгууллагын үүрэг, үйл ажиллагаа, зах зээлийн сегмент, бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн стратеги-ийг бодитоор кейсийн түвшинд судалж, бүтээгдэхүүн боловсруулах, менежментийн төлөвлөгөө гаргах чадвар эзэмшинэ.

D.TR309- Аялал жуулчлалын мэдээлэл, захиалгын системүүд	Кредит: 3
--	------------------

Долоо хоногт орох лекц, семинар, лабораторийн цаг: 2:2:0

Хичээлийн тодорхойлолт: “Аялал жуулчлалын мэдээлэл, захиалгын системүүд” хичээл нь аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагаанд ашиглагддаг мэдээллийн технологийн системүүдийн бүтэц, зорилго, гүйцэтгэлийн талаар цогц ойлголт өгнө. Суралцагчид Amadeus, Sabre, Galileo, Fidelio, Opera, Booking.com зэрэг олон улсын системүүдийн үүрэг, бүтэц, харьцуулалт, мэдээлэл дамжуулалтын онцлогийг судалж, системийн хэрэглээний кейс боловсруулж, дижитал аялал жуулчлалын зах зээлийн чиг хандлагыг ойлгоно.

D.TR310-Аялал жуулчлалын төсөл	Кредит: 3
---------------------------------------	------------------

Долоо хоногт орох лекц, семинар, лабораторийн цаг: 2:2:0

Хичээлийн тодорхойлолт:

Төслийн менежментийн үндсэн ойлголт, төслийн амьдралын мөчлөг, санхүүжилтийн төлөвлөлт, үнэлгээ, эрсдэлийн удирдлага, тогтвортой аялал жуулчлалын хөгжлийн хүрээнд төслийг хэрэгжүүлэх арга зүйг судална.

Оюутнууд бодит төслийн санаа гаргаж, төслийн төлөвлөгөө боловсруулах, санхүүгийн тооцоолол хийх, хэрэгжилтийг үнэлэх, илтгэл хэлбэрээр хамгаалах чадвар эзэмшинэ.

D.JP306-Аялал жуулчлалын япон хэл	Кредит: 3
--	------------------

Долоо хоногт орох лекц, семинар, лабораторийн цаг: 2:2:0

Хичээлийн тодорхойлолт:

Аялалын япон хэл хичээлээр Японоос ирсэн жуулчдад Монгол орны байгалийн үзэсгэлэнт газар, түүхийн дурсгалт газар, музейн тайлбарыг Япон хэлээр тайлбарлаж сурна.

D.HD103- Монголын уламжлалт соёл	Кредит: 2
---	------------------

Долоо хоногт орох лекц, семинар, лабораторийн цаг: 2:2:0

Хичээлийн тодорхойлолт:

Монголын уламжлалт соёл" хичээл нь монголчуудын түүхэн уламжлал, ёс заншил, зан үйлийн өв соёлыг судлахад чиглэдэг. Оюутнууд угсаатны соёл, хэл, шашин, урлаг, гар урлал зэрэг олон талт өвийн агуулгыг танин мэдэж, үндэсний үнэт зүйлсийг хадгалах, түгээн дэлгэрүүлэх ач холбогдлыг ойлгоно. Энэ хичээл нь соёлын дархлааг төлөвшүүлэхэд чухал үүрэгтэй.

D.JH308- Японы түүх	Кредит: 3
----------------------------	------------------

Долоо хоногт орох лекц, семинар, лабораторийн цаг: 2:2:0

Хичээлийн тодорхойлолт:

Одоогоор эзэмшсэн япон хэлний унших чадвараа ашиглан та бага сургуулийн түвшинд Японы түүхийн сурах бичгийн агуулгыг уншиж, ойлгох болно.Түүнчлэн, Японы түүхийг судалснаар оюутнууд Японы

түүхийн чухал асуудлууд болон үндэслэлийг ойлгох боломжтой болох бөгөөд энэ нь Японы судалгаа болон Япон хүмүүстэй харилцахад хэрэг болно.

D.TR203-Аялал жуулчлалын нөөц	Кредит: 2
--------------------------------------	------------------

Долоо хоногт орох лекц, семинар, лабораторийн цаг: 2:2:0

Хичээлийн тодорхойлолт:

“Аялал жуулчлалын нөөц” хичээл нь аялал жуулчлалын салбарт ашиглагддаг байгалийн, түүхэн, соёлын болон хүний нөөцийн төрөл, ач холбогдлыг судлахад чиглэдэг. Оюутнууд тухайн нөөцийн онцлог, хамгаалалт, тогтвортой ашиглалтын зарчмуудыг ойлгож, аялал жуулчлалын бүтээгдэхүүн хөгжүүлэхэд хэрхэн үр дүнтэй ашиглах талаар мэдлэг, чадвар эзэмшинэ. Энэ хичээл нь аялал жуулчлалыг хариуцлагатай, тогтвортой байдлаар хөгжүүлэх суурь ойлголтыг төлөвшүүлдэг.

D.TR204- Тусгай сонирхлын аялал жуулчлал	Кредит: 2
---	------------------

Долоо хоногт орох лекц, семинар, лабораторийн цаг: 2:2:0

Хичээлийн тодорхойлолт:

"Тусгай сонирхлын аялал жуулчлал" хичээл нь аялагчдын өвөрмөц хэрэгцээ, сонирхолд нийцсэн аяллын төрөл, зохион байгуулалт, хөгжлийн чиг хандлагыг судалдаг. Оюутнууд байгаль, соёл, адал явдал, эмчилгээ, спорт зэрэг тусгай зориулалтын аяллын онцлог, төлөвлөлт, зах зээлд нэвтрүүлэх арга зүйг эзэмшинэ. Энэ хичээл нь аялал жуулчлалын салбарт төрөлжсөн бүтээгдэхүүн хөгжүүлэх чадамжийг нэмэгдүүлдэг.

D.TR205-Зочид буудал, зоогийн газар стандартчилал	Кредит: 2
--	------------------

Долоо хоногт орох лекц, семинар, лабораторийн цаг: 2:2:0

Хичээлийн тодорхойлолт:

"Зочид буудал, зоогийн газар стандартчилал" хичээл нь үйлчилгээний байгууллагын чанар, аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартуудыг судалж, олон улсын ба үндэсний стандартын шаардлагыг хэрхэн хэрэгжүүлэх талаар мэдлэг олгодог. Оюутнууд зочлох үйлчилгээний салбарт стандартчилалын ач холбогдол, үнэлгээний шалгуур, хяналтын тогтолцоог ойлгож, чанартай үйлчилгээ үзүүлэх чадамжтай болдог. Энэ хичээл нь байгууллагын нэр хүнд, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг.

D.TR311- Аялал жуулчлалын бизнес эрх зүй	Кредит: 2
---	------------------

Долоо хоногт орох лекц, семинар, лабораторийн цаг: 2:2:0

Хичээлийн тодорхойлолт:

"Аялал жуулчлалын бизнес эрх зүй" хичээл нь аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа эрхлэхэд чухал хууль, эрх зүйн зохицуулалтыг судлахад чиглэдэг. Оюутнууд гэрээ, лиценз, даатгал, хэрэглэгчийн эрх, зохицуулах байгууллагын үүрэг зэрэг эрх зүйн үндсэн ойлголтуудыг эзэмшиж, бизнесийн үйл ажиллагааг хуульд нийцүүлэн зохион байгуулах чадвартай болдог. Энэ хичээл нь аялал жуулчлалын салбарт хариуцлагатай, ёс зүйтэй менежмент хийх суурь мэдлэгийг олгодог.

D.TR312- Аялал жуулчлалын аюулгүй байдал, аяллын бэлтгэл	Кредит: 2
---	------------------

Долоо хоногт орох лекц, семинар, лабораторийн цаг: 2:2:0

Хичээлийн тодорхойлолт:

"Аялал жуулчлалын аюулгүй байдал, аяллын бэлтгэл" хичээл нь аялагчдын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах, эрсдэлийг бууруулах, аяллын өмнөх бэлтгэлийг зохион байгуулах арга зүйг судалдаг. Оюутнууд гамшгийн үед авах арга хэмжээ, даатгал, анхны тусламж, аюулгүй маршрутын төлөвлөлт зэрэг чухал мэдлэг, ур чадварыг эзэмшинэ. Энэ хичээл нь хариуцлагатай, аюулгүй аялал зохион байгуулах чадамжийг төлөвшүүлдэг.

D.JB310- Бизнесийн япон хэл	Кредит: 3
------------------------------------	------------------

Долоо хоногт орох лекц, семинар, лабораторийн цаг: 2:2:0

Хичээлийн тодорхойлолт:

Бизнес эрхлэхэд шаардлагатай япон хэл болон бизнесийн ёс зүйг сурна.

D.TR313- Эвент менежмент	Кредит: 3
Долоо хоногт орох лекц, семинар, лабораторийн цаг: 2:2:0	

Хичээлийн тодорхойлолт:

"Эвент менежмент" хичээл нь арга хэмжээ, баяр ёслол, хурал, үзэсгэлэн зэрэг олон нийтийн үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, удирдах арга зүйг судалдаг. Оюутнууд төсөв боловсруулах, логистик зохион байгуулалт, маркетинг, эрсдэлийн удирдлага зэрэг чухал ур чадваруудыг эзэмшинэ. Энэ хичээл нь бүтээлч сэтгэлгээ, нарийн төлөвлөлт, багийн ажиллагааг хөгжүүлэхэд чиглэдэг.

D.TR314- Тогтвортой аялал жуулчлал	Кредит: 3
Долоо хоногт орох лекц, семинар, лабораторийн цаг: 2:2:0	

Хичээлийн тодорхойлолт:

"Тогтвортой аялал жуулчлал" хичээл нь байгаль орчин, нийгэм, эдийн засгийн тэнцвэрт байдлыг хадгалсан аялал жуулчлалыг хэрхэн төлөвлөх, хэрэгжүүлэх талаар судалдаг. Оюутнууд нөөцийн хэмнэлт, орон нутгийн оролцоо, соёлын өвийг хамгаалах зэрэг тогтвортой хөгжлийн зарчмуудыг аяллын үйл ажиллагаанд хэрхэн уялдуулахыг суралцана. Энэ хичээл нь хариуцлагатай, ирээдүйд чиглэсэн аялал жуулчлалын менежментийн суурь ойлголтыг төлөвшүүлдэг.

D.JT206- Япон Монгол бичгийн орчуулга	Кредит: 3
Долоо хоногт орох лекц, семинар, лабораторийн цаг: 2:2:0	

Хичээлийн тодорхойлолт:

Хичээлээр орчуулагч мэргэжлийн мөн чанар, онцлогийн талаарх онолын мэдлэгтээ тулгуурлан гадаад хэлнээс эх хэл рүүгээ хийх бичгийн орчуулгын үндсэн арга барилд суралцахын хамт япон хэлний хэлзүй, үгсийн сангийн мэдлэгийг гүнзгийрүүлнэ.

D.MT201- Магадлалын онол ба математик статистик	Кредит:3
Долоо хоногт орох лекц, семинар, лаборатори, бие даалтын цаг: 2:2:0	

Хичээлийн тодорхойлолт:

Магадлалын онолын үндсэн ойлголт болох санамсаргүй үзэгдэл, түүний магадлал, санамсаргүй хэмжигдэхүүн болон математик статистик аргуудыг судална.

D.CS204-Компьютерын сүлжээ	Кредит:3
Долоо хоногт орох лекц, семинар, лаборатори, бие даалтын цаг: 1:1:2	

Хичээлийн тодорхойлолт:

Хичээлээр компьютерын сүлжээний суурь ойлголтууд, үүсэл хөгжил, сүлжээний OSI болон TCP/IP түвшинт загвар, түгээмэл ашиглагдах протоколууд, IPx4, IPx6 хаяглал, сүлжээний хуваалт, свичийн (виртуал дотоод сүлжээ, транк холболт, виртуал дотоод сүлжээнүүдийн замчлал) болон замчлагчийн технологиудаас (статик, динамик замчлал, динамик замчлалын протоколууд, хаягийн хувиргалт, хостыг автоматаар хаяглах) судлах болно.

D.CS303-Тоон систем	Кредит:3
Долоо хоногт орох лекц, семинар, лаборатори, бие даалтын цаг: 2:0:2	

Хичээлийн тодорхойлолт:

Хичээлээр кодер ба декодер, нэмэгч ба хасагч, мультиплексор ба демультиплексор, харьцуулагч, арифметик логик байгууламж зэрэг комбинацын хэлхээнүүд болон латч, флип-флопууд, Мийлийн ба Моорийн машин, төлөвийн диаграмм, регистр, тоолуур зэрэг дараалсан утгын хэлхээний төрөл, ажиллагаа, эдгээрт анализ хийх болон зохион бүтээх аргуудыг судална.

D.CS201-Компьютерын архитектур ба ассемблер хэл	Кредит: 3
--	------------------

Долоо хоногт орох лекц, семинар, лаборатори, бие даалтын цаг: 2:0:2**Хичээлийн тодорхойлолт:**

Уг хичээлээр ерөнхий зориулалтаар хэрэглэгдэж байгаа компьютерын дотоод бүтэц, түүний үндсэн байгууламжууд болон бүрэлдэхүүн хэсгүүдийн зохион байгуулалт, үүрэг ажиллагаа, физик үндсийн талаар мэдлэг олгоно.

D.CS320-Өгөгдлийн сангийн аюулгүй байдал**Кредит: 3****Долоо хоногт орох лекц, семинар, лаборатори, бие даалтын цаг: 2:0:2****Хичээлийн тодорхойлолт:**

Өгөгдлийн сангийн аюулгүй байдлын хэрэгжүүлэлтийн зарчмууд болон практик арга техникүүдийг судална. Үүний тулд өгөгдлийн санг зохион байгуулах, өгөгдлийн аюулгүй байдлын зарчмууд, өгөгдлийн сангийн аюулгүй байдлын шалгалт, аюулгүй байдлын хэрэгжүүлэлт болон өгөгдлийн сангийн найдвартай байдлыг хангах зэрэг ойлголтуудыг судална.

D.CS306-Веб системийн аюулгүй байдал**Кредит: 3****Долоо хоногт орох лекц, семинар, лаборатори, бие даалтын цаг: 2:0:2****Хичээлийн тодорхойлолт:**

Веб системийн аюулгүй байдлын асуудлуудтай танилцах, веб системийг хакердах, хамгаалах арга зүйтэй танилцана.

D.CS309-Хиймэл оюуны ба машин сургалт**Кредит: 3****Долоо хоногт орох лекц, семинар, лаборатори, бие даалтын цаг: 2:0:2****Хичээлийн тодорхойлолт:**

Хиймэл оюун ухаан (AI) нь хүний ухаалаг зан байдлыг компьютер дээрээс хэрхэн ухамсарлахыг судалдаг судалгааны талбар юм. AI-ийн эцсийн зорилго бол суралцах, төлөвлөх, асуудлыг бие даан шийдвэрлэх чадвартай компьютер бүтээх явдал юм. AI-ийг хагас зуун жилийн турш судалж үзсэн ч бид бүх талаараа хүн шиг ухаалаг компьютер хийж чадахгүй байна. Гэсэн хэдий ч бидэнд олон амжилттай программууд байдаг. Зарим тохиолдолд AI технологиор тоноглогдсон компьютер нь биднээс ч илүү ухаалаг байж чаддаг. Дэлхийн шатрын аварга шалгаруулах тэмцээнд ялагдсан Deep Blue систем нь сайн жишээ юм. AI-ийн судалгааны үндсэн сэдвүүдэд: асуудлыг шийдвэрлэх, үндэслэл, төлөвлөлт, эх хэл ойлголт, компьютерын алсын хараа, автомат программчлал, машин сурах гэх мэт. Мэдээжийн хэрэг, эдгээр сэдвүүд нь хоорондоо нягт холбоотой байдаг. Жишээлбэл, суралцах замаар олж авсан мэдлэгийг асуудлыг шийдвэрлэх, үндэслэл болгон ашиглах боломжтой. Чухамдаа асуудлыг шийдэх ур чадварыг суралцах замаар олж авах ёстой. Түүнчлэн асуудлыг шийдэх аргууд нь үндэслэл, төлөвлөлтийн аль алинд нь ашигтай байдаг. Цаашилбал, эх хэл ойлголт, компьютерын алсын харааг хоёуланг нь таних чиглэлээр боловсруулсан аргуудыг ашиглан шийдэж болно. Энэ сургалтад бид AI-г ойлгох үндсэн суурь мэдлэгийг судлах болно. Асуудлыг шийдвэрлэх үндсэн хайлтын алгоритмуудыг танилцуулах болно; мэдлэгийн төлөөлөл ба үндэслэл; хэв маягийг таних; үл ойлгогдох логик; болон мэдрэлийн сүлжээ. Машин сургалтыг ашигласнаар машин буюу компьютер хүний зан төлөвийг дуурайж, дасан зохицох чадвартай болгох, Машин сургалтын алгоритмууд урьдчилан тодорхойлогдсон томьёо, загваргүйгээр, зөвхөн тооцоолох аргад суурилан, өгөгдлөөс шууд “суралцаж” мэдээллийг олж авах. Машин сургалтын ямар ч алгоритм өгөгдөл доторх хэв шинж, холбоо хамаарлыг тогтоож, одоогоор мэдэгдэхгүй байгаа төлөвийг урьдчилан таамаглах чадвар зэргийг судална

D.CS310-Программ хангамжийн шаардлага ба шинжилгээ**Кредит: 3****Долоо хоногт орох лекц, семинар, лаборатори, бие даалтын цаг: 2:0:2****Хичээлийн тодорхойлолт:**

Нэгдмэл процессын тухай ерөнхий ойлголтыг оюутнуудад өгч “Загварчлалын нэгдсэн хэл” ашиглан объект хандлагат системийн шинжилгээ ба зохиомжийн загвар гаргах арга барил олгоно. Хичээлээр шаардлагын шинжилгээ, юзкейс загвар, классын шинжилгээ, юзкейс нэвтрүүлэлт, пакетын шинжилгээ зэрэг агуулгыг үзнэ.

D.CS315-Программ хангамжийн чанар ба тестлэл**Кредит: 3**

Долоо хоногт орох лекц, семинар, лаборатори, бие даалтын цаг: 2:0:2

Хичээлийн тодорхойлолт:

ПХ-н чанарын талаар гүн мэдлэгтэй болж түүнийг хэрхэн, үнэлэх, баталгаажуулах, чанарын сайжруулах арга, программ хангамжийн хяналт шалгалт, үнэлгээг хийх мөн чанарын стандарт, процессын болон нэгдсэн тест хийх арга техниктэй танилцах. Чанарын үнэлгээ ба тайлагналын талаар судална.

D.CS308-Мобайл төхөөрөмжийн программчлал

Кредит: 3

Долоо хоногт орох лекц, семинар, лаборатори, бие даалтын цаг: 2:0:2

Хичээлийн тодорхойлолт:

Энэ хичээлийг амжилттай үзэж дуусгаснаар оюутнууд хөдөлгөөнт төхөөрөмжид зориулж программ бичих боломжтой болох ба түүний томоохон төлөөлөл болох Андроид болон iOS үйлдлийн систем дээр гүйцэтгэх чадвартай болно. Уг хичээлээр Андроид болон iOS үйлдлийн систем, системийн боломжууд болон техник хангамжуудтай ажиллах, сенсорууд гэх мэт мэдлэгийг олж авна. Мөн орчин үеийн мобайл системүүдийн шийдэл болон архитектурын талаар тайлбарлах чадвартай болно.

D.CS321-ЮНИКС дизайн

Кредит: 3

Долоо хоногт орох лекц, семинар, лаборатори, бие даалтын цаг: 2:0:2

Хичээлийн тодорхойлолт:

Уг хичээлээр компьютерын үйлдлийн системийн нөөц болон суурь функцүүдийг хэрхэн зохицуулалт хийх талаар мэдэх болно. Компьютер дээр бид үйлдлийн системийн программчлалыг ашиглан хавтас үүсгэх, файл үүсгэх, процесс удирдах, төхөөрөмжүүдийг удирдах ба зэрэг процесс үүсгэх зэргийг хийнэ. Эдгээр үйлдлийг бид системийн программчлал ашиглан энэ хичээлээр судлах болно.

D.CS300-Үйлдвэрлэлийн дадлага

Кредит: 3

Долоо хоногт орох лекц, семинар, лаборатори, бие даалтын цаг: 2:0:2

Хичээлийн тодорхойлолт:

Хичээлээр оюутан хиймэл оюуны арга, аргачлал, алгоритм, технологиудыг судалж, нэгийг сонгон авч, сайн хэрэглэж сурна. Оюутан мэргэжлийн компани, байгууллагад дадлага хийх бөгөөд шинээр хийж байгаа системийн багт орж ажиллана.

D.CS304-Объект хандлагат программчлал

Кредит: 3

Долоо хоногт орох лекц, семинар, лаборатори, бие даалтын цаг: 2:2:0

Хичээлийн тодорхойлолт:

Хичээлээр Жава хэл ашиглан программчлалын үндсэн арга техникүүдийн хэрэглээ, объект хандлагат программчлалын үндсэн зарчим, битүүмжлэл, класс, объект, бүрдмэл болон бүтэцлэг харьцаа, удамшил, полиморфизм, классын зохиомжийг судлах болно.

D.CS205-Өгөгдлийн бүтэц

Кредит: 3

Долоо хоногт орох лекц, семинар, лаборатори, бие даалтын цаг: 2:0:2

Хичээлийн тодорхойлолт:

Энэ хичээлээр шугаман жагсаалт, дараалал, мод, массив, хэш хүснэгт, граф зэрэг сонгодог өгөгдлийн үндсэн бүтцүүдийг объектоор дүрсэлж, массив болон динамик санах ойн удирдлагын зохион байгуулалтаар программчлалын Java хэл дээр хэрхэн хэрэгжүүлэх, хэрэглэх асуудлыг үзэх болно.

D.CS307-Визуал программчлал

Кредит: 3

Долоо хоногт орох лекц, семинар, лаборатори, бие даалтын цаг: 2:0:2

Хичээлийн тодорхойлолт:

Энэ хичээлээр Microsoft.NET технологи болоод C# программчлалын хэлний дүрэм, үндэс, классын зохиомж, объектоор ажиллах, тексттэй ажиллах, файлын I/O, Цонхтой программ бичих, winForm контролуудыг судлах, GDI графиктай ажиллах, ӨС-тай ажиллах ADO.NET технологийг ашиглах, Асинхрон программчлал, трэд программчлалын талаар зааж тайлбарлана.

D.CS302-Өгөгдлийн сангийн програмчлал	Кредит: 3
Долоо хоногт орох лекц, семинар, лаборатори, бие даалтын цаг: 2:0:2	
Хичээлийн тодорхойлолт: Өгөгдлийн санг загварчлах, зохиомжлох, өгөгдлийн сантай ажиллах логик суурь мэдлэг; объектын холбоосны шинжилгээ; өгөгдлийг энгийн хэлбэрт шилжүүлэх; өгөгдлийн сан үүсгэх; өгөгдлийн сангийн боловсруулалт хийх, SQL хэлний стандарт болон нэмэлт функцүүд ашиглан query бичих, унших; SQL болон NoSQL дээрх өгөгдөлд суурилсан тооцоолол, тайлан боловсруулах, шинжилгээ хийх, нууцлал хамгаалалтын суурь мэдлэг, чадварыг эзэмшинэ.	
D.CS301-Үйлдлийн систем	Кредит: 3
Долоо хоногт орох лекц, семинар, лаборатори, бие даалтын цаг: 2:0:2	
Хичээлийн тодорхойлолт: Үйлдлийн систем нь компьютер дээр ажиллаж байгаа программуудыг техник хангамжтай хамт ажиллах боломж олгодог үндсэн программ хангамж юм.	
D.CS317-Компьютерын загварчлал, симуляц	Кредит: 3
Долоо хоногт орох лекц, семинар, лаборатори, бие даалтын цаг: 2:2:0	
Хичээлийн тодорхойлолт: Инженерчлэл, туршилтын үр дүнг компьютерт загварчлан тоон болон шинж чанарын шинжилгээ хийх математик арга, компьютер загварчлал, симуляцийн системүүдтэй танилцах, тодорхой тохиолдол сонгон хэрэглэх дадлага хийнэ. Загвар хөгжүүлэх зарчим, Монте Карлогийн симуляц, симуляц судлалын амьдралын тойрог, өгөгдөл оролт ба гаралтын шинжилгээ, цагийн хяналт, санамсаргүй тоо үүсгэх, симуляцийн дүнг үнэлэх, симуляцийн хэл, ерөнхий зориулалтын симуляцийн системийн хэрэглээ зэрэг сэдвүүд судална.	
D.CS202- Алгоритм ба програмчлалын үндэс	Кредит: 3
Долоо хоногт орох лекц, семинар, лаборатори, бие даалтын цаг: 2:2:0	
Хичээлийн тодорхойлолт: Мэдээллийн үндсэн онол, өгөгдлийн дүрслэл, бит дээрх үйлдлүүд, Flowgorithm программд алгоритм зохиох, Python хэл дээр хэрэглэгчийн функц зохиох, жагсаалт, тюпл, толь бичиг төрлүүдийг ашиглах; файл, модуль, класстай ажиллах; Numpy, Pandas сангууд ашиглан өгөгдлийн шинжилгээ хийх онолын суурь мэдлэг, чадвар эзэмшинэ.	
D.CS208-Интернет технологийн үндэс	Кредит: 3
Долоо хоногт орох лекц, семинар, лаборатори, бие даалтын цаг: 2:2:0	
Хичээлийн тодорхойлолт: Энэ хичээлээр интернетийн архитектур, МСТСР/IP протоколын давхарга, IP хаяглалт, домэйн нэрийн систем /DNS/, имайл болон вебийн үндсэн протоколууд /SMTP, HTTP, HTTPS/, клиент сервер загвар, веб серверийн ажиллах зарчим, интернетийн аюулгүй байдлын суурь ойлголтуудыг судална. Веб технологийн үндэс, энгийн веб хуудас зохиох, серверийн тохиргоо хийх дадлага эзэмшинэ.	
D.CS203-Электроникийн үндэс	Кредит: 3
Долоо хоногт орох лекц, семинар, лаборатори, бие даалтын цаг: 2:2:0	
Хичээлийн тодорхойлолт: Электроникийн шинжлэх ухааны үндсэн суурь ойлголт, аналог ба тоон дохионы онцлог, хагас дамжуулагч диод, транзисторын бүтэц, ажиллах зарчим, хэрэглээ, логик үйлдлүүд, булийн алгебр, энгийн тоон хэлхээ бүтээх, триггер, тоолуур% регистрийн ажиллагаа, хэрэглээний тухай ойлголтыг авна.	
D.EL205-Мэргэжлийн англи хэл	Кредит: 3
Долоо хоногт орох лекц, семинар, лаборатори, бие даалтын цаг: 2:2:0	
Хичээлийн тодорхойлолт:	

Тусгай зориулалтын мэргэжлийн англи хэлийг унших, бичих, сонсох, ярих чадварыг хөгжүүлэх аргаар зааж, салбарын үг хэллэгийг ойлгох, үгийн утга шилжилт болон англи хэлний онолын мэдлэг эзэмшин, орчуулга хийх чадварыг эзэмшүүлнэ.

D.CS316-Сүлжээний програмчлал	Кредит: 3
Долоо хоногт орох лекц, семинар, лаборатори, бие даалтын цаг: 2:2:0	

Хичээлийн тодорхойлолт:

Жава хэл ашиглан програмчлалын үндсэн арга техникүүдийн хэрэглээ, объект хандалтат програмчлалын үндсэн зарчим, битүүмжлэл, класс, объект, бүрдмэл болон бүтэцлэг харьцаа, удамшил, полиморфизм, классын зохиомжийг судлана.

D.CS313-Зүйлсийн интернет /IoT/ технологи ба хөгжүүлэлт	Кредит: 3
--	------------------

Долоо хоногт орох лекц, семинар, лаборатори, бие даалтын цаг: 2:2:0

Хичээлийн тодорхойлолт:

IoT системийн ажилах зарчим, архитектур, холболтын технологийг ойлгуулж, микроконтроллер, мэдрүүр, үүлэн орчныг ашиглан бодит төхөөрөмжийн өгөгдлийг хянах, удирдах зарчмыг ойгуулна.

D.CS312-Кибер аюулгүй байдал	Кредит: 3
Долоо хоногт орох лекц, семинар, лаборатори, бие даалтын цаг: 2:2:0	

Хичээлийн тодорхойлолт:

Энэ хичээл нь мэдээллийн систем, сүлжээний аюулгүй байдал, халдлагын төрөл, хамгаалалтын үндсэн аргуудыг CISCO -ийн курсуудын агуулгад тулгуурлан заана.

D.WH200-Дэлхийн түүх	Кредит: 3
Долоо хоногт орох лекц, семинар, лаборатори, бие даалтын цаг: 2:2:0	

Хичээлийн тодорхойлолт:

Дэлхийн түүхийн хичээл нь хүн төрөлхтний нийгэм, улс орон, соёл, үйл явдлуудын түүхэн хөгжлийг судалдаг хичээл юм. Энэ хичээлээр оюутнууд дэлхийн эдийн засаг, улс төр, соёлын өөрчлөлтүүдийг ойлгож, ирээдүйн орчин үеийн дэлхийн олон талын харилцааг илүү гүнзгий ойлгоход туслах зорилготой

D.IS203-Олон улс судлалын удиртгал	Кредит: 2
Долоо хоногт орох лекц, семинар, лаборатори, бие даалтын цаг: 1:2:0	

Хичээлийн тодорхойлолт:

Дэлхийн улсын харилцаа, гадаад бодлого, олон улсын байгууллага, аюулгүй байдал, эдийн засгийн хамтын ажиллагаа зэрэг сэдвүүдийг судалдаг салбар юм. Энэ удиртгал хичээл нь оюутнуудад олон улсын харилцааны үндсэн ойлголт, онол, түүх, өнөөгийн чиг хандлагаг ойлгомжтой болгоход чиглэдэг.

D.PS204-Улс төр судлал	Кредит: 3
Долоо хоногт орох лекц, семинар, лаборатори, бие даалтын цаг: 2:2:0	

Хичээлийн тодорхойлолт:

Оюутанд улс төрийн үзэл санаа, тогтолцоо, институци, үйл явцын тухай суурь ойлголт, мэдлэг олгох, улмаар улс төрийн үйл явцад оролцох, бодитой дүгнэлт хийх чадвар төлөвшүүлэхэд оршино.

D.FA205-Соёл судлалын үндэс	Кредит: 3
Долоо хоногт орох лекц, семинар, лаборатори, бие даалтын цаг: 2:2:0	

Хичээлийн тодорхойлолт:

Суралцагчдад соёлын тухай онол, үзэл баримтлал, нийгмийн хөгжлийн дэх соёлын үүрэг, олон соёлт ертөнцөд хүний харилцаа, үнэт зүйл, зан заншлын онцлогийг шинжлэх ухааны үүднээс судлах мэдлэг, ойлголт, дүн шинжилгээний чадвар эзэмшүүлэхэд оршино.

D.LA206-Уран зохиол шинжлэлийн удиртгал	Кредит: 3
--	------------------

Долоо хоногт орох лекц, семинар, лаборатори, бие даалтын цаг: 2:2:0	
Хичээлийн тодорхойлолт:	
Суралцагчдад уран зохиол судлалын шинжлэх ухааны үүсэл, хөгжлийн чиг хандлага, үндсэн ойлголт, арга зүйг танилцуулж, уран зохиолын бүтээлийг уран сайхны талаас нь задлан шинжилж, дүгнэлт хийх чадвар төлөвшүүлэхэд оршино.	
D.IS204-Орон судлалын арга зүй	Кредит: 3
Долоо хоногт орох лекц, семинар, лаборатори, бие даалтын цаг: 2:2:0	
Хичээлийн тодорхойлолт:	
Суралцагчдад орон судлалын шинжлэх ухааны онол, үзэл баримтлал, судалгааны арга зүйг эзэмшүүлж, тодорхой улс орон, бүс нутгийн улс төр, эдийн засаг, соёл, нийгмийн үзэгдлийг судалгаа, шинжилгээний аргаар тайлбарлах чадварыг төлөвшүүлэхэд оршино.	
D.CML207- Сонгодог монгол бичгийн хэл	Кредит: 3
Долоо хоногт орох лекц, семинар, лаборатори, бие даалтын цаг: 2:2:0	
Хичээлийн тодорхойлолт:	
Суралцагчдад сонгодог монгол бичгийн хэлний бүтэц, онцлог, дүрмийн зүй тогтол, хэрэглээний хүрээ, хөгжлийн түүхийн талаар онолын болон практик мэдлэг олгох, сонгодог монгол бичгийн эх уншиж ойлгох, орчуулга хийх, бичгийн соёлыг эзэмшүүлэхэд оршино.	
D.LAML202-Хэл эзэмших арга зүй	Кредит: 3
Долоо хоногт орох лекц, семинар, лаборатори, бие даалтын цаг: 2:2:0	
Хичээлийн тодорхойлолт:	
Сурагчдын хэл яриа, унших, бичих, сонсох чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн онолын болон практик арга зүйг эзэмшүүлэх, хэлний сургалтын үр нөлөөг дээшлүүлэх аргачлалд суралцуулахад оршино.	
D.LG208-Хэл шинжлэлийн үндэс	Кредит: 3
Долоо хоногт орох лекц, семинар, лаборатори, бие даалтын цаг: 2:2:0	
Хичээлийн тодорхойлолт:	
Суралцагчдад хэл шинжлэлийн шинжлэх ухааны үүсэл, хөгжлийн түүх, судлах зүйл, салбарууд болон хэлний бүтэц, зүй тогтол, нийгмийн үүргийн талаарх цогц ойлголт олгох, хэлний үзэгдлийг шинжлэх ухааны үүднээс тайлбарлах чадвар төлөвшүүлэхэд оршино.	
D.JH301-Японы түүх	Кредит: 3
Долоо хоногт орох лекц, семинар, лаборатори, бие даалтын цаг: 2:2:0	
Хичээлийн тодорхойлолт:	
Суралцагчдад Япон улсын түүхэн хөгжлийн үе шат, улс төр, эдийн засаг, соёл, нийгмийн өөрчлөлт, дэлхий дахинд эзлэх байр суурийг судлуулж, түүхэн баримт, үйл явдлыг шинжлэх ухааны үндэстэйгээр тайлбарлах, дүгнэлт хийх чадварыг төлөвшүүлэхэд оршино.	
DJEG302-Японы эдийн засгийн газар зүй	Кредит: 3
Долоо хоногт орох лекц, семинар, лаборатори, бие даалтын цаг: 2:2:0	
Хичээлийн тодорхойлолт:	
Суралцагчдад Япон улсын байгаль, хүн ам, нийгэм, эдийн засгийн газар зүйн онцлог, бүс нутгийн хөгжил, үйлдвэрлэл, аж үйлдвэр, үйлчилгээний салбаруудын уялдаа холбоог судлуулж, орчин үеийн Японы эдийн засгийн бүтэц, хөгжлийн чиг хандлагыг газар зүйн үүднээс тайлбарлах чадварыг төлөвшүүлэхэд оршино.	
D.JSC303-Японы нийгэм, соёл	Кредит: 3
Долоо хоногт орох лекц, семинар, лаборатори, бие даалтын цаг: 2:2:0	
Хичээлийн тодорхойлолт:	
уралцагчдад Япон улсын нийгмийн бүтэц, үнэт зүйлс, уламжлал, соёлын хөгжил, орчин үеийн нийгмийн өөрчлөлтийн онцлогийг судлуулж, Японы соёл иргэншлийн онцлогийг танин мэдэх, соёл хоорондын харилцаанд ойлголцол, хүндлэлийг төлөвшүүлэхэд оршино.	

D.JPR304-Японы улс төр, гадаад харилцаа	Кредит: 3
Долоо хоногт орох лекц, семинар, лаборатори, бие даалтын цаг: 2:2:0	
Хичээлийн тодорхойлолт:	
Суралцагчдад Япон улсын улс төрийн тогтолцоо, төрийн байгууллын бүтэц, улс төрийн соёл, бодлогын онцлог болон гадаад харилцааны хөгжлийн чиг хандлагыг судлуулж, Зүүн Азийн болон дэлхийн улс төр, олон улсын харилцаанд Японы гүйцэтгэж буй үүргийг шинжлэх ухааны үүднээс тайлбарлах чадварыг төлөвшүүлэхэд оршино.	
D.JL305-Япон уран зохиол ба урлаг	Кредит: 3
Долоо хоногт орох лекц, семинар, лаборатори, бие даалтын цаг: 2:2:0	
Хичээлийн тодорхойлолт:	
Энэхүү хичээл нь Япон улсын уран зохиол, урлагийн үүсэл хөгжил, чиг хандлага, гол төлөөлөгчид болон бүтээлүүдийг судлуулж, уран сайхны сэтгэлгээ, гоо зүйн үнэлэмж, соёлын онцлогийг шинжлэх ухааны үүднээс ойлгох, дүгнэлт хийх чадварыг төлөвшүүлэхэд оршино.	
D.JL306-Японы хууль	Кредит: 3
Долоо хоногт орох лекц, семинар, лаборатори, бие даалтын цаг: 2:2:0	
Хичээлийн тодорхойлолт:	
Энэхүү хичээл нь суралцагчдад Япон улсын эрх зүйн тогтолцоо, хууль зүйн хөгжлийн түүхэн замнал, Үндсэн хууль болон гол хуулиудын агуулга, хэрэгжилтийн онцлог, шүүх эрх мэдэл ба засаглалын бүтэц, хууль ёс, нийгмийн харилцааны уялдаа зэргийг судлуулж, Японы хууль тогтолцоог Монгол болон бусад орны эрх зүйн тогтолцоотой харьцуулан ойлгох чадварыг төлөвшүүлэхэд оршино.	
D.JSC304-Харьцуулсан соёл судлал	Кредит: 3
Долоо хоногт орох лекц, семинар, лаборатори, бие даалтын цаг: 2:2:0	
Хичээлийн тодорхойлолт:	
D.JSC305-Монгол японы харилцаа	Кредит: 3
Долоо хоногт орох лекц, семинар, лаборатори, бие даалтын цаг: 2:2:0	
Хичээлийн тодорхойлолт:	
Энэ хичээлээр суралцагчдад Монгол Улс ба Япон Улсын улс төр, эдийн засаг, соёл, боловсрол, гадаад харилцааны түүхэн хөгжлийг судлуулж, хоёр улсын хамтын ажиллагааны өнөөгийн чиг хандлага, олон улсын тавцанд гүйцэтгэж буй үүргийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр ойлгуулах, харьцуулан судлах чадварыг төлөвшүүлэхэд оршино.	
D.JEG303-Олон улсын эдийн засаг	Кредит: 3
Долоо хоногт орох лекц, семинар, лаборатори, бие даалтын цаг: 2:2:0	
Хичээлийн тодорхойлолт:	
Энэ хичээлээр суралцагчдад олон улсын эдийн засгийн үндсэн онол, үзэл баримтлал, дэлхийн худалдаа, санхүү, хөрөнгө оруулалт, хөдөлмөрийн урсгал болон эдийн засгийн интеграцийн үйл явцыг судлуулж, улс орнуудын эдийн засгийн харилцан хамаарлыг ойлгох, дүн шинжилгээ хийх чадварыг төлөвшүүлэхэд оршино.	

МАГИСТРЫН ХӨТӨЛБӨРИЙН ХИЧЭЭЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

НЭГ.МЭРГЭЖЛИЙН МАГИСТР

1. Мэргэжлийн суурь

Заавал суралцах хичээл

Судалгааны арга зүй

Бодит байдлыг танин мэдэх судалгааны ерөнхий арга зүйн түүх,үндсэн ойлголт, судалгааны зарчим, онцлог, судалгааны аргын ангилал,тоон ба чанарын судалгааны талаар онолын мэдлэг,түүнд тулгуурлан хэлшинжлэлийн судалгааны аргын онцлогийн талаар мэдлэг ,судалгаа шинжилгээний практик ур чадвар олгоно.

Оюуны өмчийн эрх зүй,судлаачийн ёс зүй

Хүний оюуны ухаанаар бий болсон биет бус зохиогчийн өмч болох оюуны өмч,түүнтэй холбогдох патент, зохиогчийн эрх, барааны тэмдэг болон газар зүйн заалт гэх мэт ойлголтууд,түүнд холбогдох эрх зүйн талаар үндсэн мэдлэгтэй болох.Түүнтэй уялдаатайгаар судалгааны ёс зүйг баримтлах олон улсын болон Монголд улсад мөрдөж буй баримт бичиг,судалгааны ёсзүйн үндсэн зарчим, нийтлэг асуудал, судалгааны аргачлал боловсруулахад анхаарах ёсзүйн асуудлууд,эрдэм шинжилгээний ажлын үнэ цэнэ, ёс зүйн шаардлагуудыг мэдэх

Орчин үеийн хэлшинжлэлийн хандлага

Хэлний хөгжлийн зүй тогтол ба хэлшинжлэлийн судалгааны өөрчлөлт,орчин үеийн хэлшинжлэлийн онолуудын мөн чанар,ач холбогдол,судалгааны арга зүйн хөгжилийн талаар үндсэн ойлголтыг эзэмшүүлж,хэлэнд хандах хандлагыг шинэчилнэ.

Орчин үеийн уран зохиолын чиг хандлага

“Орчин үеийн уран зохиол судлалын чиг хандлага” хичээлээр утга зохиолын онолын шинэ чиг хандлагууд, онол арга зүйн дэг, маяг, урсалуудын тухай, утга зохиол судлалын шинэ, шинэлэг арга зүйн онолын үндэслэл, уран зохиолын олон талын холбоос, уран зохиол ба нийгэм, уран зохиол ба гүн ухаан, уран зохиол ба соёлын харилцаа холбооны талаар гүн мэдлэг, судалгаа хийх ур чадвар эзэмшинэ.

Сонгон суралцах хичээл

Прагматик хэлшинжлэл

Прагматик буюу хэрэглээ хэлшинжлэлийн орчин үеийн үзэл баримтлал,үндсэн ойлголтууд,гол төлөөлөгчид болон судалгааны чиг хандлагатай танилцуулж,хэлийг авч үзэх онол,практикийн байр суурийг зөв тодорхойлох мэдлэг чадвар олгоно.

Танихуйн хэлшинжлэл

Когнитив хэл шинжлэлийн уламжлалт болон орчин үеийн онолын үзэл баримтлалууд, хэл-сэтгэхүй-танихуй гэсэн гурвалсан холбоонд тархины хэлийг судалдаг шинэ парадигмын үндсэн ойлголтууд,судлагдахуун судалгааны аргуудын талаар мэдлэг эзэмшинэ.

Үүсгүүр хэлшинжлэл

Н.Чомскийн үүсгүүр хэл шинжлэлийн онолын мөн чанар, хэлний систем тогтолцооны нийтлэг тал,хэлний өнгөн ба гүн бүтэц,хэл ба философийн уялдаа холбооны талаарх онол арга зүйн суурь мэдлэг эзэмшинэ.

Хэлэхүйн онол

Прагматикийн онолын хүрээнд хэлэхүйн онолын үндсэн агуулгатай танилцана. Хэл,хэлэхийн ялгаа,хэлэхүйн үйлдлийн онолын үүднээс хэлний үзэгдэл,түүний утгыг өгүүлэгч,түүний нийгмийн шинж,,хам сэдэв ,хэрэглээний хүчин зүйлтэй холбон авч үзэх ,задлан шинжлэх арга зүй эзэмшинэ.

Уран зохиолын урсгал чиглэлийн судалгаа

“Уран зохиолын урсгал чиглэлийн судалгаа” хичээлээр утга зохиолын онолын шинэ чиг хандлагууд, онол арга зүйн дэг, маяг, урсалуудын тухай, түүний гүн ухааны үндэслэл, ны талаар гүн мэдлэг, судалгаа хийх ур чадвар эзэмшинэ.

Аман зохиол судлалын түүх

“Аман зохиол судлалын түүх” хичээлээр аман зохиолын мөн чанар, аман зохиол судлалын онол арга зүй, судалгааны дэг маягууд, аман ба бичгийн зохиолын харьцаа, харьцуулсан аман зохиолын талаар гүн мэдлэг, аман зохиолын төрөл зүйлүүдэд судалгаа хийх ур чадвар эзэмшинэ.

Япон хэл заах аргын дэлхийн чиг хандлага

Япон хэл заах аргын түүх, уламжлалыг авч үзэхийн хамт япон хэлний эрэлтийн хувьсал өөрчлөлтийг судалж, даяаршлын эрин зуун дахь боловсролын зах зээл дээрх япон хэл заах аргын өөрчлөлт шинэчлэлийг авч үзнэ.

Монгол хүнд зориулсан ханз заах аргын онцлог

Ханзны үүсэл, хөгжил, ханз үсэг зааж ирсэн уламжлалтай уялдаатайгаар монгол суралцагсдад ханз үсэг эзэмшүүлж буй өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийхийн хамт, суралцагчийн онцлогтой уялдаатайгаар ханз үсэг заах дэвшилтэт арга зүйтэй танилцана

Монгол дахь Япон хэл заах аргын судалгааны тойм

Монгол улсад япон хэл зааж ирсэн түүхийг судлан, япон хэл заах аргын сэдвээр хийгдсэн магистр, докторын судалгааны ажлуудтай танилцаж, дүн шинжилгээ хийн.

Монгол япон соёлын онцлог заах аргад нөлөөлөх нь

Монгол, япон хэл-соёлын уялдаа холбоон дээр үндэслэн, соёлын ялгаа бүхий япон хэлний үзэгдлүүдийг заах аргад хэрхэн харгалзан үзэх тухай судлаачдын бүтээлтэй танилцсаны үндсэн дээр арга зүйн зөвлөмж боловсруулах

2. Мэргэшлэх хичээл

Заавал суралцах хичээл

Харьцуулсан ба зэрэгцүүлсэн хэлшинжлэл

Харьцуулсан ба зэрэгцүүлсэн хэл зүй хичээлээр харьцуулсан ба зэрэгцүүлсэн хэл шинжлэл гадаад ба монгол хэлний хэл зүйн бүтэц, зохион байгуулалын онцлог тал, хэл зүйн бүрэлдүүлбэрүүдийн үйлдэл, зүй тогтлын ялгааг үг зүй, өгүүлбэр зүй, эхийн түвшинд харьцуулан судлаж, ижил төстэй болон ялгаатай талуудыг тодорхойлох хэл шинжлэлийн судалгааны үндсэн арга зүйг эзэмшүүлнэ.

Харьцуулсан ба зэрэгцүүлсэн уран зохиол

Дэлхийн утга зохиолын хөгжлийн ерөнхий зүй тогтлыг судалж, нэг улсын, нэг үеийн, эсвэл өөр өөр соёлын зохиолчдын бүтээлийг харьцуулан шинжлэх замаар уран зохиолын үзэгдэл, чиг хандлага, сэдэв, дүр, хэв маяг, урсгал, сэтгэлгээний уялдаа холбоо, нөлөөллийг илрүүлэхэд чиглэсэн шинжлэх ухаан арга зүйг эзэмшүүлнэ.

Гадаад хэл заах аргын орчин үеийн асуудлууд

Гадаад хэл заах аргын уламжлалт болон орчин үеийн онол арга зүйн хүрээнд орчин үеийн гадаад хэл заах аргын шинэ дидактик, хандлага, тулгамдсан асуудлуудын талаар мэдлэг олгоно.

Орчин үеийн орчуулга судлал

Орчуулга судлалын орчин үеийн онол, практикийн үндсэн асуудлууд, түүний шийдвэрлэх арга зам, орчуулгын заах аргын шинэчлэл, эрдэмтдийн үзэл баримтлалын талаар мэдлэг олгоно.

Орчуулгын тусгай онол

Монгол болон гадаад хэлний орчуулгын тусгай онолын зайлшгүй эрэлт, түүний гол ойлголт, үндсэн агуулга, онолын бүрэлдэхүүн хэсгүүдийн боловсруулалт, орчуулгын тусгай онол ба гадаад хэл заах арга, орчуулгын хичээлийн холбоо хамаарлын талаар мэдлэг олгоно.

Аман зохиол судлал

“Аман зохиол судлал” хичээлээр аман зохиолыг судлах онол, арга зүй, аман зохиолд аман зохиолын үүднээс хандах хандлага буюу тоглолтын онол, хэвшлийн онолын үүднээс аман зохиолыг судлах онцлог, зан үйл ба аман зохиол, тоглоом наадам ба аман зохиол, жүжиг наадам ба аман зохиолын харьцаа холбооны талаар гүн мэдлэг, аман зохиолын төрөл зүйлүүдэд судалгаа хийх ур чадвар эзэмшинэ.

Эрт ба эдүгээ үеийн уран зохиол судлал

“Эрт ба эдүгээ үеийн уран зохиол судлал” хичээлээр Монголын эртний уран зохиолыг судалж ирсэн онцлог түвшин, Монгол эртний уран зохиолыг судлах онол, арга зүйн үндэслэлүүд, эртний бичгийн зохиолын нийлэг чанарын тухай, орчин үеийн уран зохиолын хөгжил дэвшлийн асуудлууд, эрт ба эдүгээ үеийн уран зохиолын гол гол төлөөлөгч судлаачдын судалгааны тухай гүн мэдлэг, ур чадвар эзэмшинэ.

Сонгон суралцах хичээл

Үгийн сан,утга судлал

Үгийн сан,утга судлалын үндсэн ойлголт категори, судалгааны арга,агуулгын бүрэлдэхүүн хэсгүүд,үгийн сан-утга судлалын хамаарлын талаар мэдлэг эзэмшинэ.

Хэлний соёл судлал

Хэлний соёл судлалын онол арга зүйн гол судлагдахуун,,хэлний соёл судлалын үндсэн ойлголтуудын талаар мэдлэг эзэмшинэ.

Орчуулгын хэлний асуудал

Хэлний ялгарах шинж, хэлзүйн аспектиуд , үгсийн сан, утга зүй,найруулга зүйн хэм хэмжээ,хэлний соёл судлалын орчуулгад үзүүлэх нөлөөний талаарх асуудлаар орчуулга судлал -хэлшинжлэлийн зааг дээр мэдлэг олгоно.

Монгол хүнд гадаад хэл заах аргын асуудлууд

Монгол хүний танин мэдэхүй,ой тогтоолт, сэтгэлгээний болон соёлын онцлогт тохируулан гадаад хэл заах аргыг төлөвлөх онол ,арга зүйн прагматик мэдлэг эзэмшинэ.

Яруу найраг судлал

“Яруу найраг [шүлэг] судлал ” хичээлээр Монгол шүлгийн тогтолцоо хэв маяг, Монголын эртний яруу найраг, түүний уламжлал, Монголын орчин үеийн шүлэг яруу найргийн шүлэглэх ёс, уламжлал шинэчлэлийн асуудлууд, монгол шүлгийн тогтолцоог судалж, үзэл баримтлалаа дэвшүүлсэн эрдэмтдийн судалгаа, онол, арга зүйн үндэслэлүүд, дэлхийн шүлгийн тогтолцоо хэв маягийн талаар гүн мэдлэг, шүлэг яруу найргийн бүтээлийг задлах, шинжлэх ур чадвар, арга зүй эзэмшинэ.

Гадаадын уран зохиол судлал

“Гадаадын уран зохиол судлал ” хичээлээр Монгол хэлээр орчуулагдсан гадаадын сонгодог уран зохиолын түүхэн тойм, хөгжил дэвшил, дэлхийн сонгодог уран зохиол ба монголын уран зохиолын харьцаа, харилцан нөлөөллийн асуудлууд, Монгол орчуулгын зохиолын онол арга зүй, уламжлал шинэчлэлийн асуудлууд, гадаадын уран зохиолыг судалсан монгол эрдэмтэн судлаачдын үзэл баримтлалын талаар гүн мэдлэг, танин мэдэхүйтэй болох ба дэлхийн уран зохиолын монголын уран зохиол дахь нөлөө тусгалыг танин мэдэх, задлан шинжлэх ур чадвар, арга зүйтэй болно.

Монгол оюутныг JLPT-д бэлтгэх арга зүй

Япон хэлний ТТШ-д бэлтгэх сургалтын арга зүй,олон улсын туршлагатай танилцсаны үндсэн дээр,сүүлийн жилүүдийн монгол суралцагсдын япон хэлний ТТШ-ын дүнд анализ хийж,бэлтгэх арга зүйг боловсронгуй болгох зөвлөмж бэлтгэнэ.

Япон хэлний хэлзүй заах аргын онцлог

Япон ,монгол хэлний хэлзүйн нийтлэг ба ялгаатай талыг харьцуулан судалсан судалгааны бүтээлүүдтэй танилцаж,хэлзүй заах аргын тулгамдсан асуудлуудтай холбон авч үзсэний үндсэн дээр зөвлөмж бэлтгэнэ.

Япон хэлээр уран илтгэх чадварт сургах онцлог

日本語スピーチ・ япон хэлээр уран илтгэхүйн онцлогтой танилцуулан,уран илтгэх чадварыг дээшлүүлэх сургалт,заах арга зүйн онцлогийг бусад хэлнийхтэй харьцуулан судалж,монгол суралцагсдын уран илтгэхүйн чадварыг дээшлүүлэх боломжийг судална.

ХОЁР.СУДАЛГААНЫ МАГИСТР

1. Мэргэжлийн суурь **Заавал суралцах хичээл**

Судалгааны арга зүй

Бодит байдлыг танин мэдэх судалгааны ерөнхий арга зүйн түүх,үндсэн ойлголт, судалгааны зарчим, онцлог, судалгааны аргын ангилал,тоон ба чанарын судалгааны талаар онолын мэдлэг,түүнд тулгуурлан хэлшинжлэлийн судалгааны аргын онцлогийн талаар мэдлэг ,судалгаа шинжилгээний практик ур чадвар олгоно.

Оюуны өмчийн эрх зүй,судлаачийн ёс зүй

Хүний оюуны ухаанаар бий болсон биет бус зохиогчийн өмч болох оюуны өмч,түүнтэй холбогдох патент, зохиогчийн эрх, барааны тэмдэг болон газар зүйн заалт гэх мэт ойлголтууд,түүнд холбогдох эрх зүйн талаар үндсэн мэдлэгтэй болох.Түүнтэй уялдаатайгаар судалгааны ёс зүйг баримтлах олон улсын болон Монголд улсад мөрдөж буй баримт бичиг,судалгааны ёсзүйн үндсэн зарчим, нийтлэг асуудал, судалгааны аргачлал боловсруулахад анхаарах ёсзүйн асуудлууд,эрдэм шинжилгээний ажлын үнэ цэнэ, ёс зүйн шаардлагуудыг судална.

Орчин үеийн хэлшинжлэлийн хандлага

Хэлний хөгжлийн зүй тогтол ба хэлшинжлэлийн судалгааны өөрчлөлт,орчин үеийн хэлшинжлэлийн онолуудын мөн чанар,ач холбогдол,судалгааны арга зүйн хөгжилийн талаар үндсэн ойлголтыг эзэмшүүлж,хэлэнд хандах хандлагыг шинэжилнэ.

Орчин үеийн уран зохиолын чиг хандлага

“Орчин үеийн уран зохиол судлалын чиг хандлага” хичээлээр утга зохиолын онолын шинэ чиг хандлагууд, онол арга зүйн дэг, маяг, урсалуудын тухай, утга зохиол судлалын шинэ, шинэлэг арга зүйн онолын үндэслэл, уран зохиолын олон талын холбоос, уран зохиол ба нийгэм, уран зохиол ба гүн ухаан, уран зохиол ба соёлын харилцаа холбооны талаар гүн мэдлэг, судалгаа хийх ур чадвар эзэмшинэ.

Сонгон суралцах хичээл

Прагматик хэлшинжлэл

Прагматик буюу хэрэглээ хэлшинжлэлийн орчин үеийн үзэл баримтлал,үндсэн ойлголтууд,гол төлөөлөгчид болон судалгааны чиг хандлагатай танилцуулж,хэлийг авч үзэх онол,практикийн байр суурийг зөв тодорхойлох мэдлэг чадвар олгоно.

Танихуйн хэлшинжлэл

Когнитив хэл шинжлэлийн уламжлалт болон орчин үеийн онолын үзэл баримтлалууд, хэл-сэтгэхүй-танихуй гэсэн гурвалсан холбоонд тархины хэлийг судалдаг шинэ парадигмын үндсэн ойлголтууд,судлагдахуун судалгааны аргуудын талаар мэдлэг эзэмшинэ.

Үүсгүүр хэлшинжлэл

Н.Чомскийн үүсгүүр хэл шинжлэлийн онолын мөн чанар, хэлний систем тогтолцооны нийтлэг тал,хэлний өнгөн ба гүн бүтэц,хэл ба философийн уялдаа холбооны талаарх онол арга зүйн суурь мэдлэг эзэмшинэ.

Хэлэхүйн онол

Прагматикийн онолын хүрээнд хэлэхүйн онолын үндсэн агуулгатай танилцана. Хэл,хэлэхийн ялгаа,хэлэхүйн үйлдлийн онолын үүднээс хэлний үзэгдэл,түүний утгыг өгүүлэгч,түүний нийгмийн шинж,,хам сэдэв ,хэрэглээний хүчин зүйлтэй холбон авч үзэх ,задлан шинжлэх арга зүй эзэмшинэ.

Уран зохиолын урсгал чиглэлийн судалгаа

“Уран зохиолын урсгал чиглэлийн судалгаа” хичээлээр утга зохиолын онолын шинэ чиг хандлагууд, онол арга зүйн дэг, маяг, урсалуудын тухай, түүний гүн ухааны үндэслэл, ны талаар гүн мэдлэг, судалгаа хийх ур чадвар эзэмшинэ.

Аман зохиол судлалын түүх

“Аман зохиол судлалын түүх” хичээлээр аман зохиолын мөн чанар, аман зохиол судлалын онол арга зүй, судалгааны дэг маягууд, аман ба бичгийн зохиолын харьцаа, харьцуулсан аман зохиолын талаар гүн мэдлэг, аман зохиолын төрөл зүйлүүдэд судалгаа хийх ур чадвар эзэмшинэ.

Япон хэл заах аргын дэлхийн чиг хандлага

Япон хэл заах аргын түүх, уламжлалыг авч үзэхийн хамт япон хэлний эрэлтийн хувьсал өөрчлөлтийг судалж, даяаршлын эрин зуун дахь боловсролын зах зээл дээрх япон хэл заах аргын өөрчлөлт шинэчлэлийг авч үзнэ.

Монгол хүнд зориулсан ханз заах аргын онцлог

Ханзны үүсэл, хөгжил, ханз үсэг зааж ирсэн уламжлалтай уялдаатайгаар монгол суралцагсдад ханз үсэг эзэмшүүлж буй өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийхийн хамт, суралцагчийн онцлогтой уялдаатайгаар ханз үсэг заах дэвшилтэт арга зүйтэй танилцана.

Монгол дахь Япон хэл заах аргын судалгааны тойм

Монгол улсад япон хэл зааж ирсэн түүхийг судлан, япон хэл заах аргын сэдвээр хийгдсэн магистр, докторын судалгааны ажлуудтай танилцаж, дүн шинжилгээ хийнэ.

Монгол япон соёлын онцлог заах аргад нөлөөлөх нь

Монгол, япон хэл-соёлын уялдаа холбоон дээр үндэслэн, соёлын ялгаа бүхий япон хэлний үзэгдлүүдийг заах аргад хэрхэн харгалзан үзэх тухай судлаачдын бүтээлтэй танилцсаны үндсэн дээр арга зүйн зөвлөмж боловсруулах

2. Мэргэших хичээл

Заавал суралцах хичээл

Харьцуулсан ба зэрэгцүүлсэн хэлшинжлэл

Харьцуулсан ба зэрэгцүүлсэн хэл зүй хичээлээр харьцуулсан ба зэрэгцүүлсэн хэл шинжлэл гадаад ба монгол хэлний хэл зүйн бүтэц, зохион байгуулалын онцлог тал, хэл зүйн бүрэлдүүлбэрүүдийн үйлдэл, зүй тогтлын ялгааг үг зүй, өгүүлбэр зүй, эхийн түвшинд харьцуулан судлаж, ижил төстэй болон ялгаатай талуудыг тодорхойлох хэл шинжлэлийн судалгааны үндсэн арга зүйг эзэмшүүлнэ.

Харьцуулсан ба зэрэгцүүлсэн уран зохиол

Дэлхийн утга зохиолын хөгжлийн ерөнхий зүй тогтлыг судалж, нэг улсын, нэг үеийн, эсвэл өөр өөр соёлын зохиолчдын бүтээлийг харьцуулан шинжлэх замаар уран зохиолын үзэгдэл, чиг хандлага, сэдэв, дүр, хэв маяг, урсгал, сэтгэлгээний уялдаа холбоо, нөлөөллийг илрүүлэхэд чиглэсэн шинжлэх ухааны арга зүйг эзэмшинэ.

Нийгэм хэлшинжлэл

Нийгмийн хэл шинжлэлийн үүсэл гарал урсгал чиглэлүүд, үндсэн ойлголт категориуд, хэлний хамтлаг, хэл ба угсаатан, хэлний оршин байх хэлбэрүүдийн талаарх мэдлэгийг эзэмших

Сонгон суралцах хичээл

Үгийн сан, утга судлал

Үгийн сан, утга судлалын үндсэн ойлголт категори, судалгааны арга, агуулгын бүрэлдэхүүн хэсгүүд, үгийн сан-утга судлалын хамаарлын талаар мэдлэг эзэмшинэ.

Олон хэлний хэв шинжийн судалгаа

Олон хэлний типолог судлалын онол, арга зүй, үндсэн ойлголтууд, хэв шинжийн ангиллуудын талаар үндсэн ойлголт мэдлэг эзэмшинэ.

Хэл-соёл судлал

Хэлний соёл судлалын онол арга зүйн, гол судлагдахуун, хэлний соёл судлалын үндсэн ойлголтуудын талаар мэдлэг эзэмшинэ.

Хэлний боловсрол

Хэлний боловсролын үндсэн чиглэлүүд,эх хэл ба гадаад хэлний боловсрол олгож байгаа өнөөгийн байдал, орчин үеийн хэл заах арга зүйн чиг хандлагын өөрчлөлт, үзэл баримтлал,хэл шинжлэлийн тулгамдсан асуудал, хэл суралцаж буй өнөөгийн нөхцөл байдлын талаарх ойлголтыг эзэмшүүлнэ.

Уран зохиолын судлал шүүмжлэл

“Уран зохиолын судлал шүүмж” хичээлээр утга зохиолын тогтолцоо, хэв маяг, түүний уламжлал, шинэчлэлийн асуудлууд, утга зохиолыг туурвих ёс, монгол уран зохиолын судлал шүүмжлэлийн тогтолцоог судалж, энэ талаар үзэл баримтлалаа дэвшүүлсэн эрдэмтдийн судалгаа, онол, арга зүйн үндэслэлүүд, дэлхийн уран зохиол судлал, шүүмжийн орчин үеийн чиг хандлагын талаар гүн мэдлэг, уран зохиолын бүтээлийг задлах, шинжлэх, шүүмжлэх ур чадвар, арга зүй эзэмшинэ.

Аман ба бичгийн зохиолын харилцаа холбоо

“Аман ба бичгийн зохиолын харилцаа холбоо” хичээлээр аман зохиолын мөн чанар, түүний бүтэж бий болдог ёс, аман зохиолын уугуул онцлог, хэв маяг, бичгийн зохиолоос ялгарах ялгаа, бичгийн зохиолын мөн чанар, тогтолцоо, онцлог, хэв маяг, бичгийн зохиол дахь аман зохиолын элементүүд, уламжлал, шинэчлэлийн асуудлууд, аман ба бичгийн зохиолын талаар үзэл баримтлалаа дэвшүүлсэн эрдэмтдийн судалгаа, онол, арга зүйн үндэслэлүүдийн талаар гүн мэдлэг, аман зохиолтой холбоо бүхий бичгийн зохиолыг задлах шинжлэх ур чадвар, арга зүй эзэмшинэ.

Монгол оюутныг JLPT-д бэлтгэх арга зүй

Япон хэлний ТТШ-д бэлтгэх сургалтын арга зүй,олон улсын туршлагатай танилцсаны үндсэн дээр,сүүлийн жилүүдийн монгол суралцагсдын япон хэлний ТТШ-ын дүнд анализ хийж,бэлтгэх арга зүйг боловсронгуй болгох зөвлөмж бэлтгэнэ.

Япон хэлний хэлзүй заах аргын онцлог

Япон ,монгол хэлний хэлзүйн нийтлэг ба ялгаатай талыг харьцуулан судалсан судалгааны бүтээлүүдтэй танилцаж,хэлзүй заах аргын тулгамдсан асуудлуудтай холбон авч үзсэний үндсэн дээр зөвлөмж бэлтгэнэ.

Япон хэлээр уран илтгэх чадварт сургах онцлог

日本語スピーチ・япон хэлээр уран илтгэхүйн онцлогтой танилцуулан,уран илтгэх чадварыг дээшлүүлэх сургалт,заах арга зүйн онцлогийг бусад хэлнийхтэй харьцуулан судалж,монгол суралцагсдын уран илтгэхүйн чадварыг дээшлүүлэх боломжийг судална.